

Агуулга



Танилцуулга

- 04 Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ
- 05 Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- 08 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
- 10 Удирдлагын баг бүтэц
- 14 Бидний тухай
- 15 Дэлхийн жишиг Монголын банк
- 16 Үсрэнгүй хөгжлийн он жилүүд



Удирдлагын байр суурь

- 18 Тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах нь
- 20 Харилцагчдад зориулсан дижитал шийдэл
- 22 Тасралтгүй суралцаж хөгжих нь
- 24 2025 оны онцлох хөтөлбөр, арга хэмжээ
- 26 Нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулах нь
- 28 Ерөнхийлөгч
- 29 Эрсдэл хариуцсан захирал
- 32 Мэдээллийн технологи хариуцсан захирал



Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, тогтвортой хөгжил

- 35 Засаглалын тайлан
- 51 Дотоод аудит
- 52 Эрсдэлийн удирдлага
- 64 Тогтвортой хөгжил
- 66 Бизнесийн үйл ажиллагаа



Санхүүгийн үзүүлэлт болон бусад тайлан

- 76 Голомт банкны санхүүгийн үр дүн
- 80 Голомт банкны санхүүгийн 5 жилийн үзүүлэлт
- 81 Хараат бус аудиторын тайлан

Эдийн засгийн тойм

- 238 Дэлхийн эдийн засгийн тойм
- 239 Монгол Улсын эдийн засгийн тойм
- 245 Банкны салбарын тойм

Хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээлэл

- 253 Хувьцааны ханш
- 253 Ногдол ашгийн мэдээлэл
- 254 Хөрөнгө оруулагчдын календарь

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түншүүд болон хамтран ажиллагсад аа,

Зах зээлийн нийгэм анхлан төлөвшиж байсан тэртээ 1995 оны эхээр Монгол Улсын үндэсний хөрөнгө оруулалттай анхны хувийн арилжааны банк болж үүсгэн байгуулагдсан Голомт банкны 30 жилийн ой 2025 онд тохиолоо. Цаг хугацааны шалгуурыг амжилттай гэтлэн эрхэм хөрөнгө оруулагчид, түншүүд болон харилцагчдын итгэлээр бид Голомт банкны хөгжилд хөтөлсөн гурван арваныхаа түүхийг амжилт дүүрэн үдсэндээ баяртай байна.

30 жилийнхээ ойн босгон дээр 2024 онд Голомт банк эдийн засгийн боломж, нөхцөл байдлыг харгалзан огцом тэлэлт хийх стратегийг баримтлан ажиллаж, зээлийн багцыг 54.3 хувиар нэмэгдүүлсэн. Харин 2025 оны хувьд тэнцвэртэй, тогтвортой өсөлтийн горимд эргэн шилжиж, зээлийн багцын өсөлт 11 хувьд хүрэв. Голомт банкиг удирддаг бидний зарчим болох зохистой засаглалын тогтолцоог тогтмол сайжруулан хадгалах үндсэн баримтлалаа бид энэхүү тэлэлтийн үеэр бататган ажилласан. Тиймээс Голомт банк 2025 онд санхүүгийн үзүүлэлтүүдийн сайн чанарыг тогтвортой хадгалж чадлаа. Тухайлбал, Голомт банкны актив 23 хувиар өсөж, өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 23.8 хувийн үр дүнтэй гарсан ба чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт 2.5 хувийн түүхэн доод хэмжээнд хүрсэн нь хөрөнгийн үр ашигтай удирдлага болон санхүүгийн чадавхын илэрхийлэл мөн билээ. Чанаргүй зээлийг хамгийн бага хэмжээнд хадгалж чадсан нь банкны зохистой засаглал, зээлийн үйл ажиллагааны сахилга бат болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдлыг илтгэж байгаад ТУЗ-ийн зүгээс энэхүү амжилтад бахархалтай байна.

Хувьцаат компанийн хэлбэрт шилжсэнээс хойш Голомт банкны зүгээс хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нартаа санхүүгийн өгөөжийг тогтвортой байлгах үүднээс ашигт ажиллагааг өндөр түвшинд хадгалж, түүнээс боломжит хэмжээгээр тогтмол ногдол ашиг хуваарилахыг эрмэлзэн ажиллаж ирлээ. Тийм ч учраас 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараах хувь хэмжээг аль болох бууруулахгүйгээр боломжит хэмжээнд олгох шийдвэрийг гаргаад байгаа билээ. Энэхүү шийдвэр нь Банкны тогтвортой өсөлтийн стратегийг хадгалж, хувьцаа эзэмшигчдэдээ өгөөж хүртээхийн сацуу ирээдүйн тэлэлтийг дэмжих санхүүгийн чадавхаа хадгалж үлдэхэд тулгуурласан болно.

ТУЗ-ийн үйл ажиллагааны хувьд бид бизнес, төсөв төлөвлөгөөний хэрэгжилтэд хатуу хяналтыг тавьж, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоонд тогтмол анхаарал хандуулдаг. Монгол Улсын хууль, зохицуулагч байгууллагуудын журмыг чандлан мөрдөхөөс гадна олон улсын шилдэг туршлага стандартуудыг банкны бүхий л үйл ажиллагаанд мөрдүүлэх үйл хэрэгт манлайллыг үзүүлсэн. ТУЗ нь хороодынхоо үйл ажиллагаагаар дамжуулан гүйцэтгэх удирдлагад олгосон эрсдэлийн хэмжүүрүүдийг мөрдүүлж, зээлийн чанар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадвар болон үйл ажиллагааны зохистой байдалд онцгойлон анхаарч ажиллалаа.



Бизнес стратегийн хувьд Голомт банк нь технологид суурилсан бүтээмж дээшлүүлэх, бичил, жижиг, дунд бизнесүүдийн сегментээ нэмэх болон автоматжуулалтаар үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх байр суурьтай ажиллаж байна. Үүний зэрэгцээ байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) зарчмуудыг банкны стратеги болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд нэгтгэн тогтвортой санхүүжилт, ил тод байдал, нийгмийн хариуцлагатай холбоотой бүхий л үйл ажиллагаанд ахиц дэвшил гаргаж, дэлхийн жишигтэй эн зэрэгцэж байна. Макро эдийн засгийн тодорхойгүй байдал үргэлжилж байгаа ч Голомт банк нь стратегийн чиг баримтлал болон засаглалын өндөр түвшний стандартыг тогтвортой хадгалж, цаашлаад олон улсын хөрөнгийн зах зээлд гарах нөхцөлөө бэхжүүлээд байна.

Голомт банкны амжилтад нийт ажилтан, хамт олноос гадна бүх харилцагчид, бидэнд итгэл хүлээлгэсэн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, түншүүдийн оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлэн талархаж буйгаа ТУЗ-ийн өмнөөс илэрхийлье.

Ч.Мөнхцэцэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Эрхэм хүндэт харилцагчид, хамтрагч байгууллагууд, хувьцаа эзэмшигчид ээ,

Улирч буй нэг жилийн хугацааг эргэн харахад Голомт банк тогтвортой хөгжил, тууштай ахиц дэвшлээ хадгалж, тасралтгүй урагшилж ирсэнд миний хувьд чин сэтгэлээсээ бахархаж байна. Монгол Улсын хөгжлийн голомт эрхэм зорилгыг тээсэн Голомт банкны маань 30 жилийн ой 2025 онд тохиосон нь бидний арвин түүх, хуримтлуулсан туршлагыг бататгаад зогсохгүй өнгөрсөн хугацаанд туулсан сорилтуудыг даван гарч, тогтвортой байдлыг хадгалан ажилласны илэрхийлэл болсон онцгой ач холбогдолтой жил байлаа.

Энэхүү тайлангаар дамжуулан Голомт банкны үйл ажиллагаа, стратегийн тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд төдийгүй гарсан ахиц, дэвшлийн талаар ил тод, нээлттэй мэдээлэл хүргэхийг зорьж байна.

Бид олон улсын жишиг, стандартад нийцсэн банк болон хөгжих замналаа тууштай үргэлжлүүлж, Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих тогтвортой, инновацад суурилсан, олон улсын зах зээлтэй холбогдсон санхүүгийн байгууллагыг цогцлоон бүтээж байна.

Олон улсын хөрөнгийн зах зээл дэх байр суурь болон хөрөнгө оруулагчдын бааз сууриа бэхжүүлсэн нь

Хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудтай итгэлцлийг бий болгох нь Голомт банкны хувьд чухал үнэт зүйл байдаг бөгөөд бидний урт хугацааны амжилт нь ил тод, тогтвортой, нээлттэй харилцаанд тулгуурладаг гэдэгт би итгэдэг. Өнгөрсөн хугацаанд бид энэхүү суурийг улам бататгах хүрээнд хөрөнгө оруулагчидтай харилцах чиг үүргээ олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн сайжрууллаа. Үүний хүрээнд хүртээмжтэй, цаг тухайд нь, чанартай мэдээлэл түгээж, “Хөрөнгө оруулагчдын календарь”, “Earnings call”, “Удирдлагын хэлэлцүүлэг ба шинжилгээ”, “Гүйцэтгэх захирлын захидал” зэрэг хөрөнгө оруулагчдад зориулсан цогц тайлан, арга хэмжээнүүдээр дамжуулан банкны гүйцэтгэл, засаглал, стратегийн чиглэлийн талаар ил тод мэдээлэл хүргэхийг зорин ажилласан.

Энэ хүрээнд мөн олон улсын хөрөнгө оруулагчидтай харилцаагаа улам гүнзгийрүүлж, Сингапур, Нью Йорк, Лондон, Хонгконг зэрэг тэргүүлэх санхүүгийн төвүүдэд өндөр түвшний хөрөнгө оруулагчдын арга хэмжээг хамтран зохион байгууллаа. Эдгээр уулзалт, хэлэлцүүлгүүд нь институцийн хөрөнгө оруулагчид, шинжээчид, стратегийн түншүүдэд Голомт банкны алсын хараа, өсөлтийн стратеги, урт хугацааны зорилгоос гадна Монгол Улсын эдийн засгийн өргөн хүрээний чиг хандлагыг удирдлагын түвшинд шууд хүргэх боломжийг олгосон. Үүний зэрэгцээ удирдлагын баг нь хөрөнгө оруулагчидтай биет уулзалтуудыг тогтмол зохион байгуулж, харилцааг бэхжүүлэн банкны засаглал, удирдлагын чадварт итгэх итгэлийг улам бэхжүүлээ. Үр дүнд нь бид одоогийн хөрөнгө оруулагчидтай итгэлцлээ нэмэгдүүлэхийн зэрэгцээ олон улсын шинэ оролцогчдыг татан оролцуулж, хөрөнгө оруулагчдын баазаа өргөжүүлэн төрөлжүүлж, жижиг хувьцаа эзэмшигчид ч ил тод, хүртээмжтэй харилцаанаас үр өгөөж хүртэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Энэхүү өсөн нэмэгдэж буй итгэлцэлд тулгуурлан Голомт банк олон улсын хөрөнгийн зах зээл дэх Монгол Улсын оролцоог цаашид бэхжүүлээ. 2024 оны олон улсын жишиг бондыг амжилттай гаргасны үргэлжлэл болгон бид 2025 онд урт хугацааны санхүүжилтийн стратеги болон олон улсын байр суурийг шинэ түвшинд гаргаж, хоёр чухал амжилтад хүрсэн.



Эхний амжилт нь Люксембургийн хөрөнгийн биржид ногоон болон нийгмийн бонд амжилттай гаргасан явдал байлаа. Энэ нь Люксембургийн хөрөнгийн биржид бүртгэгдсэн анхны Монгол үнэт цаас болсон онцгой үйл явдал юм. 5 жилийн хугацаатай, 8 хувийн купонтой энэхүү бонд нь тогтвортой хөгжил, хариуцлагатай санхүүжилтийг дэмжих Голомт банкны тууштай байр суурийг олон улсын зах зээлээс өндөр үнэлж буйг илтгэсэн билээ. Санхүүжилтийн эх үүсвэрээ олон улсад өргөжүүлэхээс гадна тус бонд нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжиж, байгаль орчин, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх төслүүдэд хөрөнгө татан төвлөрүүлэхэд Голомт банкны гүйцэтгэх үүргийг улам бататгасан юм.

Хоёр дахь түүхэн амжилт нь Япон улсад Монголын хувийн хэвшлийн анхны Самурай бондыг амжилттай гаргасан явдал байлаа. 15 тэрбум иен буюу 100 сая ам.долларын хэмжээтэй, 3 жилийн хугацаатай, 1.85 хувийн өрсөлдөхүйц хүүтэй уг бондод Японы 30 гаруй институцийн хөрөнгө оруулагчид оролцсон нь Голомт банкны зээлийн чанар төдийгүй Монголын санхүүгийн салбарт олон улсын туршлагатай хөрөнгө оруулагчид итгэлтэй хандаж байгаагийн бодит илрэл байлаа. Голомт банк үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойтой зэрэгцэн гаргасан тус бондын төслийг бид Япон хэлээр “30” гэсэн утгатай “Project Sanju” хэмээн нэрлэсэн. Энэхүү түүхэн үйл явдал нь Монголын хувийн хэвшлийн санхүүгийн байгууллагын хувьд анхдагч амжилт болж, Голомт банкны 30 жилийн турш Монгол Улсын санхүүгийн систем бүтээлцсэн бодит хувь нэмрийг тодотгосон юм.

Голомт банк хөгжлийн санхүүгийн тэргүүлэх байгууллагуудтай хамтын ажиллагаагаа улам гүнзгийрүүлээ. Жилийн туршид бид Олон улсын санхүүгийн корпораци (IFC) болон Европын Сэргээн босголт, Хөгжлийн Банктай (EBRD) нягт хамтран ажиллаж, бичил, жижиг бизнесүүд болон ногоон, тогтвортой төслүүдийг Монгол орон даяар дэмжих санхүүжилтийг өргөжүүлээ. Эдгээр хамтын ажиллагаа нь санхүүжилтийн бааз суурийг бэхжүүлэхээс гадна хүртээмжтэй, байгаль орчинд хариуцлагатай эдийн засгийн өсөлтийг дэмжих бидний амлалтыг бататгалаа.

Түүнчлэн Голомт банк нь Азийн хөгжлийн банк (ADB), Олон улсын

санхүүгийн корпораци (IFC), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD) байгууллагуудын Худалдааны санхүүжилтийн хөтөлбөрт нэгдэн түнш банкаар хамтран ажиллаж байна. Энэхүү стратегийн түншлэлийн хүрээнд банк гадаад худалдаа эрхэлдэг харилцагчдадаа илүү уян хатан нөхцөлтэй, өргөн цар хүрээг хамарсан худалдааны санхүүжилтийн шийдлүүдийг санал болгон ажиллах боломж бүрдэж байна.

Эрсдэлийн удирдлага, сахилга батад суурилсан санхүүгийн гүйцэтгэл

2025 оны санхүүгийн үр дүн нь Голомт банкны бизнесийн тогтвортой байдал болон эрсдэлийн удирдлагад баримталж ирсэн урт хугацааны сахилга баттай бодлогын бодит үр дүнг харуулж байна.

Нийт актив өмнөх онтой харьцуулахад 23 хувиар өсөж, 19.2 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь банкны салбарын нийт активын 22.3 хувийг дангаараа бүрдүүлж, Монголын банкны системийн хоёр дахь том банкны байр сууриа бататгалаа. Банкны зээлийн багц 8.3 их наяд төгрөг болж, жилд 11 хувиар өссөн нь эдийн засгийн хөгжлийн хувьд стратегийн ач холбогдолтой хэвээр байгаа жижиг, дунд бизнесийн зээлд тогтвортой анхаарсан бодлогын үр дүн юм.

Эрсдэлийн засаглалын тогтолцоог олон жилийн турш сайжруулж, зээлийн шалгуурыг чангатгасны үр дүнд активын чанар бодитоор сайжирлаа. Чанаргүй зээлийн түвшин 2.5 хувь болж буурсан нь салбартаа хамгийн бага түвшин байсан бол Эрсдэлийн сангийн хүрэлцээ 101.7 хувьд хадгалагдсан нь балансын бат бөх байдлыг илтгэж байна. IFRS стандартын дагуу “Stage 3” зээлийн түвшин 2024 оны 4.4 хувиас 2025 онд 3.28 хувь болж буурч, “Stage 3” зээлийн нийт дүн 20 хувиар багассан нь зээлийн олголтын оновчтой байдал, багцын идэвхтэй удирдлага, өр барагдуулах үр дүнтэй дотоод бүтцийн илрэл юм.

Эдгээр эерэг үзүүлэлт нь ашигт ажиллагаанд тодорхой тусгалаа оллоо. Голомт банк 2025 онд 330.4 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олж, дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 23.8 хувь, активын өгөөж (ROA) 2.3 хувьд хүрэв. Үүний зэрэгцээ зардал, орлогын харьцаа 47.2 хувь байсан нь үйл ажиллагааны үр ашгийг тууштай сайжруулж буйг харуулж байна. Мөн нийт өөрийн хөрөнгө 18 хувиар өсөж 1.7 их наяд төгрөгт хүрснээр банк цаашдын өсөлтийг дэмжих илүү бат бөх капиталын суурьтай боллоо. Иймд Голомт банкны ТУЗ-ийн тогтоолоор 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 80 төгрөг буюу нийт 64,692,584,480 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлээд байна.

Жижиг, дунд бизнесийн банкны тэргүүлэх байр суурийг бэхжүүлж буй нь

2025 онд Голомт банк “Жижиг, дунд бизнесийг дэмжигч банк” уриан дор Монголын эдийн засгийн тулгуур багана болсон бичил, жижиг, дунд бизнесүүдийг дэмжих урт хугацааны

амлалтаа дахин нотоллоо. Илүү гүн, тогтвортой түншлэлийг бий болгоход чиглэсэн энэхүү бодлогын хүрээнд бизнесийн өсөлтийг хурдасгах, санхүүжилтийн хүртээмжийг тэлэх, орон даяарх бизнес эрхлэгчдийг бодитоор дэмжих зорилтот олон санаачилгыг хэрэгжүүлсэн. Үр дүнд нь бичил, жижиг бизнесийн зээлийн багц 26 хувиар өсөж, бизнес эрхлэгчдийн өндөр эрэлт, санхүүгийн хэрэгцээг тууштай хангаж буйг харууллаа. Мөн жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагчдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэр 24.3 хувиар нэмэгдсэн нь Голомт банканд зээлдүүлэгчээс гадна урт хугацааны санхүүгийн түнш хэмээн итгэх итгэл өсөн нэмэгдсэнийг илтгэж байна. Бүтээгдэхүүний бүтцийг сайжруулж, өргөдлийн процессыг хялбарчилж, илүү уян хатан санхүүжилтийн шийдлүүд санал болгосноор бизнесүүд өргөжих, шинэ тоног төхөөрөмж худалдан авах, шинэ боломж эрэлхийлэх нөхцөл бүрдлээ.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих нь хүртээмжтэй өсөлтийн чухал тулгуур хэвээр байна. 2025 онд эмэгтэй удирдлагатай бизнесүүдэд олгосон зээл 28.4 хувиар өссөн нь “Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжигч банк” санаачилгын бодит үр дүнг харуулж байна. Санхүүжилтээс гадна бид ур чадвар дээшлүүлэх сургалт, менторшип, бизнесийн түншлэлийн сүлжээ үүсгэхэд онцгой анхаарч, МҮХАҮТ-тай хамтран “Women Owned” барааны тэмдгийг нэвтрүүлсэн. Өнөөдрийн байдлаар 90 гаруй байгууллага уг тэмдгийг үйл ажиллагаандаа амжилттай ашиглаж байна. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хөгжлийг “SheLeads”, “Mentorship Program” зэрэг санаачилга улам бүр дэмжиж, энтрепренерүүдийг туршлагатай бизнесийн удирдагчидтай холбож байгааг онцлон тэмдэглэе.

Голомт банкны эдгээр санаачилга нь бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, хүртээмжийг тэлэх, Монгол Улсын эдийн засгийн суурийг бат бөх болгох бидний гүнзгий, урт хугацааны амлалтыг илэрхийлж байна.

Дижитал чадавх ба инновацад хийсэн хөрөнгө оруулалт

2025 онд дижитал инновац Голомт банкны стратегийн тэргүүлэх чиглэл хэвээр байж, харилцагчдын тав тух, үйл ажиллагааны үр ашиг, үйлчилгээний чанарыг сайжруулах технологид чиглэсэн хөрөнгө оруулалтуудаа тууштай үргэлжлүүлээ. Бид Google Pay үйлчилгээг Монголын зах зээлд амжилттай нэвтрүүлж, аюулгүй, хялбар, “contactless” төлбөрийн боломжийг харилцагчдадаа бүрдүүлсэн. Мөн SocialPay платформоо ахиулан хөгжүүлж, UnionPay картаар БНХАУ-д WeChat QR-аар төлбөр хийх боломжийг нэвтрүүлснээр хил дамнасан төлбөр тооцооны тав тухыг бодитойгоор сайжрууллаа.

Үүний зэрэгцээ бид банкны салбарын сүлжээгээ орчин үеийн болгох ажлыг эрчимжүүлж, 66 салбарт өөртөө үйлчлэх киоск нэвтрүүлж, уламжлалт 30 төрлийн үйлчилгээг дижитал платформд шилжүүлж, салбарын онлайн бүртгэлийг нэвтрүүлсэн. Эдгээр өөрчлөлт нь харилцагчдын хүлээлгийн хугацааг мэдэгдэхүйц бууруулж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлсэн бодит ахиц боллоо.

Эдгээр санаачилгын зэрэгцээ Голомт банк хиймэл оюун ухаан болон Generative AI-д чиглэсэн стратегийн хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлж, салбарын сүлжээ, дижитал сувгууд болон дотоод үйл ажиллагаандаа дэвшилтэт шийдлүүдийг үе шаттайгаар нэвтрүүлж байна. Бид мобайл банк, SocialPay дижитал хэтэвч зэрэг дижитал сувгуудаар харилцагч бүрд тохирсон AI туслах нэвтрүүлж эхэлсэн бөгөөд уг шийдэл нь хэрэглэгчдэд хувийн санхүүгээ хянах, төсөв болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулах, төлбөрийн нэхэмжлэл ирүүлэх, хүссэн үедээ төлбөр хийх, санхүүгийн боловсролоо дээшлүүлэх боломжийг олгож байна.

Энэхүү экосистемийг AI-д суурилсан контакт төвөөр бэхжүүлсэн бөгөөд чатботоор дамжуулан банкны 30 гаруй төрлийн үйлчилгээ үзүүлэх, харилцагчдын асуултад шуурхай хариу өгөх, “sentiment” шинжилгээг ашиглан харилцагчийн туршлагыг тасралтгүй сайжруулах боломжийг бүрдүүлж байна.

Банк байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан бид инновацад тууштай хандах байр сууриа улам бататган картын багцаа бүрэн шинэчилж, Universe картын цувралыг танилцууллаа. Хязгааргүй орон зай, цаг хугацааг бэлгэдсэн Universe картууд нь санхүүгийн ертөнцийг харилцагчдын гарт атгуулж, хаана ч найдвартай санхүүгийн хамтрагч байх зорилготойгоор бүтээгдсэн. Онцгой дизайнтайгаас гадна SocialPay болон Интернет банкаар дамжуулан банкны салбарт очихгүйгээр гүйлгээний лимит, сунгалт, шилжүүлгийг бие даан удирдах боломжийг олгосон нь хэрэглэгч төвтэй шинэчлэл юм. Дотоод болон олон улсын хэрэглээнд тохирсон, аюулгүй байдал, найдвартай байдлын дээд стандартыг хангасан Universe картууд нь дэлхийн картын чиг хандлагад нийцсэн, харилцагч төвтэй шийдлүүдийг нэгтгэсэн бүтээгдэхүүн болж чадлаа.

Эдгээр санаачилга нь технологи, дизайн, инновацыг хослуулан илүү ухаалаг, аюулгүй, харилцагч төвтэй банкны туршлага бий болгох Голомт банкны тууштай зорилтыг илтгэж байна.

Тогтвортой хөгжил ба хариуцлагатай банк

Голомт банкны хувьд нийгмийн хариуцлага, тогтвортой үнэ цэнэ бий болгох нь урт хугацааны стратегийн салшгүй хэсэг юм. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд бид хариуцлагатай банкны зарчим, хүртээмжтэй өсөлт, хамт олны сайн сайхныг дэмжих нийгэм, байгаль орчны олон талт санаачилгуудыг тууштай хэрэгжүүллээ.

Улсын “Усны элч” байгууллагын хувиар бид төр, олон нийтийн байгууллагуудтай хамтран “Бумбатын хөв цөөрөм” байгуулах төслийг эхлүүлсэн. Энэхүү төслийн хүрээнд 16.9 мянган м³ багтаамжтай ус хуримтлуулах сан байгуулах бөгөөд Улаанбаатар хотын усны нөөцийг нэмэгдүүлэх, үерийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг сайжруулахын зэрэгцээ хөрс хамгаалалт, ногоон дэд бүтцийг дэмжих чухал ач холбогдолтой. Төслийн үр дүнд 3,191 өрх буюу 9,810 орчим иргэн үерийн болзошгүй эрсдэлээс хамгаалагдах бөгөөд агаарын чийгшил нэмэгдэж, тоосжилт буурснаар байгаль орчин, нийгмийн эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлэх юм. Байгаль орчны дэд бүтэц төдийгүй иргэдэд нээлттэй ногоон байгууламж бүхий олон нийтийн парк байгуулагдах нь тогтвортой, хүртээмжтэй хотын хөгжлийг дэмжих зорилготой.

Манай байгаль орчны төлөөх амлалт нийслэлчүүдийн тулгамдсан асуудал болох агаарын бохирдлыг бууруулах төслөөр дамжин айл өрхүүдэд шууд хүрч байна. Тодруулбал, агаарын бохирдол ихтэй бүсийн гэр хорооллын 300 айл өрхийн нүүрсний хэрэглээг бүрэн халж, “Есо Heat Pump” буюу эрчим хүчний хэмнэлттэй дулааны насосны шийдэлд шилжүүлэх уг төсөл нь жилд 840 тонн нүүрсний хэрэглээг бууруулж, 2,100 тонн нүүрстөрөгчийн хийн ялгаралтыг багасгах (95,000 орчим мод тарихтай тэнцэх) ач холбогдолтой. Байгаль орчноос гадна айл өрхүүдийн аюулгүй байдал, амьдрах нөхцөл, амьдралын чанарыг бодитоор сайжруулж буй нь тогтвортой санхүүжилтийн үнэ цэнийг илэрхийлж байна.

Нийгмийн хүртээмж нь бидний хариуцлагын бодлогын гол тулгуур хэвээр байна. Үүний хүрээнд бид “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш хүртээмж итгэл” ТББ-тай стратегийн түншлэл байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санхүүгийн боловсрол, бизнесийн

боломж, хүртээмжтэй санхүүгийн шийдлүүдийг өргөжүүлэхэд хамтран ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагаа нь анхны “Итгэлийн од” шагнал хүртээсэн нь бүх иргэнд тэгш, шударга үйлчилгээ үзүүлэх санхүүгийн системийг бий болгох бидний зорилтыг бэхжүүлээ. Мөн Монголын Тусгай Олимпын хороо, Улаанбаатар Ротари клубтэй хамтран “Боломжийг бүгдэд” төслийн дараагийн үе шатыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байна.

Мөн бид “AI Academy Asia”-г дэмжин 2025–2030 оны хооронд хэрэгжих урт хугацааны санаачилгаар дамжуулан ирээдүйд бэлэн боловсрол, хүний нөөцийн хөгжилд хөрөнгө оруулж байна. Таван жилийн хугацаанд хиймэл оюуны 2,500 мэргэжилтэн бэлтгэх зорилготой уг хөтөлбөрт улс даяар 3,998 өргөдөл гаргаснаас 500 багш сонгогдон гурван сарын эрчимжүүлсэн сургалтад хамрагдлаа. Голомт банк уг санаачилгыг бүрэн дэмжиж, технологийн мэдлэгээс гадна санхүүгийн боловсролтой болгохыг зорьж байна. Энэ хөтөлбөрөөр дамжуулан орон нутаг, нийслэлийн 10,000 гаруй сурагч хиймэл оюунтай танилцаж, технологид суурилсан эдийн засагт бэлтгэгдэх юм.

Залуу үе бол Монголын ирээдүй гэдэгт бид итгэдэг. Голомт банкны “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийн хүрээнд улсын хэмжээнд шилдэг 100 оюутныг тэтгэлгээр дэмжлээ. Энэхүү 21 жилийн түүхтэй хөтөлбөрөөр нийт 2,000 оюутанд 1.5 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон билээ.

Залуучуудын хөгжил, эрүүл нийгмийг дэмжих хүрээнд Монголын Волейболын Холбоотой “Алтан түнш”-ээр хамтран ажиллаж, багийн ажиллагаа, сахилга бат, тэсвэр хатуужил, манлайллын үнэт зүйлсийг спортын салбараар дамжуулан түгээн дэлгэрүүлэх ажлыг эхлүүлээ.

Эдгээр санаачилга нь сайн засаглал, үйл ажиллагааны өндөр гүйцэтгэл, хүн төвтэй соёлыг улам тодотгож, Голомт банк нь “Шилдэг ToC банк” шагналыг үндэсний зохицуулагч байгууллагууд болон Монголын Тогтвортой Санхүүгийн Холбооноос хүртсэн нь тогтвортой санхүүгийн тогтолцоог хөгжүүлэхэд манлайлан оролцож буйг баталж байна. Үүнийг Голомт банкны дөрвөн жил дараалан авсан “Great Place to Work”-ийн батламж болон олон улсын үнэлгээнүүд бататгаж байна.

Санхүүгийн салбарын хөрөнгө оруулалтаас гадна бид “Өв соёлын голомт” төслийн хүрээнд Монголын ШУА-ийн Археологийн хүрээлэн, Гандантагчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэнтэй хамтран 2022 оноос хойш археологийн судалгаа явуулж, түүх, шинжлэх ухаанд үнэ цэнтэй 3,000 гаруй олдворыг Монголчуудад танин мэдүүлэх боломжийг бүрдүүлээд байна.

Мөн “Зүрх мартахгүй” төсөлд 2020 оноос хойш хамтран ажиллаж, хүүхдийн эрүүл мэндийн төлөөх санхүүгийн дэмжлэг үзүүлээд байгаа нь нийгэмд чиглэсэн оролцооны илэрхийлэл юм.

Эдгээр бүх санаачилга нь Голомт банк урт хугацааны байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үнэ цэнийг бий болгох, итгэлцлийг бэхжүүлэх, хамт олныг чадавхжуулах, Монгол Улсын тогтвортой хөгжилд бодит хувь нэмэр оруулах тууштай байдлыг харуулж байна.

Бидний хүчин чармайлтад үнэтэй хувь нэмрээ оруулж буй эрхэм харилцагчид, хувьцаа эзэмшигчид, түншүүд, ТУЗ-ийн гишүүд болон хамтрагч нартаа талархал илэрхийлье.

Голомт банк цаашид тогтвортой хөгжил, тууштай ахиц дэвшлээ хадгалж, тасралтгүй урагшлан банк санхүүгийн салбартаа тэргүүлэгч нь байж, нээлттэй, ил тод байдлаа бэхжүүлэн ажиллах болно.

А.Одонбаатар

Гүйцэтгэх захирал


Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



Ч.Мөнхцэцэг
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Ж.Үнэнбат
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Д.Мөнхтөр
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн



О.Ганжолоо
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Жэймс Б. Двайер
Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн

Александр Пикер
Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн



Роберт В. ван Свитен
Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн

Ханс Холзхакер
Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн

Ронил Сүжан
Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн



З.Солонго
Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга


А.Туяа
Дотоод аудитын газрын захирал

Засаглалын тайлан болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 35-р хуудаснаас уншина уу.

Удирдлагын баг



Бүтэц, зохион байгуулалт



Бидний тухай

Голомт банк Монголбанкны Ерөнхийлөгчийн 59 тоот тушаалаар 1995 оны 3-р сарын 6-ны өдөр үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр 436 сая төгрөгийн дүрмийн сантайгаар эхлүүлсэн түүхтэй. Улирч буй 30 жилийн хугацаанд эх орныхоо хөгжлийн голомт байх эрхэм зорилго дор харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлан орчин үеийн, дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн иж бүрэн үйлчилгээг үзүүлж, 2025 оны байдлаар банкны салбарын нийт хөрөнгийн 22.3 хувийг дангаар бүрдүүлэн Монголын банкны системийн хоёр дахь том банк гэсэн байр сууриа бэхжүүлэн ажиллалаа.

Бизнесийн онцлох үзүүлэлт

Нийт актив

19.2 их наяд ₮

Нийт өөрийн хөрөнгө

1.7 их наяд ₮

Нийт зээлийн багц

8.3 их наяд ₮

Цэвэр ашиг

330.4 тэрбум ₮

Харилцагчийн эх үүсвэр

10.8 их наяд ₮

Тогтвортой хөгжлийн онцлох үзүүлэлт

Олгосон ногоон санхүүжилт

270 тэрбум ₮

Тогтвортой, ногоон зээлийн багцын үлдэгдэл


406 тэрбум ₮

Нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн багц

4.9 %

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ

1646



Дэлхийн жишиг МОНГОЛЫН БАНК

Голомт банк Монгол Улсын хөгжлийн голомт байх эрхэм зорилго дор Дэлхийн жишиг Монголын банк байх алсын харааг тээж, сайн сайхныг санхүүжүүлэх замаар улс орны хөгжил, дэвшилд үнэ цэнтэй хувь нэмрийг оруулахыг зорьдог билээ. Тэр дундаа дэлхийн жишигтэй эн зэрэгцэхүйц банк байх алсын хараанд алхам, алхмаар ойртсон үйл явдлууд 2025 онд өрнөж, амжилтаа бататгалаа.



Бид олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа тасралтгүй



өргөжүүлж, тогтвортой хөгжилд чиглэсэн бодлого, үйл ажиллагаагаа тууштай хэрэгжүүлсний үр дүнд

олон улсын хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсээр байна. Энэхүү итгэл нь банкны санхүүгийн тогтвортой байдал, зах зээл дэх нэр хүндийг бататгахын зэрэгцээ урт хугацааны өсөлт, хөгжлийг дэмжих чухал хүчин зүйл болж байна. Голомт банк сүүлийн нэг жил гаруйн хугацаанд олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулагчид, хөрөнгө оруулалтын сангуудаас 1.2 тэрбум ам.долларыг татан төвлөрүүлээ.

Монголын хувийн хэвшлүүдээс анх удаа Япон улсын хөрөнгийн зах зээлд Самурай бондыг гаргав



Голомт банк олон улсын зах зээлээс хөрөнгө оруулалт татах, олон талт хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн тэлэх стратегийн хүрээнд 30 жилийн ойгоо тохиолдуулж, Япон улсын хөрөнгийн зах зээлд 3 жилийн хугацаатай, 30 институцийн хөрөнгө оруулагчдаас 100 сая ам.доллартой тэнцэх Самурай бондыг татан төвлөрүүлээ. Энэхүү бонд нь Монголын хувийн хэвшлүүдээс анхлан гаргасан Самурай бонд бөгөөд тогтмол, бага

хүүтэй гэдгээрээ онцлогтой. Төслөө бид "Project Sanju" гэж нэрлэсэн нь онцлогтой бөгөөд Sanju гэдэг нь Япон хэлээр 30 гэсэн үг билээ. Уг бондыг гаргахад Sumitomo Mitsui Banking Corporation болон SMBC Nikko Securities Inc. андеррайтераар ажиллаж, Японы мэргэжлийн хөрөнгө оруулагч нарт санал болгосон бөгөөд бондын захиалга давж биелснээр амжилттай хаагдсан юм.

Олон улсын банк санхүүгийн салбарын нэр хүнд бүхий Euromoney сэтгүүлээс Голомт банкныг 2025 оны Монгол Улсын "Жижиг, дунд бизнесийг дэмжигч шилдэг банк"-аар өргөмжлөв



Euromoney сэтгүүл Монгол Улсын жижиг, дунд бизнесийн салбарт оруулсан Голомт банкны хувь нэмрийн талаар ийнхүү онцоллоо.

"Голомт банкнаас хэрэгжүүлж буй жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр, сургалтууд тэр дундаа бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих, чадавхжуулах, бизнесийн үйл ажиллагааг нь дараагийн шатанд

гаргахад санхүүгийн дэмжлэг үзүүлж буй хүчин чармайлт нь бусдаас илт давуу байсан.

Эдгээр нь Голомт банкны жижиг, дунд бизнесийн салбарыг стратегийн түвшинд дэмжих бодлогын үр шим, нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөллийг нь бататгаж, салбартаа Монголын жижиг, дунд бизнесүүдийн хувьд найдвартай түнш болохыг баталж буй юм."

Үсрэнгүй хөгжлийн он жилүүд

Харилцагч төвтэй бодлого, өгөгдөл болон технологид суурилсан тогтолцооны үр дүнд Голомт банк 2025 онд нийт хөрөнгөө 23 хувиар өсгөн 19.2 их наяд төгрөгт хүргэж, салбарын нийт хөрөнгийн 22.3 хувийг дангаар бүрдүүлж байна.

Зах зээлд эзлэх байр суурь

	2021	2022	2023	2024	2025
Нийт хөрөнгө	19.1%	19.4%	20.1%	21.6%	22.3%
Нийт зээл	16.1%	17.3%	17.5%	20.1%	18.8%
Нийт харилцагчдаас татсан эх үүсвэр	18.5%	18.4%	20.0%	20.1%	20.6%



(тэрбум төгрөг)

Хувьцаа	2024	2025
Нэгж хувьцааны үнэ	1,242₮	1,332₮
Хувьцааны тоо	808,657,306	808,657,306
Зах зээлийн үнэлгээ	1,004,352,374,052₮	1,077,131,531,592₮
Үнэ ашгийн харьцаа	2.40	3.26

Алтны арилжаа

2025 онд тушаасан нийт алтны хэмжээгээр Голомт банк алтны зах зээлд дэх өөрийн тэргүүлэгч байр сууриа хадгалж чадлаа. Мөн харилцагчдын хөрөнгө оруулалтын сонголтыг нэмэгдүүлэхээр "Биет бус алтны арилжаа"-г нэвтрүүлсэн бөгөөд харилцагчид хүссэн үедээ биет бус алтыг өөрийн нэр дээр эзэмших, хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэн, шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэв.

Алтны зах зээлд эзлэх хувь

2024 45%
2025 48%

Шагнал



Best Bank for SMES
Euromoney



Great Place to Work
Great Place to Work Institute

Олон улсын шагнал



Frontier Markets Deal

Голомт банкны олон улсын зах зээлд гаргасан 300 сая ам.долларын бонд "IFR Asia Awards 2024" арга хэмжээний оны шилдгүүдийн нэгээр тодорч, "Frontier Markets Deal"-ээр өргөмжлөгдлөө. Энэхүү шагналыг "International Financing Review Asia" сэтгүүлээс жил бүр Азийн бүс нутагт амжилттай хэрэгжсэн хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлцлүүдэд олгодог бөгөөд Голомт банк ийнхүү олон улсын томоохон банкуудтай эн зэрэгцлээ.




Монгол Улс дахь Шилдэг түнш банк
Азийн Хөгжлийн Банк




STP Award 2024
The Bank of New York Mellon (BNY)


Дотоодын шагнал




Шилдэг ТоС банк



ТоС Манлай банк



Усны элч банк



Итгэлийн од

Тогтвортой хөгжилд ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ НЬ

Хариуцлагатай банкны зарчмуудын стратегийн түвшний хүрээнд тогтвортой хөгжил, нийгмийн сайн сайхны төлөө, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тасралтгүй хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



1 Олон улсын санхүүгийн корпорацаас Монгол Улсад анхны "Цэнхэр" санхүүжилт, хөрөнгө оруулалтыг татав

Олон улсын санхүүгийн корпорацаас Голомт банканд олгож буй 160 сая ам.долларын санхүүжилт нь Монгол Улсын эрүүл, аюулгүй усны хүртээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжихээс гадна жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжихэд чиглэгдэнэ. Энэхүү санхүүжилт нь ОУСК-аас Монгол Улсын санхүүгийн салбарт олгосон анхны "Цэнхэр" хөрөнгө оруулалт гэдгээрээ онцлогтой бөгөөд өндөр ач холбогдолтой түншлэл юм.

Олон улсын бизнес, хамтын ажиллагааны тухай 70-р хуудаснаас уншина уу.

2 Нийгмийн болон ногоон бондыг Льюксембургийн хөрөнгийн бирж дээр гаргав

Голомт банк 2025 оны 1-р сард олон улсын зах зээлд 5 жилийн хугацаатай, 50 сая ам.долларын ногоон болон нийгмийн чиглэлийн бондыг жилийн 8 хувийн хүүтэйгээр амжилттай гаргасан. Энэхүү бонд нь Монгол Улсын корпоратив бондуудаас олон улсын зах зээлд гарсан хамгийн хямд хүүтэй, мөн сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй төслүүдийг санхүүжүүлэх бонд гэдгээрээ онцлогтой юм. Бондын эх үүсвэрийг Монгол Улсад хэрэгжиж буй ногоон дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүч, байгаль орчны тогтвортой шийдлүүдийг санхүүжүүлэхэд бүрэн зарцуулав.

3 Виртуал картаар дамжуулан нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулав

Тайлант хугацаанд Голомт банк дигитал шийдэлдээ тулгуурлан 206,196 ширхэг виртуал картыг зах зээлд гаргалаа. Ингэснээр 3.4 тэрбум төгрөгийн пластик материалын зардал хэмнэсэн төдийгүй 36.57 тонн карбон имиссион буюу нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулж, банкны тогтвортой хөгжлийн зорилтыг бататгалаа.

4 Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулж байна

Голомт банк "Тогтвортой хөгжлийн бодлого"-ынхоо хүрээнд нийслэл хотын томоохон асуудал болох агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран ажиллалаа. Төслийн хүрээнд тус дүүргийн агаарын бохирдлын түвшин өндөртэй бүсийн 300 өрхөд "Air to air heat pump" буюу дулааны насос төхөөрөмжийг суурилуулахад шаардлагатай санхүүжилтийг Голомт банкнаас шийдвэрлэж, агаарын бохирдлыг бууруулахад бодит хувь нэмрээ оруулав.

5 Санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг PCAF аргачлалын дагуу тооцоолж байна

Монгол Улсын Үндэсний Зорилтот Хувь Нэмэр баримт бичигтэй уялдуулан Голомт банк өөрийн болон санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг 2030 онд 30 хувиар, 2050 онд 50 хувиар бууруулах томоохон зорилттойгоор ажилладаг. Үүний хүрээнд, Олон Улсын Нүүрстөрөгчийн Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл (PCAF)-ийн гишүүнээр 2023 онд нэгдсэнээр санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлаа PCAF аргачлалын дагуу тооцоолон тайлагнаж байна.

6 Ногоон зээлийн багцаар дамжуулан 4,477 ажлын байр бий болгов

Тайлант хугацаанд Голомт банк нийт ногоон зээлийн багцаар дамжуулан 4,477 ажлын байрыг бий болголоо. Ингэснээр 205 тэрбум төгрөгийн нэмүү өртгийг хадгаламж, татвар болон цалин хэлбэрээр бий болгож, тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмрээ оруулсаар байна. Уг тооцооллыг "Joint Impact Model" \ JIM)-ын хэрэгслийг ашиглан нийгэмд үзүүлж буй нөлөөллийг гаргалаа.

Харилцагчдад зориулсан ДИЖИТАЛ ШИЙДЭЛ

Голомт банк мэдээллийн технологи, инновацад тулгуурлан харилцагчдынхаа цаг хугацаа, зардлыг хэмнэх, сэтгэл ханамжийг нь нэмэгдүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн загварыг Монгол Улсын банкны салбарт анхлан нэвтрүүлдэг. Эдгээр шийдэл нь Монгол Улсын төр болон бизнесийн салбарт ч түлхэц өгч, шилдэг туршлага, жишиг болсоор байна.



1 CIPS буюу олон улсын юанийн төлбөр тооцооны систем

БНХАУ-ын Cross-Border Interbank Payment System буюу олон улсын юанийн төлбөр тооцооны системийг амжилттай нэвтрүүллээ. CIPS нь юанийн гүйлгээний төвлөрсөн клирингийн систем бөгөөд Голомт банк тус системийн шууд оролцогч болсноор дэлхийн аль ч улс руу юанийн гүйлгээг илүү хурдан шилжүүлэх дэд бүтэцтэй болсон юм. Уг системийг нэвтрүүлснээр юанийн төлбөр тооцоо бодит хугацаанд, илүү хялбар, үр ашигтай процессоор хийгдэхээс гадна харилцагчдын гадаад гүйлгээний хурд, зардлын хувьд мэдэгдэхүйц эерэг өөрчлөлтүүдийг авчирч байна.

4 Монголын анхны "wearable" Skate карт

Монголын хамгийн анхны "wearable" карт буюу зайнаас унших технологи бүхий 7-22 насны хүүхэд, залуучуудад зориулсан "Skate" картыг хэрэглээнд нэвтрүүлэв. Skate карт нь банкны картын мэдээллийг суулгасан "skateboard" загвар гэдгээрээ энгийн төлбөрийн картаас ялгаатай бөгөөд NFC технологийг ашиглан бүх төрлийн ПОС төхөөрөмж дээр уншуулж, И-коммерс дээр онлайнаар худалдан авалт хийх боломжтой төлбөрийн хэрэгсэл юм.

2 Universe картын шинэ концепц

Голомт банк 30 жилийн ойгоо тохиолдуулан картын загвараа бүрэн шинэчилж, хил хязгааргүй орон зай, цаг хугацааг илэрхийлэх Universe картуудаа зах зээлд нэвтрүүллээ. Эдгээр карт нь санхүүгийн ертөнцийг харилцагчдын гарт атгуулж, огторгуйн өргөн уудамд эргэлдэгч дагуул адил дэлхийн хаана ч санхүүгийн аяллын хөтөч болж, хил хязгааргүй боломж, дахин давтагдашгүй үнэ цэн, нэр хүндийн баталгааг өгөх болно.

5 Google Pay дижитал хэтэвч

Google Pay дижитал хэтэвчийг Монгол Улсад анхлан нэвтрүүлж, Голомт банкны Мастер карт, Т-брэндийн картаа холбон ашигладаг боллоо. Ингэснээр Android үйлдлийн систем бүхий гар утас, төхөөрөмжтэй харилцагчид дэлхийн хаашаа ч аялж, зорчсон NFC тэмдэглэгээ бүхий худалдаа, үйлчилгээний газарт Google Pay хэтэвчээ ашиглан төлбөрөө хялбар, аюулгүй төлөх боломжтой болов.

3 "World Mastercard" кредит карт

MasterCard, Visa International, American Express, UnionPay International картын схемүүдээс Монгол Улсад гаргасан картуудын хамгийн өндөр зэрэглэл болсон "World Mastercard" зэрэглэлийн кредит картыг 22 граммын метал хийцлэл, дагалдах 26 консерж үйлчилгээтэйгээр нэвтрүүлэв. Эдгээр шийдлийн үр дүнд Голомт банк кредит картын зах зээл болон интернэт худалдааны зах зээлд тэргүүлж, картын борлуулалтын өсөлт 17%, гадаад гүйлгээний өсөлт 25%-д хүрлээ.

6 WeChat Pay

SocialPay дижитал хэтэвчээ ашиглан WeChat QR кодыг уншуулах төлбөрийн шийдлийг нэвтрүүлэв. Ингэснээр Голомт банкны харилцагчид UnionPay картаараа БНХАУ-д төлбөр тооцоогоо саадгүй хийж, нэмэлт шимтгэлгүйгээр бүхий л худалдаа үйлчилгээний газруудад ашиглах боломжтой.




Мэдээллийн технологи болон дижитал шилжилттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг 32-р хуудаснаас уншина уу.


Тасралтгүй суралцаж, хөгжих нь

Голомт банк ажилтан болон ажилтны гэр бүлд ээлтэй бодлогын хүрээнд мэнд оршихуй буюу бие, сэтгэл зүй, санхүүгийн эрүүл мэндийг дэмжих замаар банканд урт хугацаанд, тогтвортой хөдөлмөр эрхлэх боломжоор хангахад чиглэн ажиллаж байна.

Нийт ажилтан



Ажилтны энгэйжмент индекс



АЖИЛТАН ТА ХӨГЖЛИЙН ГОЛОМТ

Ажилтны карьер хөгжил

Эрдмийн зэргээ ахиулсан ажилтнууд

70

Нийт зарлагдсан ажлын байрыг дотоодоосоо бүрдүүлэв

57%

Ажилтны мэнд оршихуй

Сэтгэл зүйн эрүүл мэнд

Ажилтны мэнд оршихуйд чиглэсэн цогц арга барилын нэг хэсэг болох ажилтны сэтгэл зүйн эрүүл мэндийг нэн тэргүүнд тавьж, энэ хүрээнд ажилтнууддаа мэдлэг олгож, дэмжин ажиллаж байна.

Биеийн эрүүл мэнд

Урьдчилан сэргийлэх үзлэг, Эмчийн анхан шатны үзлэг, Эрүүл мэндийн аян, Цус хандивлах аян, Эрүүл мэндийн нэмэлт даатгал.

Санхүүгийн эрүүл мэнд

Голомт банкны "ТУС хуримтлал хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан"-аар дамжуулан ажилтнууддаа урт хугацааны хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэн ажилладаг.

Багийн мэнд оршихуй

Багийн хамтын ажиллагааг сайжруулах арга хэмжээ

120

Хамрагдсан ажилтны тоо

6,700

Багийн хөгжлийн хөтөлбөр

87

Хүн цагийн сургалт

4,090

Гэр бүлд ээлтэй банк

- Голомт банкны 30 жилийн ойн хүрээнд ажилтнуудын гэр бүлд зориулж, "Golomt One Big Family" арга хэмжээг зохион байгуулав.
- Ажилтнуудынхаа 2,500 гаруй хүүхдэд зориулан сурагчдын дадлага, мэргэжил таниулах "Good vibes" хөтөлбөр, санхүүгийн боловсрол, мэдээллийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн сургалтуудыг зохион байгууллаа.
- Жирэмсэн ажилтнуудынхаа ажлын цагийг богиносгох, хүүхдээ хөхүүлэх, асрах цагийг хуулийн дагуу олгох, хүүхдээ асарч буй ээжүүдэд сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэв.



Нийгмийн сайн дурын ажил

Ажилтнуудын тарьсан мод

220+

Цус хандивласан ажилтан

190 570 гаруй хүний амь аврав

Хайраа хуваалцъя аянд оролцсон ажилтан

1,500

G-Volunteer сайн дурын хөтөлбөрт хамруулсан сурагч

440 6 удаагийн сайн дурын ажил

2025 оны онцлох хөтөлбөр, арга хэмжээ

Голомт банк тайлант хугацаанд харилцагчид руу чиглэсэн, харилцагчдынхаа онцлогт тохирсон олон урамшуулалт аян, хөтөлбөрүүдийг өрнүүллээ.

- Голомт банкны 30 жилийн ойн баяр болон “Дэлхийн хуримтлалын өдөр”-ийг тохиолдуулан Голомт банк 12 сарын хугацаатай хадгаламжийн хүүгээ 30%-аар өсгөж, 15,000 гаруй харилцагчийг хамруулаа. Мөн “Хуримтлалтай” гэх нэгдсэн нэршлээр цэрэг, цагдаа, эмч, багш болон цалингийн байгууллагуудад зориулсан сугалаат хөтөлбөрийг амжилттай зохион байгуулав.
- Харилцагчдынхаа хуримтлуулах зуршлыг дэмжиж, ирээдүйдээ зориулан мөнгөө хадгалаад аялах боломжийг олгодог “Хадгаламжтай аялал” сугалаат аяныг 2 дахь жилдээ хэрэгжүүллээ. Аянд 145,442 харилцагч хамрагдсан бөгөөд 3 удаагийн тохирлоор нийт 30 хос азтаныг тодруулж, азийн орнуудаар аялах эрх олголоо.



- Банкны нийт харилцагчаа идэвхжүүлэх, үнэ цэнтэй харилцагчдыг нэмэгдүүлэх Big Loyalty урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Уг хөтөлбөрт 1,015,378 харилцагч хамрагдаж, лоялти оноо, түүнийг дагасан урамшуулалд идэвхтэй хамрагдлаа. Хөтөлбөрийн хүрээнд эхний хагас жилд BYD Sealion 6 автомашины 1 супер азтан, iPhone 16 Pro Max гар утасны 8 азтаныг тус тус шалгаруулав.
- Зах, худалдааны төвийн бизнес эрхлэгчдэд зориулж, Улаанбаатар хотын сонгогдсон зах, худалдааны 19 төвд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж, төлбөр тооцооны шийдлүүдийг санал болгон ажиллалаа. Мөн эдгээр бизнес эрхлэгчдэд зориулсан урамшуулалт аяны хүрээнд 42 харилцагчийг шалгаруулж, гадаадад аялах эрхийн бичгээр урамшуулав.



Хүүхэд, залууст зориулсан хөтөлбөр

- Монгол Улсад шинээр мэндэлж буй эх орны ирээдүй болсон хүүхдүүдэд зориулж, Хадгаламжийн эрхийн бичиг болон гарын бэлэг өгдөг “New born” аяныг 2024.09.16-2025.06.30-ны хугацаанд хэрэгжүүллээ. Аяны хүрээнд орон нутаг болон Улаанбаатар хотод шинээр төрсөн 7,000 хүүхдэд гарын бэлэг тараасан бөгөөд аяны үр дүнд нийт 2,292 хадгаламжийн данстай болов.
- Хүүхдүүдийг бага наснаас нь хуримтлуулах зөв дадалд сургах, хуримтлалын ач тусыг таниулах зорилгоор Голомт банк орон нутаг болон Улаанбаатар хотын 1-р ангид элсэн орж буй нийт 22,000 хүүхдэд 100,000₮-ийн хуримтлалын эрхийн бичиг олгов. Аяны үр дүнд нийт 2,156 хүүхэд “Алтантүлхүүр” хүүхдийн хадгаламжийн данс шинээр нээлгэлээ. 2025 онд “Алтантүлхүүр” хүүхдийн хадгаламжийн бүтээгдэхүүний концепцийг бүрэн шинэчилж, харилцагч нарт олон давуу тал бүхий нөхцөлийг бий болгоод байгаа юм.



- Шинэ үеийн хүүхэд, залуусыг Голомт банкны ирээдүйн харилцагч болгох, банкны үйлчилгээг шинэлэг байдлаар хүргэх GenZ Loyalty урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Тайлант хугацаанд 0-22 насны 270,000 гаруй харилцагч хөтөлбөрт хамрагдаж, 110 харилцагч сугалааны азтан болсон бөгөөд 1 супер азтаныг Хонг Конг руу хосоор нь аялуулж, “Мама Awards 2025” хөгжмийн наадмыг үзэх эрхийн бичгээр урамшуулав.

Иргэдийн зах зээлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 69-р хуудаснаас уншина уу.

Нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулах нь



- Монголын түүх соёлын үл хөдлөх дурсгал, биет өвийн хадгалалт хамгаалалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, соёлын өвийг дэлхийд таниулах археологийн олон төслийг хэрэгжүүлэх, урт хугацаанд дэмжихээр “Өв соёлын голомт” төслийг Голомт банк санаачлан 2022 оноос ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй 4 дэх жилдээ хамтран ажиллаж байна. Төслөөр дамжуулан хувийн хэвшлийн байгууллагуудаас анхлан археологийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд Монголын түүх, шашин, соёлыг судлахад чухал нөлөө, томоохон дэмжлэг үзүүлж байгаа юм. Одоогоор төслийн дэд төсөл болох “Ингэт толгой”-н дурсгалт газрын археологийн судалгааны ажлыг гүнзгийрүүлэн үргэлжлүүлж байгаа бөгөөд энэ нь Монголд төдийгүй олон улсад анхаарал татаж буй түүх, археологийн олдвор болоод байна. Археологийн олдворууд нь Монгол Улсын түүх, өв соёл, зан заншил, шашин шүтлэгтэй салшгүй холбоотой бөгөөд “Өв соёлын голомт” төслийг хэрэгжүүлснээр хойч үедээ үнэн зөв, бодитой мэдээллийг бататган үлдээх, цаашлаад дэлхийд таниулах ач холбогдолтой. Төслийн хүрээнд

хэд хэдэн археологийн олдворт газарт малтлага, судалгааны ажлыг гүйцэтгэж, үр дүнд нь Монголын түүх, шинжлэх ухааны ач холбогдол бүхий 3,000 гаруй олдворуудыг нээн илрүүлээд байна.

- ЕБС-ийн сурагч охид, эмэгтэй багш нарт хиймэл оюуны суурь болон ахисан түвшний мэдлэг, чадварыг олгох зорилгоор 2025 онд AI Academy Asia-тай хамтран ажиллаж, “AI for Women 100x100” хөтөлбөрийг хэрэгжүүлээ. Хөтөлбөрийн хүрээнд мэдээллийн технологийн салбар дахь жендэрийн тэгш оролцоог дэмжих, боловсролын салбарт технологийн дэвшлийг бодитоор нэвтрүүлэх, хөдөө орон нутаг ба нийслэлийн боловсролын ялгааг бууруулах, улмаар ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хиймэл оюуны боловсролыг үе шаттайгаар нэвтрүүлэх эхлэлийг тавьж, ЕБС-ийн тус бүр 100 эмэгтэй сурагч, багшийн оюуны хөрөнгө оруулалт хийлээ.
- Оюутан, залуусын боловсролыг дэмжих, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Голомт банк нийгмийн хариуцлагын хүрээнд бизнесийн салбараас анхлан “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 2003 оноос

санаачлан хэрэгжүүлж байна. Өнгөрсөн хугацаанд 2000 гаруй оюутанд нийт 1.5 тэрбум төгрөгийн сургалтын тэтгэлэг олгоод байна.

- Голомт банк хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, санхүүгийн боловсрол олгох зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш хүртээмж итгэл” ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Хамтын ажиллагааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж, банкны арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүддээ хамруулахаас гадна хөнгөлөлттэй санхүүгийн бүтээгдэхүүн санал болгох юм.
- Голомт банк Монгол Улсад багийн спорт тэр дундаа волейболын спортыг хөгжүүлж, сурталчлахад дэмжлэг үзүүлэхээр Монголын Волейболын Холбоо НҮТББ-ын “Алтан түнш”-ээр хамтран ажиллах урт хугацааны гэрээнд гарын үсэг зурав. Хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад зохион байгуулагдах волейболын Үндэсний дээд лиг, Хөгжлийн лиг, Оюутны лиг, Хүүхдийн лиг болон улсын, олон улсын чанартай бүх төрлийн тэмцээн, үйл ажиллагааг илүү хүртээмжтэй, олон улсын стандартад нийцсэн байдлаар зохион байгуулахад санхүүжилт олгоно.

Мөн хүүхэд, залуучуудын эрүүл зөв дадал, сонирхолд хөрөнгө оруулах, өсөх ирээдүйтэй тамирчдыг дэмжих зорилготой.

- Монгол Улсын Засгийн газар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас 33 дахь жилдээ зохион байгуулсан “Оны онцлох хүүхэд” арга хэмжээнд хамтран ажиллаж, онцгой амжилт гарган үе тэнгийнхнээ манлайлсан шилдэг хүүхдүүдийг “Алтантүлхүүр” хүүхдийн хадгаламжийн эрхээр урамшуулж, хуримтлалтай, санхүүгийн дархлаатай иргэн болон төлөвшихөд нь хувь нэмрээ оруулав.
- Голомт банк хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах үйлт хувь нэмрээ оруулж буй томоохон төсөл нь “Бундан” ТББ-тай хамтран хэрэгжүүлдэг “Зүрх мартаггүй” төсөл юм. 2020 оноос хойш энэхүү төслийн албан ёсны түншээр хамтран ажиллаж байгаа бөгөөд Голомт банкны “Алтантүлхүүр” хүүхдийн сангаар дамжуулан санхүүгийн болон бусад дэмжлэгийг тууштай үзүүлж, өнгөрсөн хугацаанд хугацаанд нийт 540 сая төгрөгийн дэмжлэг олгоод байна.





Ерөнхийлөгч Г.ГАНБОЛД

Улирч буй 2025 онд Голомт банк үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлээ. Энэхүү түүхэн зурвас хугацаа нь Монгол Улсад зах зээлийн эдийн засаг, чөлөөт өрсөлдөөн бий болсны төдийгүй орчин цагийн банк, санхүүгийн систем үүсэн бэхэжсэний салшгүй нэг хэсэг юм. Бид өнгөрсөн 30 жилийн хугацаанд хувийн өмчийн цоо шинэ банкны тогтолцоог бий болгож, эх орныхоо эдийн засгийн бүх салбарт хөрөнгө оруулалт, зээл, санхүүгийн шинэ бүтээгдэхүүнүүдээр бодитой хувь нэмрийг орууллаа.

Голомт банк тайлант хугацаанд дижитал шилжилтийн хүрээнд харилцагчид болон бүртгэл, тооцооны үйл ажиллагаандаа зарим сайжруулалтыг хийлээ. Тухайлбал, харилцагчийн хувийн хэргийг хуулийн шаардлагын дагуу шинэчлэх ажлын хүрээнд “Харилцагчийн хувийн хэргийн аян”-ыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр амжилттай хэрэгжүүлэв. Мөн харилцагчаас авч буй баримт бичгийн давхардлыг бууруулж, программын ашиглалтын үр өгөөжийг сайжруулах чиглэлээр ажиллалаа. Голомт банкны архивын үйл ажиллагааг шинэчлэх, өргөжүүлэх ажлын хүрээнд “Цахим архив” төслийг амжилттай хэрэгжүүлээд байна. Мөн “Иргэний өр зээлгүйн тодорхойлолт”, “Гадаадаас орлого орсныг баталгаажуулах тодорхойлолт”, “Хугацаа хэтэрсэн зээлийн тодорхойлолт” гэх мэт харилцагчийн тодорхойлолтыг автоматжуулсан юм.

“Сайн сайхныг санхүүжүүлнэ” уриатай Голомт банк нь төр засгаас үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн бодлого шийдвэр, төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэгч төдийгүй Монгол Улсад хийгдсэн томоохон бүтээн байгуулалтыг сүндэрлүүлэхэд гар бие оролцож ирсэн бүтээгч хамт олон бөгөөд байгуулагдсан цагаасаа эхлэн улсынхаа эдийн засгийн хөгжлийн түүхийн салшгүй нэг хэсэг нь байсаар ирсэн. Энэ

ч үүднээс орон нутгийн замуудын дэд бүтцийг шинэчлэх, сайжруулах төслүүд, нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд автобус худалдан авах гэх мэтчилэн Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй мега төслүүд болон бусад яамнаас зарласан төслүүдийн тендер, гүйцэтгэл, урьдчилгаа төлбөрийн баталгаанууд дээр ажиллалаа.

2025 онд CIPS буюу олон улсын юанийн төлбөр тооцооны системд шууд оролцогчоор элссэн. Ингэснээр Голомт банк дэлхийн аль ч улс руу юанийн гүйлгээг 24/7 зарчмаар илгээж, гүйлгээний хурд, автомат ажиллагаа, хялбар шийдэл зэрэг олон давуу талыг харилцагчдад бий болгож чадсан юм.

Бид харилцагчийн гадаад төлбөр тооцоог хурдтай, олон улсын стандартад нийцүүлэн хэрэгжүүлж ажилласан ба үүний үр дүнд АНУ-ын тэргүүлэх The Bank of New York Mellon (BNY) банкнаас Голомт банканд “Straight-Through-Processing” (STP) шагнал олгосон. Банк мөн зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх, гадаад төлбөр тооцоог олон сувгаар хурдтай шилжүүлэх, харилцагчийн төлбөр тооцоо хийгдсэн эсэхийг баталгаажуулах, гадаад төлбөр тооцоонд үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор дараах томоохон ажлуудыг олон улсаас тавьсан

шаардлага хугацааны дагуу бүрэн хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

- SWIFT үйлчилгээтэй холбоотой ISO20022 стандартыг анхлан нэвтрүүлэв.
- SWIFT GPI систем;
- SWIFT pre-validation модуль;
- SWIFT Payment control модулийг тус тус амжилттай нэвтрүүллээ.

Нар тусах эхний оргил өөд хамтдаа тэмүүлж буй эрхэм харилцагчид, түншүүд, хувьцаа эзэмшигчид болон хамтрагч нартаа талархал илэрхийлье!

Г.Ганболд
Голомт банкны Ерөнхийлөгч



Эрсдэл хариуцсан захирал Т.ОТГОН

Голомт банк 2025 онд макро эдийн засаг, зах зээл, технологи, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлүүдийн нөлөөлөл нэмэгдэж буй орчинд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүхэлд нь бэхжүүлэхэд анхааран ажиллалаа. Банк нь зээлийн болон зах зээлийн эрсдэлийг урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны эрсдэл, мэдээллийн болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг олон улсын түвшинд хангах, мөн уур амьсгалын эрсдэлийг бусад гол эрсдэлүүдтэй уялдуулан системтэйгээр удирдах чиглэлд бодлого, процесс, системийн түвшинд цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Зээлийн эрсдэлийн удирдлага

2025 онд макро эдийн засгийн орчин тодорхой хэмжээнд тогтвортой байсан хэдий ч инфляц, зээлийн хүүгийн түвшин, өрхийн өрийн дарамт, мөн дэлхийн зах зээлийн тодорхойгүй байдал зэрэг хүчин зүйлс банкны зээлийн багцад тодорхой эрсдэл үүсгэх боломжтой байлаа. Ялангуяа хэрэглээний зээл болон жижиг, дунд бизнесийн сегментэд орлогын тогтворгүй байдал, зардлын өсөлт, зах зээлийн хэлбэлзэл нь зээлдэгчдийн төлбөрийн чадварт нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй нөхцөл байдал бүрдсэн. Ийм эдийн засгийн орчинд Голомт банк зээлийн эрсдэлийн удирдлагыг илүү идэвхтэй, урьдчилан сэргийлэх чиглэлд төвлөрүүлэн ажиллаж, багцын чанар, төрөлжилт, тогтвортой байдлыг хадгалахад анхааран ажиллалаа.

2025 оны жилийн эцсийн байдлаар банкны нийт зээлийн багц 8.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны эцэстэй харьцуулахад 11 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Банк зээлийн багцын өсөлтийг сегментүүдийн хооронд харьцангуй тэнцвэртэй байлгах, төвлөрлийн эрсдэлийг бууруулах зорилгоор багцын бүтэц, салбарын төрөлжилтийг тогтмол хянаж ажилласан.

Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд тогтвортой хэвээр байлаа. Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл нийт зээлийн багцын 2.3 хувийг, чанаргүй зээлийн үлдэгдэл 2.5 хувийг тус тус эзэлж байна.

2025 онд хэрэглээний зээлийн сегментэд онцгой анхаарал хандуулж, зээлийн багцын чанарын нарийвчилсан шинжилгээг тогтмол хийснээр эрсдэл өндөртэй гэж үнэлэгдсэн зарим бүтээгдэхүүний шинэ олголтыг түр хугацаагаар зогсоож, зээлийн шалгуур нөхцөлийг сайжруулсан. Түүнчлэн дижитал цалингийн зээлийн хувьд банкны идэвхтэй харилцагчид олгох бодлогыг нэвтрүүлсэн. Эдгээр арга хэмжээ нь зээлийн чанар муудахаас урьдчилан сэргийлэх, харилцагчийн орлогын бодит урсгалыг илүү найдвартай үнэлэхэд чиглэсэн болно.

Мөн харилцагчийн өрийн дарамтын эрсдэлийг бууруулах зорилгоор өр-орлогын харьцааг 45 хувиас хэтрүүлэхгүй байх дотоод бодлогыг мөрдөн ажилласан нь зохицуулагч байгууллагын шаардлагаас илүү өндөр хяналтын түвшинг хангаж байна. Үүний зэрэгцээ банкны идэвхтэй харилцагчдын зээлийн хүсэлтийг судлах зарчмыг хэрэгжүүлж эхэлсэн.

Зээлийн эрсдэлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тогтолцоог нэвтрүүлсэн. Мөн дижитал скорингийн загварыг сайжруулах, өр цуглуулах үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, зээлийн мэдээллийг бодит цагийн горимоор Монголбанкны зээлийн мэдээллийн санд хүргүүлэх зэрэг систем, процессын сайжруулалтыг үе шаттай хэрэгжүүлж байна.

Энэхүү тайлангийн дараагийн хэсгүүдэд Голомт банкны зээлийн эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, удирдах арга зүй, зээлийн багцын бүтэц болон чанарын үзүүлэлтүүд, зээлийн үйл ажиллагааны дижитал шилжилт, СТОУС-9 стандартын дагуу тайлагнал, мөн зээлийн барьцаа хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагаа зэргийг дэлгэрэнгүй танилцуулж байна.

Цаашид Голомт банк зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам боловсронгуй болгох, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэмэгдүүлэх, эрт сэрэмжлүүлэх механизмыг сайжруулж, автоматжуулах, зээлийн багцын төрөлжилтийг хадгалах замаар зээлийн чанарыг тогтвортой хангаж, санхүүгийн тогтвортой өсөлтийг дэмжих зорилтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно.

Зах зээлийн эрсдэл

2025 онд банк зах зээлийн нөхцөлөөс үүсэх эрсдэлийг үр ашигтай удирдах чиглэлд дэд бүтэц, системийн чадавхаа сайжруулан ажиллав. Энэ хүрээнд өгөгдлийн чанарыг сайжруулсан төдийгүй зах зээлийн эрсдэлийг хэмжих, хянах нэмэлт функцуудыг нэвтрүүлснээр хяналтыг илүү бодитой, шуурхай болгох боломж бүрдсэн.

Тайлант хугацаанд банкны системд хөрвөх чадварын бууралт ажиглагдсан хэдий ч банк нь хөрвөх чадварын эрсдэлийг бодлого, төлөвлөлт, хяналтын хүрээнд идэвхтэй удирдаж, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлснээр үйл ажиллагааны тасралтгүй байдлыг ханган зах зээлийн хүндрэлтэй нөхцөлийг хэвийн даван туулсан.

Мөн гадаад валютын ханш болон зарим түүхий эдийн үнийн хэлбэлзэл нэмэгдсэн орчинд банк валютын нээлттэй позиц, арилжааны болон хөрөнгө оруулалтын багцад тавих хяналтыг тогтмол хэрэгжүүлж, зах зээлийн эрсдэлийг тогтоосон зөвшөөрөгдөх түвшинд удирдан ажилласан. Үүний үр дүнд валютын болон түүхий эдийн үнийн савлагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг хязгаарлаж, банкны санхүүгийн тогтвортой байдалд ноцтой нөлөө үзүүлэхүйц эрсдэл үүсээгүй болно.

Цаашид банк зах зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам боловсронгуй болгож, системд суурилсан хяналт, анализыг өргөжүүлэх, зах зээлийн гэнэтийн өөрчлөлтөд бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах болно.

Үйл ажиллагааны эрсдэл

Засаглал болон эрсдэлийн соёлыг бэхжүүлэх замаар үйл ажиллагааны уян хатан байдлыг нэмэгдүүлэв

Тайлант онд үргэлжилсэн дижитал шилжилт, технологийн хамаарал нэмэгдэж буй байдал, харилцагчдын хүлээлтийн өөрчлөлт, түүнчлэн кибер халдлага, залилан, үйл ажиллагааны тасалдлын эрсдэлийн өсөлт зэрэг нь Голомт Банкны хувьд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг тэргүүлэх чиглэлийн нэг хэвээр байлгалаа. Ийм нөхцөлд Банк хүн, процесс, систем болон гадаад хүчин зүйлсээс үүдэлтэй эрсдэлийг эрт илрүүлэх, үр нөлөөтэй удирдах, хяналтын орчныг бэхжүүлэх, байгууллагын тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллалаа.

Тайлант хугацаанд Банк Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын системээ улам боловсронгуй болгож, банк хэмжээнд Эрсдэл ба хяналтын өөрийн үнэлгээ (RCSA)-г хэрэгжүүлэн эрсдэлийг тодорхойлох, хяналтын үр нөлөөг үнэлэх, удирдлагын мэдээллийн чанарыг сайжрууллаа. Мөн Банкны түүхэнд анх удаа Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хороог байгуулснаар үйл ажиллагааны эрсдэлийн асуудлаарх хяналт, шатлан мэдэгдэх тогтолцоо, шийдвэр гаргалтын үр нөлөөг шинэ түвшинд хүргэв.

Үүнээс гадна Эрсдэлийн удирдлагын тогтолцоо бодлогын баримт бичиг, Эрсдэлийн таксономи, Эрсдэлийн аппетитийн мэдэгдэл болон даатгалын ерөнхий журмыг шинэчлэн сайжруулснаар Банкны эрсдэлийн засаглал, тайлагнал, хяналтын орчны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг бэхжүүллээ. Эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх чиглэлд Эрсдэлийн соёлын хөтөлбөрийг хэрэгжүүлж,

Эрсдэлийн соёлын судалгаа болон жил бүр заавал өгөх эрсдэлийн шалгалтыг зохион байгуулж, байгууллагын хэмжээнд эрсдэлийн тухай ойлголт, мэдлэгийг улам бэхжүүлэв. Мөн Ёс зүйн төлөөлөгч нарт зориулсан “Ёс зүй, эрсдэлийн форум”-ыг дөрөв дэх удаагаа амжилттай зохион байгуулж, зөв зан төлөв, хариуцлагатай эрсдэлийн соёлыг түгээн төлөвшүүлэх ажлыг үргэлжлүүлэв.

Мэдээллийн технологийн эрсдэл болон Бизнесийн тасралтгүй ажиллагааны чиглэлд Банк “Бизнесийн нөлөөллийн дүн шинжилгээ”-г хийсэн бөгөөд ISO22301: Бизнесийн тасралтгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны стандартын хяналтын аудитыг амжилттай хэрэгжүүлж, Мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын журмыг шинэчлэн баталлаа. Эдгээр арга хэмжээ нь Банкны чухал үйл ажиллагаа, дижитал сувгийн тасралтгүй ажиллагаа, бэлэн байдал, технологийн эрсдэлийн засаглалыг улам бүр бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

Цаашид Банк санхүүгийн бус эрсдэлийн удирдлагыг илүү боловсронгуй засаглал, илүү цаг үеэ олсон удирдлагын мэдээлэл, нэгдүгээр шугамын хариуцлагатай байдал, мөн уян хатан байдлын чадавхыг тасралтгүй сайжруулах замаар улам бүр бэхжүүлэн ажиллах болно. Бид хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлийн асуудлыг шуурхай шатлан мэдэгдэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг сайжруулах, эрсдэлийн соёлыг байгууллагын хэмжээнд төлөвшүүлэхэд тууштай анхаарсаар байх болно. Үйл ажиллагааны орчин цаашид улам бүр хувьсан өөрчлөгдөхийн хэрээр эдгээр чиглэл нь харилцагчийн эрх ашгийг хамгаалах, Банкны нэр хүндийг бататгах, тогтвортой өсөлтийг хангахад чухал хэвээр байна.

Мэдээллийн аюулгүй байдал, цахим эрсдэл

2025 онд Голомт банк ISO/IEC 27001:2022, PCI DSS 4.0, PCI-3DS 1.0, ISO/IEC 27701:2019, GDPR болон SWIFT CSP v2025 зэрэг олон улсын стандартуудын хэрэгжилтийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулж, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоогоо улам бэхжүүлсэн. Эдгээр стандарт нь харилцагчийн мэдээллийг дэлхийн жишигт нийцсэн байдлаар хамгаалах үндсэн суурь болж байна.

Онцлох ажил нь олон улсын кибер аюулгүй байдлын компанитай хамтран 24/7 горимоор ажиллах хосолсон Кибер Аюулгүй Байдлын Удирдлагын Төв (КАБУТ)-ийг байгуулсан явдал юм. Давхарласан хамгаалалтын стратеги, эмзэг байдлын тогтмол шалгалт, Bug Bounty хөтөлбөр болон кибер эрсдэлийн даатгалтай хослуулснаар банк нь улам нарийсч буй кибер аюулыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах бүрэн чадамжаа бэхжүүлж байна.

Дижитал банкны үйлчилгээ өргөжихийн хэрээр цахим залилан, нийгмийн инженерчлэл болон хиймэл оюун ухаанд суурилсан халдлагын эрсдэл нэмэгдэж байна. Үүний хариуд бид зөрчил эрсдэл илрүүлэх систем, бодит цагийн шинжилгээ, олон хүчин зүйлт баталгаажуулалт болон эрсдэлд суурилсан хандалтын хяналтыг санхүүгийн цахим сувагт нэвтрүүлснээр банкны харилцагчдыг цахим халдлага луйварт өртөхөөс урьдчилан сэргийлж ажиллалаа.

Үүний зэрэгцээ, банк өөрийн үйл ажиллагаанд хиймэл оюуныг нэвтрүүлэхтэй холбоотой эрсдэлүүд болох найдвартай модел, өгөгдлийн нууцлал, алгоритмын хэвийлт болон гуравдагч талын хиймэл оюуны хамаарлыг технологи, тасралтгүй хяналтаар удирдаж, хиймэл оюуныг хариуцлагатай, аюулгүй ашиглах орчныг бүрдүүлж байна.

Уур амьсгалын эрсдэл

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ хангалтгүй тохиолдолд банкны зээлийн багц, ялангуяа нүүрстөрөгчийн ялгаралт өндөртэй салбарууд болон уур амьсгалын эрсдэлд өртөмтгий барьцаа хөрөнгийн эрсдэл нэмэгдэх хандлагатай байна. Иймд уур амьсгалын эрсдэлийг бодитой тодорхойлох, үнэлэх, хянах, удирдах нь банкны санхүүгийн тогтвортой байдал, урт хугацааны хөгжлийн зорилттой салшгүй холбоотой юм.

Энэ хүрээнд Банк нь 2025 онд тогтвортой хөгжил, уур амьсгалын эрсдэлийг бусад гол эрсдэлүүдтэй адил түвшинд авч үзэж эрсдэлийн удирдлагын тогтолцоонд тусган баталж, зээлийн багцад нөлөөлөх уур амьсгалын биет болон шилжилтийн эрсдэлийг тоон аргаар үнэлэх, мөн харилцагчдын шилжилтийн бэлэн байдлыг үнэлэх аргачлалыг боловсруулан ажиллаж байна.

Эрсдэлийн менежмент

Бид өөрийн удирдаж чадах зүйлсийг удирдахаас гадна бидний тооцоолоогүй гэнэтийн нөхцөл байдал гадаад орчин, үйлчилгээ авч байгаа байгууллагын гэнэтийн асуудлаас болж үүсэхэд тухайн асуудлыг шийдэх процесс тодорхой, төлөвлөгөө бэлэн байлгах нь нь бидний хамгийн их анхаардаг зүйлсийн зүйлсийн нэг юм. Бид аппликэйшний лог болон хяналтын процессыг илүү сайжруулснаар эрсдэл доголдлыг эрт илрүүлж, аливаа асуудал гарсан үед үйлчилгээг илүү хурдан сэргээх боломжтой болсон. Эдгээр сайжруулалт нь системийн сул зогсолтын хугацааг бууруулаад зогсохгүй үйл ажиллагааны уян хатан байдлыг бэхжүүлж, үйлчилгээний найдвартай байдлыг сайжруулж, харилцагч банкны технологийн дэд бүтцэд итгэх итгэлийг нэмэгдүүлж байна.

Голомт банкны бүх төрлийн тасалдал (дотоод болон гуравдагчаас хамаарсан)-ын давтамж эдгээр болон дэмжих бусад ажлыг хийснээр 1.8 дахин буурсан сайн үзүүлэлтэд хүрлээ.

2026 онд анхаарах чиглэлүүд

• Макро эдийн засаг болон геополитикийн эрсдэлийг идэвхтэйгээр хянах, тэдгээрийн банканд үзүүлэх болзошгүй нөлөөг стресс тестээр үнэлэх

• Санхүүгийн гэмт хэрэг болон цахим эрсдэлийн удирдлагын чадавх, хяналтыг сайжруулах зорилгоор дижиталчлал болон ахисан түвшний өгөгдөл шинжилгээг ашиглах

• Кибер аюулгүй байдал, технологийн уян хатан байдал болон гуравдагчийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх

• Эрсдэлийн талаарх хүчтэй соёлыг төлөвшүүлэх

• Засаглал, манлайлал, систем болон үйл явцыг сайжруулах замаар санхүүгийн бус эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх

• Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийн удирдлага болон стресс тестийн чадавхыг бэхжүүлэх



T.Отгон

Эрсдэл хариуцсан захирал

Мэдээллийн технологи хариуцсан захирал

М.САЙНБИЛЭГ

Голомт банк үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн дижитал шилжилтийн эхлэлийг тавьж, инновац шингэсэн дэвшилтэт шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг Монголын банк санхүүгийн салбарт анхлан нэвтрүүлсээр ирсэн. Сүүлийн жилүүдэд бид харилцагч, хамтрагч байгууллагууддаа Дижитал банк, Нээлттэй банк, Дэд бүтэц хуваалцах үйлчилгээ, Агент банк гэсэн дөрвөн үндсэн технологид суурилсан бизнесийн загварыг санал болгож байна. Түүнчлэн иргэд, жижиг, дунд бизнес, байгууллагын банкны харилцагч, түншүүдийнхээ ч дижитал шилжилтэд анхаарч, туршлага хуваалцаж ажилдгаараа бид бусдаас ялгардаг. Голомт банкны хувьд дижитал шилжилтийн аяллыг 2005-2014 он, 2015-2025 он, 2025 оноос хойш гэсэн гурван үед хуваан үзэж болох бөгөөд 2025 он анхны AI виртуал банк болох эхлэлийг тавьсан жил байлаа.



Мэдээллийн технологи

Хэдийгээр өөрчлөлт, сайжруулалт, шинэчлэлтийг байнга хийж, банкны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байх зорилго нь бидний тэргүүн эгнээний зорилго ч харилцагчдын суурь шаардлага болох банкны бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдад доголдол, тасалдалгүй хүргэх шаардлагыг хангах үүднээс олон сайжруулалтыг хийлээ.

Системийн уян хатан байдал

Бид Kubernetes мульти-кластер архитектурыг үндсэн болон нөөц хоёр дата төвд амжилттай нэвтрүүлээ. Энэ нь үндсэн ч дата төвд доголдол үүссэн ч харилцагчийн үйлчилгээ тасалдал доголдолгүйгээр үргэлжлэх боломжийг олгож байгаа юм. Мөн бид "AWS Direct Connect"-ийг нэвтрүүлсэн бөгөөд ингэснээр шаардлагатай үед үндсэн тооцооллын нөөцийг үүлэн технологи руу жигд өргөжүүлэх боломжийг олгож байна. Ингэснээр системийн хүртээмж, тасралтгүй ажиллагааг мэдэгдэхүйц хэмжээгээр сайжруулаад зогсохгүй үйлчилгээнүүдийг бие

даан ажиллах боломжтой болгож, бууруулж байгаа юм. Мөн тухайн үеийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан тодорхой үйлчилгээг хурдан байршуулах, шинэчлэх, өргөжүүлэх боломжтой болж байна. Үр дүнд нь технологийн орчин нөхцөл илүү уян хатан, хурдан шуурхай болж, бизнесийн өсөлт болон харилцагчдын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагыг дэмжих чадвар сайжирч байна.

Өөрчлөлтийн менежмент

Гадаад орчны тодорхой бус байдал, зохицуулагч байгууллагын гэнэтийн шийдвэр нь өөрчлөлтийн менежментийг хурдтай, эрсдэлгүй удирдах шаардлагыг улам нэмэгдүүлж байна. Иймд манай ихэнх системүүд микро сервист суурилсан архитектурт шилжсэн. Энэхүү шилжилт нь тасралтгүй интеграц болон тасралтгүй байршуулалт (CI, CD), канари нэвтрүүлэлт зэрэг орчин үеийн хөгжүүлэлтийн практикийг дэмжиж, банкны дижитал үйлчилгээг хүргэхэд ашиглагдаж байна. Үүний үр дүнд бид шинэчлэлт, сайжруулалтыг аюулгүй байршуулж, асуудал гарсан тохиолдолд өөрчлөлтийг буцаан байршуулах,

харилцагчийн үйлчилгээнд үзүүлэх аливаа нөлөөллийг багасгах бүрэн боломжтой болж байгаа юм. Түүнчлэн Микро сервист шилжсэнээр банкны системийн уян хатан, бат бөх байдал, өргөтгөх чадвар сайжирч, инновацыг хурдасгаж, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулаад байна.

Дижитал шилжилт

Бизнесийн өсөлтийг дэмжсэн дата дэд бүтэц, технологи

Банк нь дата аналитик болон дата засаглалын дэд бүтцийг дэмжих зорилгоор хиймэл оюунд бэлэн өндөр гүйцэтгэлт дата төв, дэвшилтэт програм хангамж, дата лэйкаус систем зэрэг стратегийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлж, датанд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, дата чанар, түүний хүртээмж, аюулгүй байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ их хэмжээний дата анализ (big data analytics) хийх хурдыг 10-400 дахин хурдасгасан бодит үр дүн гарч, үйл ажиллагааны бүтээмж, эрсдэлийн удирдлага, дижитал шилжилтийн зорилтуудыг амжилттай хангаж байна.

Шинээр үүсгэсэн дата моделийн тоо

679

Их өгөгдлийг хурдан хугацаанд боловсруулах хурд

10X

Үйл ажиллагааны бүтээмж

Банкны бизнес процессуудыг оновчлох, нөөцийн ашиглалтыг сайжруулах, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжихэд чиглэсэн процессын шинжилгээ, дата аналитик болон хиймэл оюуны шийдлүүдийг нэвтрүүлсний үр дүнд банкны үйл ажиллагааны үр ашиг мэдэгдэхүйц сайжирч, үйл ажиллагааны зардлын хэмнэлт бий болгож чадлаа. Уг хэмнэлт нь банкны санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ банкны нэгж бүрийн үйл ажиллагааны бүтээмжийг дунджаар 12.5%-аар технологид суурилсан байдлаар сайжруулж байна.

Хиймэл оюун, машин сургалт

Банк нь хиймэл оюунд суурилсан дижитал шийдлүүдийг хэрэгжүүлснээр бизнесийн үйлчилгээ, дотоод процессын автоматжуулалтыг дэмжиж, харилцагчийн туршлага, үйл ажиллагааны бүтээмж, зардлын үр ашиг, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг нэгэн зэрэг сайжруулах стратегийн ач холбогдолтой дижитал шилжилтийг амжилттай хэрэгжүүлж, банкны урт хугацааны өрсөлдөх чадвар, технологид суурилсан тогтвортой өсөлтийг бэхжүүлж байна. Тухайлбал, орон сууц олон автомашины жишиг үнэ таамаглах AI загварууд, Харилцагчийг зайнаас таних eKYC, Баримтын хяналтын OCR шийдлүүд юм. Түүнчлэн бид гуравдагч байгууллагатай хамтран хиймэл оюуныг банкны бүхий л хэсэг ашиглах төслийг эхлүүлэв.

Процесс менежмент

Банкны процессуудыг удирдах, хянах, хэмжих боломжтой болж, "Prime BPM" системийг нэвтрүүлснээр дараагийн томоохон шилжилт, өөрчлөлтийг бүтээмж өндөртэй төлөвлөх боломжийг бүрдүүлж байна.

Төслүүд

Харилцагчийн туршлага сайжруулах, Бизнесийн үйл ажиллагааг дэмжих, Дотоод үйл ажиллагааг сайжруулах үндсэн гурван чиглэлээр 11 төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, эдгээр нь харилцагчийн туршлага, үйл ажиллагааны үр ашиг, технологи-дата дэд бүтэц, эрсдэлийн удирдлагын чиглэлд төвлөрсөн бодит үнэ цэнийг бий болголоо.

Дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээ

Монгол Улсын банк санхүүгийн салбарт тогтмол шинэ үйлчилгээ анхлан нэвтрүүлдэг жишгийнхээ дагуу дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэвтрүүлэв.

Лоялти

Голомт банк "wide loyalty" буюу урамшууллын оноогоо өөрийн бүх төрлийн үйлчилгээ болон хамтрагч байгууллагуудын олон бүтээгдэхүүн, үйлчилгээнээс авах боломжтой систем нэвтрүүлсэн цорын ганц банк юм. Тайлант хугацаанд энэхүү шийдлээ илүү сайжруулж, Coupon market place, Coupon based payment шийдлүүдийг анхлан нэвтрүүлээ.

- БНХАУ-ын Cross-Border Interbank Payment System (CIPS) буюу олон улсын юанийн төлбөр тооцооны систем
- Хамгийн өргөн лоялти сүлжээ, дахин давтагдашгүй үнэ цэн, нэр хүндийн баталгаа бүхий Universe шинэ картын концепт
- Монгол Улсын анхны "wearable" төрлийн Skate төлбөрийн карт
- 22 граммын метал хийцлэл, дагалдах 26 консьерж үйлчилгээтэй "World Mastercard" өндөр зэрэглэлийн кредит карт
- Android үйлдлийн системтэй утастай бүх харилцагчдаа Mobile contactless payment буюу гар утасны контактгүй үйлчилгээг санал болгох Google Pay төлбөрийн хэрэгсэл
- SocialPay хэтэвчээ ашиглан WeChat QR кодыг уншуулж, төлбөр тооцоогоо БНХАУ-д өөрийн данснаасаа саадгүй хийх WeChat Pay
- Банк болон Финтек хамтралын сайн жишгийг бий болгосон хуваан төлөх EasyPay үйлчилгээ

Хөнгөлөлтийн купон



Төлбөрийн купон



Хөтөлбөр

64
Аян

2B
Урамшуулал

Хөнгөлөлт

100+
Байгууллага

10B/138K
TRX Volume T / Too

Хөтөлбөр

12.5K
Купон

30%
Хөнгөлөлт

Агент банк

Банк салбаргүй байршлуудад агентад суурилсан борлуулалт хийх боломж бүхий платформыг нэвтрүүлсэн нь харилцагчдын цаг хугацаа, зардлыг хэмнэж, салбар төвтэй уламжлалт загвараас технологи, түншлэлд суурилсан, цар хүрээгээ тэлэх боломжтой экосистем рүү чиглэж стратегийн хувьд томоохон алхам болсон. Ингэснээр харилцагчдыг татах хугацаа болон үйл ажиллагааны зардлыг эрс бууруулж чадсан. Үр дүнд нь агентууд, харилцагчид болон хамтрагч байгууллагуудыг саадгүй холбох нэгдсэн экосистемийг бий болголоо.

Төлбөр хүлээн авах өргөн сүлжээ

Хамгийн олон төрлийн төлбөр тооцоо хүлээж авдаг боломжоо улам өргөжүүлэв.



Бэлэн бус төлбөр тооцоо

Голомт банкны нийт шилжүүлэг, төлбөр тооцооны 99% нь онлайн болон картын сувгуудаар хийгдэж, жишиг түвшинд хүрлээ. 2025 оны байдлаар дижитал банкны хэрэглэгч нэг сая гаруйд хүрсэн бөгөөд хэрэглэгчдийн 99 хувийг Интернэт банк болон Смарт банкны хэрэглэгчид эзэлж байна. Өмнө нь нийт дижитал банк хэрэглэгчийн 50 орчим хувийг SocialPay аппликэйшн хэрэглэгчид эзэлж байсан бол энэ үзүүлэлт сүүлийн хоёр жилд хурдацтайгаар өсөж, 80 орчим хувьд хүрлээ.

Дүгнэлт

Голомт банк өөрчлөлт шинэчлэлтээр манлайлж, Монгол Улсдаа тэргүүлэх инновацлаг санхүүгийн байгууллагуудын

Олон улсын мөнгөн гуйвуулга

SWIFT, Visa B2B болон Western Union-оос гадна дотоодын болон олон улсын Fintech байгууллагуудтай хамтран олон улсын мөнгөн гуйвуулгын өөр шийдлүүдийг нэвтрүүллээ. Ингэснээр зөвхөн IBAN ашиглахаас илүүтэйгээр хурдан шуурхай бөгөөд өргөн хүрээний боломжуудыг олгодгоороо давуу талтай. Тухайлбал, карт болон утасны дугаараар ашиглаж, IBAN эсвэл нэр, хаягийн тохируулга зэрэг бусад уламжлалт үзүүлэлтүүдийг хадгалах боломжтой. Үүний үр дүнд харилцагчдын цаг хугацаа, зардлыг бууруулах юм.

2026 онд анхаарах чиглэлүүд

2026 онд бид системийн тасралтгүй ажиллагааг илүү өндөр түвшинд барих, бүтээмжийг нэмэгдүүлэх хэмжилтийг банкны нэгжүүдэд хийх, банкны үндсэн онлайн сувгуудыг шинэчлэх, карт гаргах, хүлээн авах шийдлүүдийг үргэлжлүүлэн сайжруулж, идэвхтэй харилцагчдыг нэмэгдүүлэх замаар шимтгэл, хураамжийн орлогыг өсгөх, ойрын ирээдүйн гол суурь болох хиймэл оюунд суурилсан банкны бизнес загварын суурь технологийн шийдлүүдийг үргэлжлүүлэн хөгжүүлэхэд төвлөрөн ажиллахаар төлөвлөж байна.

М.Сайнбилэг

Мэдээллийн технологи хариуцсан захирал

Засаглалын тайлан

Голомт банк нь компанийн засаглалын хамгийн өндөр стандартыг хэрэгжүүлэх зарчмыг тууштай баримталж ирсэн бөгөөд зохистой сайн засаглалыг бүрдүүлэх нь урт хугацааны санхүүгийн уян хатан байдал, оролцогч талуудын итгэл, тогтвортой үнэ цэнийг бий болгоход чухал ач холбогдолтой. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацаанд Банк нь Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн засаглалын тогтолцоогоо улам бэхжүүллээ. Мөн Төлөөлөн удирдах зөвлөл нь стратеги, эрсдэл, дотоод хяналт, ёс зүй болон БОНЗ асуудалд үр дүнтэй хяналт тавьж, тогтвортой хөгжлийн зарчмыг шийдвэр гаргалтад бүрэн шингээж ажиллалаа.

Хувьцаа эзэмшигчид

Голомт банкны нийт хувьцааны 11.6 хувь буюу 93 мянга гаруй нэгж хувьцааг олон нийт эзэмшиж байна.

Голомт Файнэншил
Групп ХХК

79.77%

Голомт Файнэншил Групп ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр бизнесийн төвлөрсөн үйл ажиллагаа явуулдаг 100 хувь Монголын хөрөнгө оруулалттай компани юм. Тус компани нь урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого баримталдаг ба Голомт банкны энгийн хувьцаа болон зарим хувьцаанд хөрвөх зээлүүдийг эзэмшдэг.

Олон нийт

11.6%

Голомт банк 2022 онд хувьцаагаа олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг хийснээр банкны нийт хувьцааны 11.6 хувь болох 93 мянга гаруй нэгж хувьцааг олон нийт эзэмшиж байна.

Свисс-Мо
Инвестмэнт Эй Жи

5.21%

Свисс-Мо Инвестмэнт Эй Жи нь Швейцарь улсын хөрөнгө оруулалтын сан бөгөөд 2010 онд үүсгэн байгуулагдсан. Вальют арилжаа, нисэх онгоцны буудал, агаарын тээвэр болон зочид буудлын салбаруудад хувьцаа эзэмшдэг. 2011 онд Голомт банканд хөрөнгө оруулалт хийснээр хувьцаа эзэмшигч болсон.

Бодь
Интернэшнл ХХК

3.42%

Бодь Интернэшнл ХХК нь үндэсний хөрөнгө оруулалттайгаар 1993 онд байгуулагдсан. Томоохон групп компаниудын нэг бөгөөд өдгөө үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, удирдлага, барилга, эрчим хүч, уул уурхай, амралт аялал жуулчлалын салбаруудад үйл ажиллагаагаа явуулдаг.

Засаглалын тогтолцоо

Голомт банкны Засаглалын тогтолцоо нь Монгол Улсын Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж зэрэг зохицуулагч байгууллагын холбогдох дүрэм, журамтай нийцэхээс гадна олон улсын засаглалын үндсэн зарчмууд, шилдэг туршлагауд, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ) болон Базел зэрэг баримт бичиг, стандартын дагуу зохистой засаглалын тогтолцоогоо улам бэхжүүлэн ажиллаж байна.



Банкны удирдлага

Төлөөлөн удирдах зөвлөл

2016 онд Хятагтай Ч.Мөнхцэцэг нь "Нерко Publishing" хэвлэлийн компани зэрэг газруудад ажиллаж байсан бөгөөд 2010 оноос "Тойм" сэтгүүлийг эрхлэн гаргаж байсан.

2016 онд АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр /MBA/ зэрэгтэй төгссөн. 2015 онд Англи улсын Оксфордын их сургууль, 2016 онд АНУ-ын Харвардын их сургуулиудад тус тус мэргэжил дээшлүүлсэн.

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүнээс 5 Хараат бус гишүүнтэй. ТУЗ-ийн дийлэнх гишүүнийг Хараат бус гишүүдээр бүрдүүлсэн Монгол Улсын анхны системийн нөлөө бүхий банк юм. ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь санхүүгийн салбарт хамгийн багадаа 30 жилээс дээш хугацаанд, тэр дундаа тус салбарт 10 жилээс дээш эрх бүхий

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

2016 онд Хятагтай Ч.Мөнхцэцэг нь "Нерко Publishing" хэвлэлийн компани зэрэг газруудад ажиллаж байсан бөгөөд 2010 оноос "Тойм" сэтгүүлийг эрхлэн гаргаж байсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга**Ч.Мөнхцэцэг**

Хатагтай Ч.Мөнхцэцэг нь 1988 онд Зөвлөлтийн III бүрэн дунд сургууль, 1993 онд Политехникийн их сургуулийг Уул уурхайн цахилгаан механикийн инженер /BSMinE/, 2001 онд АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр /MBA/ зэрэгтэй төгссөн. 2015 онд Англи улсын Оксфордын их сургууль, 2016 онд АНУ-ын Харвардын их сургуулиудад тус тус мэргэжил дээшлүүлсэн.

Ажлын гараагаа 1996 онд Монголын Хөрөнгийн Биржээс эхэлж, Дэлхийн банк, Азийн сан, “Nepko Publishing” хэвлэлийн компани зэрэг газруудад ажиллаж байсан бөгөөд 2010 оноос “Тойм” сэтгүүлийг эрхлэн гаргаж байсан.

Ч.Мөнхцэцэг нь ТУЗ-ийн түвшинд ажилласан 20 гаруй жилийн туршлагатай бөгөөд Олон улсын сургууль, Масс медиа групп зэрэг байгууллагуудад ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан. 2012 оны 12-р сард Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдож, 2013 оны 12-р сараас Голомт банкны ТУЗ-ийн даргаар томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**Ж.Үнэнбат**

Ноён Ж.Үнэнбат нь 1985 онд Москвагийн Эдийн засаг статистикийн дээд сургуулийг, 1994 онд АНУ-ын Нью-Йоркийн Колумбын их сургуулийг магистрын зэрэгтэйгээр тус тус төгссөн.

1996 оноос Монголбанканд ажиллаж эхлэн Монголбанкны Ерөнхийлөгч албан тушаалыг хашиж байсан бөгөөд мөнгөний бодлого, судалгааны чиглэлээр олон ажлыг хийж, банк санхүүгийн чиглэлээр арвин их туршлага хуримтлуулсан. 2000, 2015 онуудад Монголын банкны холбооны Гүйцэтгэх захирлаар томилогдон тус тус 5 жил ажилласан. Компанийн засаглалын хөгжлийн төвийн (КЗХТ) Гүйцэтгэх захирал бөгөөд СЭЗДС-ийн Санхүүгийн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байсан туршлагатай.

Өндөр албан тушаалыг хашсан гишүүдээс бүрддэг бөгөөд хөрөнгө оруулалтын удирдлага, эрсдэлийн удирдлага, БОНЗ, хууль эрх зүй, санхүү бүртгэл, аудит хяналт, эдийн засгийн судалгаа зэрэг олон талт ур чадварын нэгдэл болсон тэнцвэртэй, хараат бус бүрэлдэхүүнтэй юм.

Өдгөө КЗХТ-д Зөвлөхөөр ажилладаг. 2010 онд анх Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдож, 2020 оноос ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**Д.Мөнхтөр**

2016 онд Хятагтай Ч.Мөнхцэцэг нь "Нерко Publishing" хэвлэлийн компани зэрэг газруудад ажиллаж байсан бөгөөд 2010 оноос "Тойм" сэтгүүлийг эрхлэн гаргаж байсан.

Ноён Д.Мөнхтөр нь 1997 онд МУИС-ийн ЭЗС-ийг Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй, 2009 онд АНУ-ын Оклахомагийн их Сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр дүүргэсэн.

1996 оноос Голомт банканд Туслах ажилтнаас эхлэн Эдийн засагч, Зээлийн газрын захирал, Бүртгэл тооцооны газрын захирал, 2011 оноос Тэргүүн дэд захирлаар ажиллаж байсан туршлагатай. Одоо Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-д Гүйцэтгэх удирдлагын үүрэгт ажлыг гүйцэтгэж байна.

1996 оноос Голомт банканд Туслах ажилтнаас эхлэн Эдийн засагч, Зээлийн газрын захирал, Бүртгэл тооцооны газрын захирал, 2011 оноос Тэргүүн дэд захирлаар ажиллаж байсан туршлагатай. Одоо Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-д Гүйцэтгэх удирдлагын үүрэгт ажлыг гүйцэтгэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**Д.Мөнхтөр**

Ноён Д.Мөнхтөр нь 1997 онд МУИС-ийн ЭЗС-ийг Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй, 2009 онд АНУ-ын Оклахомагийн их Сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр дүүргэсэн.

1996 оноос Голомт банканд Туслах ажилтнаас эхлэн Эдийн засагч, Зээлийн газрын захирал, Бүртгэл тооцооны газрын захирал, 2011 оноос Тэргүүн дэд захирлаар ажиллаж байсан туршлагатай. Одоо Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-д Гүйцэтгэх удирдлагын үүрэгт ажлыг гүйцэтгэж байна.

Тэрээр Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд хувьцаа эзэмшигч болсон ба 149 цөөнх хувьцаа эзэмшигчийг төлөөлж, 2012 оноос ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**О.Ганжолоо**

Ноён О.Ганжолоо нь ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт их сургуулийг Эдийн засгийн онолын чиглэлээр магистр болон докторын зэрэгтэй төгссөн. Мөн Их Британийн Нэгдсэн Вант Улс болон Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй.

Тэрээр ХБНГУ болон Монгол дахь Олон улсын PwC аудитын компанийн салбаруудад ажиллаж байсан ба өмнө нь Бодь Интернэшнл ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирлаар ажиллаж байсан туршлагатай.

О.Ганжолоо нь 2016-2023 он хүртэл Голомт Файнэншил Групп ХХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан. Одоогоор Цэцэнс майнинг энд Энэржи ХХК-ийн Санхүү хариуцсан захирлаар ажилладаг.

2022 оноос Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн Жэймс Б. Двайер

Ноён Двайер нь АНУ-ын Notre Dame их сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр, Колумбийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд тус сургуулийн 40,000 гишүүнтэй төгсөгчдийн холбооны Ерөнхийлөгчөөр дараалан сонгогдон ажиллаж байсан.

2001 онд Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны хувьчлалын ажиллагаанд оролцохоор анх Монгол Улсад ирж, Хойд Америкийн Бизнес зөвлөлд Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байсан бөгөөд 2007 онд Монголын бизнесийн зөвлөлийг үүсгэн байгуулж, 2016 он хүртэл Гүйцэтгэх захирал, 2017 оны 4-р сар хүртэл ТУЗ-ийн Дэд даргаар ажиллаж байсан.

Тэрээр 1970 оноос хойш Швейцарын Нэгдсэн Банкны дэлхий дахины Нэгдэл ба Худалдан авалт хариуцсан захирлаар, Нью-Йорк хотын Вол Стрийтд байрлалтай санхүүгийн байгууллагуудад хөрөнгө оруулалтын банкир хийж байсан туршлагатай.

Тэрээр одоо Мандал даатгал ХК, Mongolian Growth Group, Монголын Финтек групп болон Сэндли ХК-ийн охин компанид ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус ажилладаг. Мөн Монголын Боловсролын Сангийн Ерөнхийлөгч, Монголын Бизнес Мэдээллийн Сангийн ТУЗ-ийн гишүүний албыг давхар хашиж байна.

2018 оноос Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн**Александр Пикер**

Ноён Александр Пикер нь Австри улсын Салзбургийн их сургуулийг бизнес, хуулийн чиглэлээр магистр болон докторын зэрэгтэй төгссөн.

Анх 1989 онд ажлын гараагаа одоогийн Австри банкнаас эхлүүлж, Die ERSTE bank, International Moscow Bank (IMB), Unicredit Bank, JSC ATF Bank Нуро Alpe-Adria Bank, HBI Bundesholding AG зэрэг банкнуудад Эрсдэл хариуцсан захирал, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал зэрэг удирдлагын албан тушаалуудад ажиллаж байсан олон жилийн туршлагатай.

Тэрээр одоо Узбекистаны Ипотека банкны Хяналтын зөвлөлийн даргын албан тушаал, Молдав Улсын Молдиндкон банкны Хяналтын зөвлөлийн Хараат бус гишүүний албан тушаалыг хашиж байгаа бөгөөд Дэлхийн банкны томоохон төслүүдэд ахлах зөвлөх, Молдав улсын Молдиндкон банкны Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан.

2021 оноос Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Роберт В. ван Свитен

Ноён Роберт В.Ван Свитен нь Нидерландын Хаант Улсын Лейден их сургууль болон АНУ-ын Колумбын их сургуулийг Хууль зүйн бакалавр, Chicago Booth их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Ноён Роберт В.ван Свитен нь дэлхийн санхүүгийн зах зээл болон тогтвортой хөгжлийн салбарт 30 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр Тогтвортой хөгжлийн институтийн хөрөнгө оруулалтын стратегийн талаар зөвлөгөө өгдөг Route17 фирмийн хамтран үүсгэн байгуулагч, Serendra Group-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Мөн Climate Policy Initiative-ийн гишүүн бөгөөд Дэлхийн бенчмаркийн холбооны төлөөлөгч, хэд хэдэн компанийн ТУЗ-ийн гишүүн, Азийн гэр бүлийн оффисын Ахлах зөвлөхөөр ажилладаг.

Тэрээр өмнө нь EMPEA холбооны (одоогийн GPCA) ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлаар, Сингапурын бирж, Lehman Brothers, General Electric, ABN Amro банк зэрэг компаниудад удирдах албан тушаал болон Азийн хөгжлийн банкны Хувийн секторын хөрөнгийн зах зээлийн хэлтсийн захирлаар ажиллаж байсан.

2023 оноос Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн**Ханс Холзхакер**

Ноён Ханс Холзхакер нь 2020 оноос “Төв Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны судалгааны хүрээлэн /CAREC/”-ийн Ерөнхий эдийн засагчаар ажиллаж байгаа бөгөөд 2017-2019 оны хооронд “Европын сэргээн босголт, хөгжлийн банк /EBRD/”-ны Төв Азийн бүс хариуцсан Тэргүүн эдийн засагчаар ажиллаж байсан. Тэрээр Төв болон Зүүн Европ, ТУХН-ийн орнуудын Эдийн засагчаар 30 гаруй жил ажилласан туршлагатай ба Казахстан улсын АТФ банкны Ерөнхий эдийн засагч, Алматы хот дахь“Наркоз их сургууль”-ийн шинжлэх ухааны Ахлах зөвлөхөөр ажиллаж байсан. Өмнө нь тэрээр БНАУ-ын ЮниКредит группийн гишүүн Австрийн банкны Орос, Украины чиглэлээр ажилладаг Вена хотод төвтэй Ахлах эдийн засагч байсан бөгөөд Төв Европын орнуудын үнэлгээг хариуцаж байсан.

Ноён Ханс Холзхакер нь 1999-2001 онд АНУ-ын Вашингтон дахь Олон улсын санхүүгийн хүрээлэн / Institute of International Finance/-д Чех, Словак, Словени, Украин улсуудыг хариуцсан Ахлах эдийн засагч, 1993-1999 онд Австрийн Хөрөнгө оруулалтын банк / Investmentbank Austria/-ны “GiroCredit Research”-д Улс орны эрсдэл/судалгаа хариуцсан дарга, 1989-1993 онд Лондон хотод төвтэй Венийн Номура судалгааны хүрээлэнгийн Төв Европын орнуудыг хариуцсан эдийн засагчаар ажиллаж байсан.

Тэрээр 1984 онд БНАУ-ын Венийн их сургуульд Социологийн докторант, 1988 онд Эдийн засгийн магистрын зэргийг хамгаалсан бөгөөд 1989 онд Венийн Ахисан түвшний судалгааны хүрээлэнгийн Эдийн засгийн тэнхимд аспирантурын тэтгэлэгт хамрагдаж байсан.

2024 оноос Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн Ронил Сүжан

Ноён Ронил Сүжан нь АНУ-ын Станфордын их сургуулийг Байгууламжийн менежментийн мэргэжилтэн чиглэлээр төгссөн.

Анх 1990 онд ажлын гараагаа одоогийн Нэгдсэн Технологийн корпорацаас эхлүүлж, ПрайсУотерХаус, Энэтхэг Улс дахь Америкийн банк, Лондон дахь ANZ банк, Рабобанк групп, Савиллс Сингапур, Стратегийн ахлах зөвлөх, Энэтхэг улсын Мумбай хот, Тилакнагар Индастрис Лимитед, Хараат бус гишүүн, Сингапур, M Social/Up, Нью Йорк хот, DrumG Financial Technologies Greater ТУЗ-ийн гишүүн, хөрөнгө оруулагч, Ази, Ойрхи Дорнод, St.James's Place стратегийн зөвлөх, Недерланд, Стювард Рэдквийн, ахлах зөвлөх, Сингапур Улсын Үндэсний ИС, Инновацийн тэтгэлэгт хөрөнгө оруулалтын хороо/орон тооны бус факультет зэрэг удирдлагын албан тушаалуудад ажиллаж байсан олон жилийн туршлагатай.

Тэрээр одоо Сингапур улсын Үндэсний их сургууль, Инновацын тэтгэлэгт хөрөнгө оруулалтын хороо/орон тооны бус факультет, Раага Холдингс Хувийн ХК, Хамтран үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал, Үйл ажиллагаа хариуцсан захирал, INSEAD, Оршин суугаа газар дахь орон тооны бус бизнес эрхлэгч, Омнивор Партнерс, ТУЗ-ийн хараат бус гишүүн, Мега Делта Капитал, ТУЗ-ийн хараат бус гишүүн, Азийн Удирдлагын хүрээлэн, Орон тооны бус факультет албан тушаалыг хашиж байна.

2025 оноос Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга 3.Солонго

3.Солонго нь 2003 онд Энэтхэг улсын Гужарат мужийн Сардар Пател их сургуулийн бакалавр, 2017 онд СЭЗИС-ийн Компанийн засаглалаар мэргэшсэн Бизнес удирдлагын магистрын зэрэг хамгаалсан.

2017 онд Олон улсын санхүүгийн корпорац (IFC)-аас Сингапур улсад зохион байгуулсан Ази бүсийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын мастер хөтөлбөрт хамрагдаж, мэргэжил дээшлүүлсэн. 2007 оноос хойш Голомт банканд ажиллахдаа Гүйцэтгэх захирлын түвшинд Нарийн бичгийн дарга, Туслахын албан тушаал хашиж, 2015 оны 9-р сараас хойш Голомт банкны ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Дотоод аудитын газрын захирал А.Туяа

А.Туяа нь 2008 онд ХУИС-ийн Санхүүгийн удирдлагын бакалавр, МУБИС-ийн Боловсролын бакалавр, 2015 онд Австралийн үндэсний их сургуулийн Санхүүгийн магистрын зэрэг хамгаалсан.

Тэрээр 2008-2017 онд Голомт банкны Дотоод аудитын газарт аудитор, 2017-2019 онд Дотоод аудитын газрын Мэдээллийн технологи, Гүйцэтгэлийн аудитын хэлтэст ахлах аудитор, 2019-2023 онд Дотоод аудитын газрын Зайны аудит, Чанарын баталгаажуулалтын хэлтсийн захирлаар тус тус ажилласан бөгөөд 2023 оноос Голомт банкны Дотоод аудитын газрын захирлаар томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

ТУЗ нь тайлант хугацаанд улирал бүр ээлжит, тухай бүр ээлжит бус байдлаар хуралддаг. ТУЗ-ийн дэргэдэх 4 хороод тус бүр эрхлэх асуудлынхаа хүрээнд 2025 онд ТУЗ-ийн болон хороодын нийт 76 удаа хуралдаж холбогдох санал, зөвлөмж, шийдвэрийг гаргасан байна.

Доорх хүснэгтэд ТУЗ-ийн гишүүдийн тайлант хугацаанд оролцсон хурлын тоог тусгасан байна.

ТУЗ-ийн гишүүн	Хуралд оролцсон ирц (2025.01.01-2025.12.31)					
	ТУЗ*	АХ*	ЭУХ*	ЗЭЗЦУХ*	НДХ*	ХЭХ*
	2025 онд зохион байгуулагдсан хурлын тоо					
	17	11	37	5	5	1
Ч.Мөнхцэцэг Энгийн гишүүн, дарга • 2012.12.12 ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон • 2013.12.19 ТУЗ-ийн даргаар томилогдсон • 2025.04.17 улиран сонгогдсон	17	11	37	5	5	0
Ж.Үнэнбат Энгийн гишүүн • 2010.09.01 ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдсон • 2018.12.17 ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон • 2025.04.17 улиран сонгогдсон	17	-	37	-	-	1
Д.Мөнхтөр Энгийн гишүүн • 2012.12.12 ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон • 2025.04.17 улиран сонгогдсон	17	11	-	-	-	1
О.Ганжолоо Энгийн гишүүн • 2022.03.30 ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон • 2025.04.17 улиран сонгогдсон	17	-	-	-	-	1
Жеймс Б. Двайер III Хараат бус гишүүн • 2018.02.23 ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдсон • 2025.04.17 улиран сонгогдсон	17	11	37	5	-	1
Александр Пикер Хараат бус гишүүн • 2021.12.23 ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдсон • 2025.04.17 улиран сонгогдсон	17	11	37	5	5	1
Роберт В. ван Свитен Хараат бус гишүүн • 2023.04.26 ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдсон • 2025.04.17 улиран сонгогдсон	17	-	37	-	5	1
Ханс Холзхакер Хараат бус гишүүн • 2024.04.15 ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдсон • 2025.04.17 улиран сонгогдсон	17	11	-	-	-	1
Ронил Сүжан Хараат бус гишүүн • 2025.04.17 ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдсон *Ноён Ронил Сүжан нь 2025 оны ХЭХ-аар томилогдсон бөгөөд албан ёсоор албан тушаалаа хашиж эхэлснээс хойш бүх ТУЗ-ийн хуралд оролцсон болно.	9*	-	-	-	-	1

(1) ТУЗ – Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит/ээлжит бус хурал

(2) АХ – Аудитын хорооны хурал

(3) ЭУХ – Эрсдэлийн удирдлагын хорооны хурал


(4) ЗЭЗЦУХ – Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны хурал

(5) НДХ – Нэр дэвшүүлэх хорооны хурал


(6) ХЭХ – Хувьцаа эзэмшигчдийн хурал

2025 оны ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Хараат бус байдал



Ажилласан жил / гишүүний тоо



ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, чиг үүрэг

Хороо, бүрэлдэхүүн	Чиг үүрэг
Аудитын хороо <ul style="list-style-type: none"> Жеймс Б. Двайер III (Хорооны дарга) Александр Пикер Ханс Холзхакер Ч.Мөнхцэцэг Д.Мөнхтөр 	<p>Аудитын хороо нь 3 хараат бус гишүүн, нийт 5 гишүүнтэй бөгөөд даргаар нь ТУЗ-ийн Хараат бус гишүүн Жеймс Б.Двайер, Нарийн бичгийн даргаар Дотоод аудит хариуцсан захирал А.Туяа ажилладаг.</p> <p>Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд сар бүр хуралдаж, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай асуудлуудаар зөвлөмж хүргүүлдэг.</p> <ul style="list-style-type: none"> Жилийн болон сар бүрийн санхүүгийн тайлан, санхүүгийн үзүүлэлтүүдийг санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд болон эрх зүйн бусад актуудтай нийцэж байгаа эсэхийг хянах Банкны дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд анхаарч, үнэлэлт, дүгнэлт өгөх, Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, гол эрсдэлүүд, түүнийг хэрхэн удирдаж буй талаар чиглэл өгөх Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, гол эрсдэлүүд, түүнийг хэрхэн удирдаж буй талаар чиглэл өгөх Банкны Зөрчлийг мэдээлэх (шүгэл үлээх) үр дүнтэй тогтолцооны хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах Аудит хариуцсан захирлыг сонгон шалгаруулах, томилох, буцаан татах, цалин, урамшууллыг тогтоох; Дотоод аудитын хараат бус байдлыг хангах, төсвийг батлах, удирдах, гүйцэтгэлийг хянах, дотоод аудитын тайланг хэлэлцэх Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, чөлөөлөх, гүйцэтгэлийг үнэлж, холбогдох саналыг ТУЗ-д хүргүүлэх
Эрсдэлийн удирдлагын хороо <ul style="list-style-type: none"> Александр Пикер (Хорооны дарга) Жеймс Б. Двайер III Роберт В. ван Свитен Ч.Мөнхцэцэг Ж.Үнэнбат 	<p>Эрсдэлийн удирдлагын хороо нь 3 хараат бус гишүүн, нийт 5 гишүүнтэй бөгөөд даргаар нь ТУЗ-ийн хараат бус гишүүн Александр Пикер, Нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга З.Солонго ажилладаг.</p> <p>Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд сар бүр хуралддаг.</p> <ul style="list-style-type: none"> Эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийн аппетит лимитүүд, эрсдэлийг удирдах стратеги, зээлийн бодлого, зээлийн хорооны дүрэм, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, комплаенсын бодлого зэргийг сайжруулах, батлах саналыг ТУЗ-д гаргах, Гүйцэтгэх удирдлагад хэрэгжүүлэх чиг үүрэг өгч, хэрэгжилтэд хяналт тавих Гүйцэтгэх удирдлагын Эрсдэлийн удирдлагын хорооны тайлан, Санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэл, Комплаенс тайланг хэлэлцэх, хянах Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг Банкны баримтлах бодлого, МУТСТ дотоод хяналтын хөтөлбөрийг батлах, түүний хэрэгжилтийг хянах ба энэ талаарх үйл ажиллагааны улирлын тайланг хянах Гүйцэтгэх удирдлагын баталсан тодорхой дүнгээс дээш зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийн үүрэг хүлээсэн групп компаниудын зээлийн шийдвэрийг хянах, шаардлагатай гэж үзвэл тус шийдвэрийг хэрэгжүүлэхэд хориг тавих.

Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо <ul style="list-style-type: none"> Жеймс Б. Двайер III (Хорооны дарга) Александр Пикер Ч.Мөнхцэцэг 	<p>Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо нь нийт 3 гишүүнтэй бөгөөд даргаар нь ТУЗ-ийн Хараат бус гишүүн Жеймс Б. Двайер, Нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга З.Солонго ажилладаг.</p> <p>Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд улирал бүр хуралддаг.</p> <ul style="list-style-type: none"> Засаглалын кодекс болон түүнд багтсан бүх бодлогын хэрэгжилтийг хянаж, цалин хөлс, урамшууллын системийг боловсруулах, батлахад ТУЗ-д санал, зөвлөмж өгдөг ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын цалин хөлс, урамшууллыг тогтоох Гүйцэтгэх захирал ба гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх Банкны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангахтай холбоотой журам дүрэмтэй танилцаж, хянан хэлэлцэж, банкны борлуулалт болон төвийн нэгжийн цалингийн систем, тэдгээрийн гүйцэтгэлд суурилсан урамшууллын систем, сонгон шалгаруулалтын журам, ажилтанд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох журам, ажилтнуудын халамж тэтгэмжийн журам зэрэг бичиг баримтуудыг хянах, сайжруулах
Нэр дэвшүүлэх хороо <ul style="list-style-type: none"> Александр Пикер (Хорооны дарга) Роберт В. ван Свитен Ч.Мөнхцэцэг 	<p>Нэр дэвшүүлэх хороо нь нийт 3 гишүүнтэй бөгөөд даргаар нь ТУЗ-Хараат бус гишүүн Александр Пикер, Нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга З.Солонго ажилладаг.</p> <p>Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд улирал бүр хуралддаг.</p> <ul style="list-style-type: none"> Засаглалын кодекс болон түүнд багтсан бүх бодлогын хэрэгжилтийг хянаж, Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх тухай ТУЗ-д санал, зөвлөмж өгдөг ТУЗ-ийн бүрэлдэхүүний зохистой байдал, зөвлөлийн мэргэжил, мэргэшлийн уялдаа бүтцийг хянах, бодлого тодорхойлох ТУЗ-ийн энгийн болон Хараат бус гишүүдийг сонгон шалгаруулах, томилох, буцаан татах Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, буцаан татах Гүйцэтгэх захирал ба гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх

ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын онцлох үйл явдал

Стратегийн гол чиглэлүүд

Голомт банкны ТУЗ нь банкны санхүүгийн үр дүнг тогтмол хянаж, дотоодын болон олон улсын макро эдийн засгийн үзүүлэлт, чиг хандлага, улс төр, хууль журмын нөхцөл байдал, өөрчлөлтийн хүчин зүйлс, нөлөөллийг харгалзан тогтмол хуралдаж, шийдвэр гарган ажиллалаа.

Засаглалын олон улсын стандартуудыг баримтлах зорилгынхоо хүрээнд Голомт банк 2025 онд засаглалын томоохон баримт бичгүүдээ шинэчлэх төслийг эхлүүлсэн. Үүнд, Засаглалын кодекс, Ёс зүйн дүрэм, Соёлын кодекс, Банкны дүрэм, ХЭХ-ийн журам, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрмүүд зэрэг бодлогын баримт бичгүүдэд сайжруулалт хийхээр судалгаа, шинжилгээг хийж, боловсруулалтын түвшинд ажиллаж байна. Энэхүү шинэчлэл нь олон улсын шилдэг туршлага, Монгол Улсын хууль

тогтоомж, зохицуулалтын шаардлагад нийцүүлэх, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлага, хяналтын механизмыг илүү тодорхой болгох, ил тод байдал болон тайлагналыг бэхжүүлэхэд чиглэсэн байна. Ингэснээр компанийн засаглалын тогтолцоо илүү боловсронгуй болж, хяналт сайжирч, үр өгөөж дээшлэх юм.

2025 оны онцлох амжилт бол Голомт банк олон улсын хамтран ажиллагчдаасаа нийт 380 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлсэн явдал байв. Энэхүү санхүүжилт нь Голомт банкны санхүүгийн чадавхыг бэхжүүлэх, урт хугацааны тогтвортой өсөлтийг дэмжих, ногоон болон тогтвортой санхүүжилтийн бүтээгдэхүүн болон жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагчдад чиглэсэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Түүнчлэн Голомт банкны үйл ажиллагаа, засаглал,

ил тод байдал нь бат бөх бөгөөд Банкны олон улсын түншлэлийн итгэлцэл өндөр түвшинд байгааг илэрхийлж байна.

Тасралтгүй үйл ажиллагаа, тогтвортой хөгжин тэлэхийг эрмэлзэж, тайлант хугацаанд дотоод үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалттай холбоотой 8 шийдвэрийг гаргаж, хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

Шинэ стратеги, гадаад өөрчлөлтөд дасан зохицох, тэдгээрийн хэрэгжилтийг хянан сайжруулахтай холбогдуулан 7 шийдвэр гаргаж, томоохон бодлогын баримт бичгүүдээ шинэчиллээ.

Стратегитай уялдаатай эрсдэлийн стратеги, аппетит лимитүүдийг шинэчлэв

2025 онд ТУЗ нь банкны Эрсдэлийн аппетитийн мэдэгдэл, Эрсдэлийн бодлого, Эрсдэлийн удирдлагын стратеги болон холбогдох эрсдэлийн бодлогыг тогтмол хянаж,

Ингэснээр Банкны зорилгоо хэрэгжүүлэх

шинэчлэн баталсан. Ингэснээр Банк стратегийн зорилтоо хэрэгжүүлэх хүрээнд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшин, хязгаарыг тодорхойлж, хэмжих, хянах болон удирдах үйл ажиллагааг нэгдсэн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэв.

Зээлийн эрсдэлийн үйл ажиллагааг сайжруулав

Банкны зээлийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, зээлийн багцын чанарыг сайжруулах зорилгоор Зээлийн бодлогыг хянан хэлэлцэж, шинэчлэн баталсан. Үүний хүрээнд зээлийн үнэлгээ, шийдвэр гаргалт, хяналт шинжилгээний үйл явцыг боловсронгуй болгож, зээлийн үйл ажиллагааг хяналттай, тогтвортой хэрэгжүүлэх суурийг бэхжүүлсэн.

Комплаенс, МУТСТ хөтөлбөр батлав

ТУЗ нь Комплаенсийн бодлого, 2026 оны МУТСТ дотоод хөтөлбөрийг хянан шинэчлэн баталж, Банкны үйл ажиллагааны хууль, зохицуулалтын шаардлагыг чанд мөрдөх суурийг бэхжүүлэв. Шинэчилсэн бодлого, батлагдсан хөтөлбөр нь зохицуулалтын шаардлага, эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэгтгэж, ил тод, хариуцлагатай үйл ажиллагааг дэмжих үндэс суурь болдог.

Бүтэц, зохион байгуулалттай холбоотойгоор шинэчлэлийг хийв

Тайлант хугацаанд ТУЗ-өөс байгууллагын бүтэц, удирдлагын зохион байгуулалтыг шинэчлэн батлав. Энэ хүрээнд мэдээллийн хүртээмж, урсгалыг хангар зорилгоор Ил тод байдлын хороог шинэчлэн байгуулж, санхүүгийн үр нөлөөг сайжруулахын тулд Санхүү хариуцсан захирлын албан тушаалыг шинээр баталсан. Түүнчлэн татварын нийцлийн хяналтыг бэхжүүлэх зорилгоор Санхүүгийн удирдлагын газрын дор Татварын албыг байгуулж, ТУЗ нь хяналтын хүрээн дэх стратегийн болон зохицуулалтын чиг үүргүүдийг тодорхойлсон.

Хүний нөөцийн чадавх, ажилтны

Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитоор нэмэгдүүлэхэд чиглэсэн ба тус бодлого нь банкны урт хугацааны өсөлт, хөрөнгө удирдлагын тогтвортой байдлыг хадгалахтай уялдуулан хэрэгжиж, хувьцаа эзэмшигчдийн итгэлийг бэхжүүлэх чухал илэрхийлэл болно.

үр бүтээмжийг нэмэгдүүлэх, зах зээлийн стратегийг дэмжих, харилцагчийн туршлагыг сайжруулах зорилгоор ТУЗ-өөс Хүний нөөцийн удирдлагын бодлого, Маркетингийн бодлого, Харилцагч төвтэй банкны бодлогыг мөн шинэчлэн баталж, бодлогын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Гүйцэтгэх удирдлагын томилгоо, албан тушаалыг шинээр батлав

1. Эрсдэл хариуцсан захирлын албан тушаалд хатагтай Т.Отгоныг томилов. Тайлант хугацаанд Голомт банк нь эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Эрсдэл хариуцсан захирал буюу Chief Risk Officer /CRO/-ыг томилсон. Тус томилгоо нь эрсдэлийг нэгдсэн байдлаар удирдах, эрсдэлийн хяналтыг сайжруулах, зохицуулалтын шаардлагын нийцлийг хангах, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын түвшинд эрсдэлийн хяналтын үр нөлөө болон хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн юм.

2. Санхүү хариуцсан захирлын албан тушаалыг шинээр бий болгов.

Голомт банк нь санхүүгийн удирдлага, стратеги, тайлагнал, дотоод хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Санхүү хариуцсан захирал буюу Chief Financial Officer /CFO/ албан тушаалыг шинээр бий болголоо. Санхүүгийн бодлого, тайлагналын ил тод байдал, санхүүгийн сахилга бат болон ТУЗ-ийн хяналтыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой албан тушаал юм.

Хувьцаа эзэмшигчдийн үнэ цэн

Голомт банк тайлант хугацаанд 2024 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаанд 100 төгрөг, нийт 80.8 тэрбум төгрөгийг хуваарилан хувьцаа эзэмшигчдэд 2025 оны 4-р сарын 25-ны өдөр олгож, бодит өгөөжийг бий болголоо. Банкны тогтвортой ашигт ажиллагаа, мөнгөн урсгалын чадавхыг илэрхийлэхийн зэрэгцээ

Жилийн тайлан 2025
● **Голомт банк**

Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитоор нэмэгдүүлэхэд чиглэсэн ба тус бодлого нь банкны урт хугацааны өсөлт, хөрөнгө удирдлагын тогтвортой байдлыг хадгалахтай уялдуулан хэрэгжиж, хувьцаа эзэмшигчдийн итгэлийг бэхжүүлэх чухал илэрхийлэл болно.

хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитоор нэмэгдүүлэхэд чиглэсэн ба тус бодлого нь банкны урт хугацааны өсөлт, хөрөнгө удирдлага, тогтвортой байдлыг хадгалахтай уялдуулан хэрэгжиж, хувьцаа эзэмшигчдийн итгэлийг бэхжүүлэх чухал илэрхийлэл болно.

Хувьцаа эзэмшигчидтэй харилцах чиг үүргийг стратегийн түвшинд бэхжүүлэх зорилгоор Хөрөнгө оруулагч нартай харилцах албыг Хэлтэс болгон өргөжүүлж, бүтэц, орон тоо, үйл ажиллагааг сайжрууллаа. Ингэснээр мэдээллийн ил тод байдал, тасралтгүй шуурхай байдал, харилцааны чанар сайжирч, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид болон олон нийтэд чиглэсэн мэдээлэл түгээх, харилцах, гомдол санал хүлээн авах тогтолцоо илүү үр өгөөжтэй болсон.

Тайлант хугацаанд Гүйцэтгэх удирдлагын багийн контрактын гэрээг шинэчлэн гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоонд хувьцааны урамшуулал олгох боломжийг контрактын хүрээнд бий болголоо. Энэхүү шинэчлэл нь удирдлагын багийн урт хугацаанд тогтвортой ажиллах хөшүүрэг байхаас гадна шийдвэр гаргалт, гүйцэтгэлийг банкны урт хугацааны үнэ цэн, хувьцааны үнэлгээтэй шууд уялдуулах стратегийн ач холбогдолтой. Ингэснээр богино хугацааны үр дүн бус тогтвортой өсөлт, үнэлгээнд суурилсан хариуцлагатай гүйцэтгэлийн тогтолцоог баталгаажууллаа.

Голомт банк нь гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог сайжруулж, удирдлага болон нэгжүүдийн гүйцэтгэлийг нэгдсэн хамтын KPI болон орлого эрсдэлд суурилсан KPI үзүүлэлттэй нягт уялдууллаа. Энэ нь байгууллагын стратегийн зорилго, санхүүгийн үр дүн, үйл ажиллагааны гүйцэтгэл хоорондын уялдаа холбоог бэхжүүлж, гүйцэтгэлийг хэмжих, үнэлэх ил тод, бодит шалгуурыг бүрдүүлдэг.

Ил тод байдал, хариуцлагын хүрээнд Голомт банк нь засаглалын зохистой

Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, тогтвортой хөгжил

Журмыг хэрэгжүүлэх тайлан, холбогдох этгээдтэй хийсэн хэлцэл, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан зэрэг олон нийтэд хүргэх мэдээллүүдээ тогтмол нийтэлж, зохицуулагч байгууллагуудад хууль, журмын дагуу тайлагналаа. Ил тод байдлын хамгийн өндөр стандартыг бэхжүүлэх зорилгынхоо хүрээнд банкны бүтэц, зохион байгуулалтаа шинэчилж, Мэдээллийн ил тод байдлын хороог Гүйцэтгэх удирдлагын дор шинээр байгуулав.

журмыг хэрэгжүүлэх тайлан, холбогдох этгээдтэй хийсэн хэлцэл, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан зэрэг олон нийтэд хүргэх мэдээллүүдээ тогтмол нийтэлж, зохицуулагч байгууллагуудад хууль, журмын дагуу тайлагналаа. Ил тод байдлын хамгийн өндөр стандартыг бэхжүүлэх зорилгынхоо хүрээнд банкны бүтэц, зохион байгуулалтаа шинэчилж, Мэдээллийн ил тод байдлын хороог Гүйцэтгэх удирдлагын дор шинээр байгуулав.

Дижиталчлал, мэдээллийн технологи

Голомт банк нь 2026 оны Мэдээллийн аюулгүй байдлын стратеги болон Мэдээллийн технологийн бодлого, Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг шинэчлэн баталж, технологийн засаглал болон мэдээллийн аюулгүй байдлаа сайжруулан бэхжүүлсэн. Ингэснээр кибер аюулгүй байдал, өгөгдлийн нууцлал, системийн найдвартай ажиллагаа, бизнесийн тасралтгүй байдлыг хангах чадавх сайжрах бөгөөд технологийн засаглал, мэдээллийн аюулгүй байдлын соёлыг Банкны бүх түвшинд төлөвшүүлж, дижитал хөгжилд суурилсан тогтолцоог бүрдүүлж байна.

Мэдээллийн технологи, аюулгүй байдалтай холбоотойгоор өгөгдлийн чанар, бүрэн байдал, аюулгүй байдлыг сайжруулан бэхжүүлэхээр

Мэдээллийн технологи, аюулгүй байдалтай холбоотойгоор өгөгдлийн чанар, бүрэн байдал, аюулгүй байдлыг сайжруулан бэхжүүлэхээр

Нэр дэвшүүлэх хорооны онцлох ажил

Нэр дэвшүүлэх хорооны онцлох ажил

Нэр дэвшүүлэх хороо нь 2025 онд 5 удаа хуралдаж, ХЭХ-ын бэлтгэл ажил, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулалт болон бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, төсөвтэй холбоотой нийт 7 асуудал хэлэлцэж, холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

ТУЗ-ийн томилгоо

Голомт банк нь ТУЗ-ийн гишүүдийг 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулж, улируулан томилж, засаглалын

Дата удирдлагын бодлогыг мөн шинэчлэн батлав.

Дата удирдлагын бодлогыг мөн шинэчлэн батлав.

Тогтвортой байдал болон БОНЗ

2025 онд шинээр батлагдсан Эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд БОНЗ-ын хэмжүүрүүдийг нэвтрүүлэн баталсан. БОНЗ-ын эрсдэлийг стратегийн түвшинд үнэлж, тодорхойлох боломжтой болсон бөгөөд энэ нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны уялдаа, тогтвортой байдлыг нэмэгдүүлж, БОНЗ-ын үзүүлэлтүүдийг стратегийн зорилттой уялдуулан хэрэгжүүлэх, хянах суурийг тавьж өгсөн.

Тайлант хугацаанд PwC байгууллагатай хамтран ажиллаж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ 1: Тогтвортой байдалтай холбоотой мэдээллийн ил тод байдлын ерөнхий шаардлага болон СТОУС 2: Уур амьсгалтай холбоотой тодруулга стандартуудыг хэрэгжүүлэх үнэлгээг хийлгүүлдэг. Үүний хүрээнд Олон улсын тогтвортой байдлын зөвлөл /ISSB/-ийн шинэ стандартуудтай харьцуулсан зөрүүний шинжилгээ хийгдэж, шаардлагатай шинэчлэл, сайжруулалтын хэрэгцээг тодорхойлж, хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, сонгох, томилох үйл явц

Голомт банканд ТУЗ-ийн гишүүн

Томилогдох үйл ажиллагаа нь ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны үүрэг ба тус хороо нь тохиромжтой нэр дэвшигчдийг хэрхэн тодорхойлох тал дээр ажиллана. Ингэхдээ ТУЗ-ийн Хараат бус гишүүний зарыг дотоодод болон олон нийтэд нээлттэй хүргүүлж, хүсэлтээ ирүүлсэн боломжит нэр дэвшигчдийг Нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцдэг. Банкны тухай хууль, зохицуулагч байгууллагуудын журам, Голомт банкны дүрэм, Хорооны дүрэмд үндэслэн тодорхойлсон шаардлагын дагуу сонгон шалгаруулалтыг хийж, гүйцэтгэн эцсийн нэр дэвшигчийг сонгох шийдвэрээ гарган ТУЗ-д санал болгодог. ТУЗ-ийн томилгоо нь ажлын туршлага, ур чадварт суурилсан бөгөөд ТУЗ-ийн бүрэлдэхүүн болон Банкны ерөнхий үйл ажиллагаанд оруулах хувь нэмрийг харгалзан үздэг. ТУЗ-ийн хурлаар нэр дэвшигчийг сонгон шалгаруулахдаа Монголбанкнаас хууль журмын дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэн шалгуулж зөвшөөрөл авдаг.

2025 онд Голомт банкны ТУЗ-ийн бүрэлдэхүүнд Хараат бус гишүүнээр Ноён Ронил Сүжан сонгогдож, тус оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шинээр томилогдсон юм.

*Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Ноён Ронил Сүжаны танилцуулгыг 38-р хуудаснаас уншина уу.

Д.Мөнхтөр, О.Ганжолоо нар энгийн гишүүдээр, Жеймс Б. Двайер III, Александр Пикер, Роберт в. Ван Свитен, Ханс Холзхакер нар хараат бус гишүүдээр улиран томилогдов.

2. Тус хурлаар ТУЗ-ийн гишүүн Ронил Сүжан нь хараат бус гишүүний албан тушаалд шинээр томилогдож, нийт ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг дийлэнх хараат бус болсон.

ТУЗ-ийн гишүүдийн сургалт, хөгжил

Голомт банк нь ТУЗ-ийн шинэ гишүүдийг үүрэгт ажилд мэдээллээр хангах, банкны үйл ажиллагааг бүрэн мэдээлэх зорилгоор биечлэн чиглүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг билээ. Тус хүрээнд банкны стратеги, бизнес загвар, эрсдэлийн удирдлагын тогтолцоо, зохицуулалтын орчин, дотоод хяналтын тогтолцоо, санхүүгийн болон тогтвортой байдлын

тайлагнал, гол бодлого, дүрэм, журмуудын цогц мэдээллийг олгодог.

2025 оны 6-р сард Голомт банкны ТУЗ-ийн нийт бүрэлдэхүүн биечлэн хүрэлцэн ирж, банкны үйл ажиллагаа, бодлогын түвшний мэдээ мэдээлэлтэй танилцаж, зохицуулагч байгууллагуудтай биечлэн уулзалт хийж, Гүйцэтгэх удирдлагатай ажил хэрэгч хурлуудыг зохион байгуулав.

Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны онцлох ажил

Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо нь 2025 онд 5 удаа хуралдаж, дүрмийн нэмэлт, өөрчлөлт, баримт бичгийн хэрэгжилт, цалин урамшууллын бодлого, Гүйцэтгэх удирдлагын багийн гүйцэтгэл, урамшуулалтай холбоотой нийт 5 асуудал хэлэлцэж, холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

ТУЗ-ийн гүйцэтгэл болон үнэлгээ

Голомт банк нь ТУЗ-ийн гүйцэтгэл, хяналтын үр нөлөөг бодитойгоор хэмжих, тасралтгүй сайжруулах зорилгоор үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлдэг. Энэ нь ТУЗ-ийн шийдвэр гаргалтын чанар, эрсдэлийн хяналт, хороодын уялдаа, гишүүдийн оролцооны идэвх зэрэг бодит шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурладаг.

ТУЗ-ийн гишүүд хоорондын үнэлгээгээр гишүүн тус бүрийн

мэргэжлийн үйл ажиллагаа, хараат бус байдал, ТУЗ-ийн ажиллагаанд оруулж буй хувь нэмэр зэргийг үнэлдэг бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн давуу тал, сургалт, хөгжлийн үйл ажиллагаа, бүрэлдэхүүний оновчлолд ач холбогдолтой юм.

Үүний сацуу ТУЗ-ийн бүрэлдэхүүний үнэлгээг тогтмол хийж, ТУЗ-ийн бүтэц, хурлын зохион байгуулалт, хэлэлцэх асуудлын чанар, стратегийн болон хяналтын чиг үүргийн тэнцвэр, хороодын уялдааг дүгнэдэг. Ингэснээр ТУЗ-ийн үйл ажиллагааг бодитой сайжруулах, засаглалын тогтолцоог тасралтгүй хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар хэрэгжүүлэхэд чиглэдэг.


ТУЗ-ийн цалин урамшуулал

ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын тогтолцоог хараат

бус байдал, хяналтын үр нөлөөг хадгалах, засаглалын зарчимд тулгуурлан тогтоодог. Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны дүрэмд Голомт банкны ТУЗ-ийн гишүүн нь тогтмол суурь цалин авах бөгөөд үүн дээр тус гишүүн ТУЗ-ийн дэргэдэх хорооны дарга эсвэл гишүүний бүрэлдэхүүний нэмэгдэл олгогддог. Энэ нь гишүүдийн оролцоог дэмжиж, хариуцлагын түвшнийг бодитоор үнэлэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Түүнчлэн ТУЗ-ийн гишүүдэд Банкны гүйцэтгэл, ашигт ажиллагаа, санхүүгийн үр дүнгээс хамаарсан аливаа урамшуулал, гүйцэтгэлд суурилсан нэмэгдэл олгогддоггүй тул ТУЗ-ийн хараат бус, бодитой шийдвэр гаргах, үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, хянах, стратегийн шийдвэр гаргалтыг ашиг сонирхлын зөрчилгүй хэрэгжүүлэх засаглалын чухал зарчим юм.

Хэлэлцсэн асуудлууд



Аудитын хороо нь шаардлагатай тохиолдолд хорооны эрхлэх асуудлын хүрээнд тусгайлсан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, банкны нууцад хамаарах баримт, материалтай танилцах, холбогдох албан тушаалтнаар мэдээлэл гаргуулах эрхтэй байна. Дотоод аудитын болон хөндлөнгийн аудитын тайлан, илэрсэн зөрчил, зөвлөмжүүд нь Аудитын хороонд шууд тайлагнагддаг.

Аудитын хороо нь банкны сар бүрийн санхүүгийн үзүүлэлтүүдийг хянаж, Удирдлагын багт үүрэг, зөвлөмж өгдөг. Мөн хөндлөнгийн аудитын тайлан, Монголбанкны шалгалтын үр дүнг хэлэлцэж, батлах саналыг ТУЗ-д хүргүүлж ажилладаг.

Аудитын хороо нь нягтлан бодох бүртгэлийн стандарт, хууль эрх зүйн орчинд гарч буй санхүүгийн тайлагналд нөлөө үзүүлэхүйц өөрчлөлтүүд, банкиг нэр хүндийн эрсдэлд оруулж болзошгүй асуудлын талаар байнгын мэдээлэлтэй байдаг.

Аудитын хороо нь Дотоод аудитын үйл ажиллагааны эрх, үүргийг тусгасан дүрэм, үйл ажиллагааны журам, эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөөг хэлэлцэж, холбогдох саналыг ТУЗ-д хүргүүлдэг. Мөн Дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг, үйл ажиллагаандаа олон улсын стандарт, арга аргачлал, сайн туршлагыг нэвтрүүлж буй эсэхийг болон аудитын тайлан, тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянадаг. Аудитын хороо нь Аудит

хариуцсан захирлыг томилох, чөлөөлөх саналыг ТУЗ-д хүргүүлж, дотоод аудитын үйл ажиллагааны нэгжүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин урамшууллыг тогтоодог.

Хөндлөнгийн аудитын байгууллагыг дахин сонгох үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 00/06 тоот тогтоолын дагуу Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь 2025 оны санхүүгийн жилийн хөндлөнгийн аудитор байгууллагаар ажилласан. Хөндлөнгийн аудиторын ажиллах хугацаа нь Монгол Улсын Аудитын тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд уг хуулийн хүрээнд банкны Аудитын Хорооны хурлаар хэлэлцэж банкны санхүүгийн аудиторыг сонгодог.

Хөндлөнгийн аудитын гүйцэтгэл, хараат бус байдлын үнэлгээ

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь хөндлөнгийн аудитын гүйцэтгэл, хараат бус байдал, мэргэжлийн байдлыг тогтмол үнэлж, аудитын аргачлал, тайлагналын чанар болон дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах зөвлөмжийг гаргадаг. Шаардлагатай үед хөндлөнгийн аудитын байгууллага, Аудитын хороо нь Гүйцэтгэх удирдлагын оролцоогүйгээр хурал зохион байгуулж, холбогдох асуудлаар хэлэлцэх эрхтэй байх бөгөөд энэ нь хөндлөнгийн аудитын хараат бус байдал, ил тод байдлын баталгаажуулахад чиглэсэн байна.

Аудитын хороо нь хөндлөнгийн аудитын жилийн үр дүн, хагас жилийн үр дүнгээр хэлэлцэж, холбогдох санал, зөвлөмжийг хүргүүлдэг.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь аудитын бус үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой болон бусад ямар нэгэн харилцаа банкттай үүсгэх, аливаа харилцаа холбооноос үүсэх хараат бус байдалд нөлөөлөх эрсдэл, эдгээр эрсдэлүүдийн эсрэг авах арга хэмжээнүүдийн талаар Аудитын хороонд мэдэгдэх үүрэгтэй. 2025 онд Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн бодитой байх болон хараат бус байдалд нөлөөлөх аливаа зүйл илрээгүй бөгөөд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдсөн.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь аудитын дүгнэлт, үр дүнг банкны Аудитын хороонд бүрэн тайлагнасан.

Санхүүгийн тайлагнал, ил тод байдлын хяналт

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороод нь сар бүр тогтмол хуралддаг бөгөөд тус хурлуудаар санхүүгийн тайлантай танилцаж, хяналт тавьдаг. Санхүүгийн тайланг мөн Дотоод аудитын газар давхар баталгаажуулсан байх ба Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны хурлуудаар санхүүгийн тайлангийн ил тод, үнэн зөв байдлыг хангах зорилгоор нягт хянан хэлэлцдэг.

Голомт банк нь хууль тогтоомжийн дагуу зохицуулалтын шаардлагад нийцүүлж, санхүү, үйл ажиллагааны бүх тайланг бэлтгэж, холбогдох байгууллагуудад цаг тухайд нь хүргүүлэн ажилладаг.

Түүнчлэн, санхүүгийн тайлагналын үнэн зөв, ил тод байдлыг бэхжүүлэх, мэдээллийн тасралтгүй байдлыг хангах хүрээнд Санхүүгийн удирдлагын газрын зохион байгуулалтыг шинэчилж, татвар хариуцсан нэгжийг байгуулж, стратегийн шинэчлэлийн хүрээнд

Аудитын хорооны онцлох ажил

Аудитын хороо нь 2025 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 11 удаа, дунджаар 93%-ийн ирцтэй хуралдаж, 39 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

Аудитын хороо нь дараах үйл ажиллагаатай холбоотой чиг

үүргийг хэрэгжүүлдэг.

- Санхүүгийн тайлантай холбоотой
- Дотоод хяналтын тогтолцоотой холбоотой
- Дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой
- Хөндлөнгийн аудитын үйл

ажиллагаатай холбоотой

- Комплаенсын үйл ажиллагаатай холбоотой
- Тайлагналын үйл ажиллагаатай холбоотой
- Бусад үйл ажиллагаатай холбоотой

Санхүү хариуцсан захирлын албан тушаалыг шинээр байгуулж санхүүгийн тайлагналын процессыг уялдуулах, боловсронгуй болгохоор ажиллалаа.

Аудитын хорооноос аудиттай холбоотой гол асуудлуудад тайлбар өгсөн байдал

ТУЗ-ийн Аудитын хороо нь 2025 онд танилцуулагдсан аудитын гол үр дүнд үндэслэн дараах үүрэг, зөвлөмжийг өгсөн.

- Банкны бизнес, тэр дундаа дижитал бизнестэй холбоотой

аудитуудын үр дүнд үндэслэн давхар борлуулалтыг өсгөх, лояалти хөтөлбөрийг дараагийн түвшинд гаргах, концепцийг өөрчлөх зөвлөмжүүдийг өгч ажилласан.

- Мэдээллийн технологи, кибер аюулгүй байдалтай холбоотой аудитуудын үр дүнд эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах процессыг илүү боловсронгуй болгох нь зүйтэй талаар онцолсон.
- Үйл ажиллагаатай холбоотой

аудитуудын үр дүнд дотоод процесст анализ хийж, бүтээмжийг сайжруулж, дотоод дижитал шилжилтийг хурдасгах зөвлөмжийг өгч ажилласан.

- Мөн Дотоод аудитын газраас аудитын үр дүнд өгсөн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулахтай холбоотой үндсэн шалтгаанд суурилсан зөвлөмжүүдийг онцгой анхааралдаа авч, зөвлөмжүүдийг цаг тухайд нь, үр дүнтэй хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон.

Эрсдэлийн удирдлагын хорооны онцлох ажил

Эрсдэлийн удирдлагын хороо нь 2025 онд 39 удаа хуралдаж, нийт 108 асуудал хэлэлцэж, холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан. Үүнд:


- 77% нь 20 тэрбум төгрөг буюу түүнээс зээлтэй групп компаниудын хүсэлтийг шийдвэрлэсэн Зээлийн хорооны хяналт;
- 15% нь Эрсдэлийн тайлан мэдээлэл, эрсдэлийн удирдлага бодлого;
- 8% нь бусад цаг үеийн асуудал, мэдээлэл хэлэлцсэн байна.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Банк нь дараах зорилготойгоор Эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг.

- Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, процесс, систем, гуравдагч талууд болон гадаад хүчин зүйлээс үүдэлтэй эрсдэлийг тодорхойлох;
- Тоон үзүүлэлтүүд болон чанарын үнэлгээг хослуулан (эрсдэлийн үнэлгээ, рейтинг, стресс тест гэх мэт) эрсдэлийг шинжилж, үнэлэх;
- Бодлого, журам, зөвшөөрөл, лимит болон урьдчилан сэргийлэх/илрүүлэх хяналтуудаар дамжуулан эрсдэлийг хянах, бууруулах болон зохистой арга хэмжээг авах;
- Эрсдэлийн үзүүлэлт, хязгаарлалт, бодит тохиолдол, шинээр үүсэж болзошгүй эрсдэлийг тогтмол мониторинг хийх;
- ТУЗ болон удирдлагын түвшний

- хороодод тогтмол тайлагнах, шаардлагатай тохиолдолд шатлах мэдээлэх (escalate);
- Зохицуулагч байгууллагын хяналт шалгалт, Дотоод аудитын баталгаажуулалтын зөвлөмж, сургамжид тулгуурлан эрсдэлийн удирдлагын тогтолцоог тогтмол сайжруулах.



Эрсдэлийн засаглал

ТУЗ нь Банкны эрсдэлийн төлөв байдал, эрсдэлийн аппетит болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр нөлөөтэй байдлыг тогтмол хянадаг. ТУЗ (шууд болон өөрийн дэргэдэх хороогоор дамжуулан) эрсдэлийн бодлогуудыг баталж, эрсдэлийн аппетит болон хязгаарлалтыг тогтоож, Банк баталсан хязгаарлалтын хүрээнд байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг.

ТУЗ-ийн хороонд болон Удирдлагын түвшний хороод

- ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо: Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн аппетитийн хэрэгжилт болон материаллаг эрсдэл тохиолдолд хяналт тавих
- ТУЗ-ийн Аудитын хороо: Дотоод хяналтын тогтолцоо, санхүүгийн тайлагналтай холбоотой эрсдэлүүд болон баталгаажуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих
- Удирдлагын түвшний хороод (Эрсдэлийн удирдлагын хороо, Актив пассивын хороо, Зээлийн хороо, Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хороо, Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын хороо): Өдөр тутмын шийдвэр гаргалт, хязгаарлалтуудын хэрэгжилтийг хянах болон эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хяналт тавих

Гурван шугамын загвар

Банк эрсдэлийн гурван шугамын загварыг нэвтрүүлэн хэрэгжүүлдэг. Үүнд:

- Банкны бодлого, журам болон өөрсдийн чиг үүргийн хүрээнд өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааныхаа эрсдэлийг хариуцан ажилладаг бизнес нэгжүүд болон тэдгээрийг дэмжих чиг үүрэгтэй нэгжүүд “Нэгдүгээр шугам”-д хамаарна.
- “Нэгдүгээр шугам”-д хамаарах нэгжүүдийг эрсдэлээ хэрхэн удирдаж байгаад хяналт тавих, банкны хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, хязгаарлах чиг үүрэгтэй нэгжүүд “Хоёрдугаар шугам”-д хамаарна.
- Хараат бус дотоод аудитын чиг үүрэгтэй нэгжүүд “Гуравдугаар шугам”-д хамаарна.

Эрсдэлийн соёл

Банк нь удирдлагын үлгэрлэн манлайлал, бодлого ба сургалт, гүйцэтгэлийн удирдлага, мөн асуудлыг цаг тухайд нь шатлан мэдээлэх тодорхой хүлээлтээр дамжуулан эрсдэлийг ухамсарласан соёлыг төлөвшүүлдэг. Эрсдэлийн удирдлагыг тусдаа үйл ажиллагаа гэж үзэхгүй, харин бизнесийн төлөвлөлт, төсөвлөлт, бүтээгдэхүүн батлах процесс, аутсорсингийн шийдвэр, өөрчлөлтийн удирдлагад бүрэн нэгтгэн хэрэгжүүлдэг.

Холбогдох этгээдтэй хийх хэлцэл

Голомт банк нь холбогдох этгээдтэй хийх хэлцлүүдийг зохицуулалтыг шаардлагад нийцсэн, ил тодоор мэдээлдэг бөгөөд аливаа сонирхлын зөрчил үүсэхгүй байх шаардлагад ТУЗ хяналт тавин ажилладаг. Банкны санхүүгийн ил тод байдал болон засаглалын тогтолцоо баталгаажуулах, холбогдох этгээдтэй хийсэн хэлцлүүдийн үнэн зөв байдлыг тасралтгүй ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд холбогдох этгээдтэй хийсэн хэлцэлтэй холбоотой 6 тогтоол ТУЗ-аас баталсан бөгөөд тус мэдээллийг бид өөрийн цахим хуудас, Монголын хөрөнгийн биржид ил тод мэдээлэхээс гадна зохицуулагч байгууллагуудад мөн тайлагнадаг.

Байгууллагын соёл

Голомт банк нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн банк санхүүгийн салбарт “Голомтын соёл, Голомтын гоёл” соёлын ялгарлыг бий болгож, бэхжүүлсээр ирсэн. Голомт банкны соёл нь ажилтан бүр мэргэжлийн ур чадвараа тогтмол дээшлүүлж, өндөр ёс зүйг эрхэмлэн гүйцэтгэл ба бодит үр дүнд суурилсан, тасралтгүй суралцагч соёлыг бүрдүүлэн ажилладаг.

Голомт банк тасралтгүй суралцах соёлоороо дамжуулан хувь хүний хөгжлийг тогтмол дээшлүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг.

Бид банкныхаа соёлоор дамжуулан харилцагчид дараах эерэг нөлөөг үзүүлдэг.

- Мэргэжлийн өндөр түвшний зөвлөгөө, найдвартай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх
- Ёс зүйтэй, ил тод харилцаа нь харилцагчийн итгэлцлийг нэмэгдүүлж, урт хугацааны тогтвортой харилцааг бий болгох
- Үр дүнд суурилсан ажиллах арга барил нь үйлчилгээний хурд, чанарыг сайжруулах, харилцагчийн цаг хугацаа, зардлыг хэмнэх
- Тасралтгүй суралцах, шинэ мэдлэг, технологийг нэвтрүүлэх нь харилцагчид илүү шинэлэг, хүртээмжтэй, хэрэгцээнд нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх боломжийг нэмэгдүүлэх

Иймд банкны ажилтнуудын мэргэжлийн, өндөр ёс зүйтэй, гүйцэтгэлд суурилсан, тасралтгүй суралцах соёл нь харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, банк болон харилцагчийн хооронд харилцан итгэлцэлд тулгуурласан, урт хугацааны хамтын ажиллагааг бэхжүүлэх гол үндэс болдог.


Голомт банк 2022 оноос эхлэн “Итгэлцэл дээр суурилсан, өндөр гүйцэтгэлтэй байгууллагын соёл”-ыг бий болгох зорилгоор судалгаа

хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг тусгай эрх бүхий, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, 94 улсад салбартай Great Place to Work® байгууллагаар дамжуулан хөндлөнгөөс, хараат бусаар дотоод ажилтнуудаасаа соёлын индексн түвшинг жил бүр тодорхойлуулсаар байна.

2025 оны байдлаар дэлхийд 170 улс орны 21,000 гаруй ажиллахад таатай байгууллагууд байдаг ба Great Place to Work® байгууллага нь дэлхийн өнцөг булан бүрд үйл ажиллагаа явуулж буй компаниудын 20 сая гаруй ажилтнаас уг судалгааг авч үнэлгээ, дүгнэлт гаргаж өгдөг. Мөн цаашид анхаарах үйл ажиллагааг бодлогын хүрээнд сайжруулах төлөвлөгөөг гаргах замаар жилийн турш хэрэгжилтийг хангаж, байгууллагынхаа соёлыг бэхжүүлэн банкны зорилтыг дэмжин ажилладаг.

Ажиллахад таатай газрын Итгэлцлийн индекс нь Итгэлцэл, Хүндлэл, Бахархал, Нөхөрлөл, Шударга байдал гэсэн суурь 5 үзүүлэлтээс бүрддэг ба судалгаа нь эдгээр үзүүлэлтийг тодорхойлох олон улсын жишиг бүхий 60 асуумжаас бүрддэг.

- Ажилтан удирдлагадаа итгэдэг байх;
- Ажилтан хийж байгаа ажлаараа бахархдаг байх;
- Хамт олонтойгоо хамтарч ажиллахад таатай байх;



- Ажилтан өөрийн албан тушаал, үүрэг, нэр хүндээс үл хамааран ажлын байрны тогтвортой уур амьсгалыг мэдрэх.

Итгэлцлийн индекс /Trust index/-ийн суурь үзүүлэлт болох Итгэлцэл, Хүндлэл, Бахархал, Нөхөрлөл, Шударга байдал гэсэн 5 үзүүлэлтээс бүрддэг.

- 1-3-р индекс нь тухайн байгууллагын удирдлагын манлайлал болон уг байгууллагад итгэлцлийг бий болсон эсэхийг хэмждэг.
- 4-5-р индекс нь ажилтнууд хамт олонтойгоо харилцах харилцаа болон ажилтан өөрийн ажил болон байгууллагыг үнэлэх үнэлэмжийг хэмждэг.

Голомт банк жил бүрийн судалгааны үр дүн болон түүний сайжруулах ажлын төлөвлөгөөний дагуу


				
Итгэлцэл Credibility	Хүндлэл Respect	Шударга байдал Fairness	Бахархал Pride	Нөхөрлөл Camaraderie
<ul style="list-style-type: none"> • Харилцаа • Ур чадвар • Шударга ёс зүйтэй байдал 	<ul style="list-style-type: none"> • Дэмжлэг • Хамтын ажиллагаа • Халамж анхаарал 	<ul style="list-style-type: none"> • Эрх тэгш байдал • Тэгш оролцоо • Ёс зүй 	<ul style="list-style-type: none"> • Ажил • Баг хамт олон • Байгууллага 	<ul style="list-style-type: none"> • Нөхөрсөг байдал • Халуун дулаан уур амьсгал • Багийн уур амьсгал

үйл ажиллагааг хэрэгжүүлснээр “Ажиллахад таатай газар” батламжийг 2022 онд Монгол Улсын банк, санхүүгийн салбарт анхлан авсан амжилтаа улам бататган 2025 онд “Ажиллахад таатай газар” батламжийг Монгол Улсад дөрвөн жил дараалан авсан

анхны байгууллагаар тодорч, жил бүр соёлын индексийн үр дүнгээ тогтмол өсгөж байна.

Бид энэ төрлийн судалгаагаар батламжлагдсан Монгол Улсын бусад байгууллагуудаас соёлын индексийн түвшин 9%-аар

дээгүүр, Азийн батламжлагдсан байгууллагуудтай соёлын индексийн түвшин ижил байгаа ба хөдөлмөрийн зах зээлд ажил олгогчийн брэндигээр тэргүүлэгч байгууллага болж буй нь үүгээр илэрч байна.



Голомт банк “АЖИЛЛАХАД ТААТАЙ ГАЗАР”-аар дөрвөн жил дараалан батламжлагдлаа

Ази тив

90%


Монгол Улс

82%

Голомт банк

91%

Соёлын индекс



Соёлын кодекс

Бид 2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн 00/35 тогтоолоор Голомт банкны “Соёлын кодекс” баримт бичгийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Голомт банкны “Соёлын кодекс” баримт бичиг нь 18 заалтаас бүрддэг бөгөөд “Соёлын кодекс” баримт бичгийг ажилтнууддаа нэвтрүүлэх ажлын хүрээнд ажилтнуудын заавал хамрагдах сургалтын жагсаалтад багтаах, “Managers’ meeting” арга

хэмжээний үеэр нийт удирдах ажилтанд баримт бичгийг таниулах, нэгжийн удирдлага бүр өөрийн нэгжийн ажилтнуудад “Соёлын кодекс” баримт бичгийг таниулах сургалт зохион байгуулах, дотоод ажилтнууддаа зориулан тогтмол мэдээ, мэдээлэл, постер хүргэх, жилд нэг удаа мэдлэг бататгах шалгалт нийт ажилтнаас авах, хяналтын нэгжүүдээс холбогдох үйл ажиллагааны хүрээнд хяналт шалгалтууд тогтмол хийх, үр дүнг

хэмжих, ажилтнуудын оролцоог хангах үүднээс тест, судалгаа, багийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.


Баримт бичгийн хэрэгжилтийг ТУЗ-ийн хурлаар хагас жил тутам тайлагнадаг бөгөөд ТУЗ-ийн чиглэлийн дагуу тус хүрээнд ёс зүйн төлөвлөгөөг боловсруулж, үйл ажиллагаандаа тогтмол мөрдөх, хэрэгжүүлэх, таниулах үйл явцыг хянан ажиллаж байна.

Дотоод аудит

Голомт банкны Дотоод аудитын үйл ажиллагаа нь Олон улсын Дотоод аудиторчуудын институт (The Institute of Internal Auditors)-ийн гаргасан Дотоод аудитын мэргэжлийн туршлагын олон улсын хүрээ (International Professional Practices Framework)-нд нийцсэн бөгөөд үндсэн зорилго нь эрсдэлд суурилсан, хараат бус, бодит баталгаажуулалт хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар Банк, түүний нэгж, үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэн нэмэх, стратеги зорилгодоо хүрэхэд нь туслахад чиглэдэг.

Бүтэц, тайлагнал

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаагаар дамжуулан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлдэг. Банкны нэгжүүд нь эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцоогоо бүрдүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах үүрэгтэй байдаг бол Аудитын хороо нь банкны дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд анхаарч, хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэгтэй. ТУЗ-ийн Аудитын хороо нь тус чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор банкны Гүйцэтгэх удирдлагын багаас хараат бус бүтэцтэй Дотоод аудитын үйл ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудит хариуцсан захирлыг томилох, Дотоод аудитын үйл ажиллагааны дүрэм, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, стратеги болон жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөө, зардлын төсвийг баталдаг. Дотоод аудитын үйл ажиллагаа нь Аудит хариуцсан захирлын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Дотоод аудитын газар, Дата анализын алба гэсэн бүтцийн нэгжүүдтэй бөгөөд 35 ажилтны батлагдсан орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Дотоод аудитын газар нь Ерөнхий аудитын хэлтэс, Мэдээллийн технологийн аудитын хэлтэс, Зайны аудит, чанарын баталгаажуулалтын хэлтсээр дамжуулан чиг үүргээ хэрэгжүүлдэг.



Аудитын хамрах хүрээ, аргачлал

Банк нь стратеги зорилтууддаа хүрэх, тодорхойлсон эрсдэлийн аппетитын хүрээнд үйл ажиллагаагаа явуулахад банкны засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо хангалттай, үр дүнтэй байгаа эсэхийг Дотоод аудитын газар үнэлж, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж хүргүүлэх замаар банкны үйл ажиллагаанд үнэ цэн нэмж байна. Зөвлөх үйлчилгээг банкны менежментийн багийн хүсэлтээр хийдэг бөгөөд засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор, удирдлагын болон гүйцэтгэх чиг үүрэг хүлээлгүйгээр банкны нэгж, үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Дотоод аудитын үйл ажиллагаа 2025 онд

- Олон улсын сайн туршлагын дагуу Дотоод аудитын газар нь Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад нийцсэн Чанарын баталгаажуулалт, сайжруулах хөтөлбөртэй. Олон улсын дотоод аудиторчуудын институт нь 2025 оны 1-р сарын 9-өөс эхлэн Дотоод аудитын шинэ стандартыг мөрдөх шаардлага тавьж буй бөгөөд энэ шаардлагад нийцүүлж, Голомт банкны Дотоод аудитын газар нь дүрэм, журмаа шинэчлэн боловсруулж, 2024 оны 12-р сард ТУЗ-өөр батлуулсан. 2025 оноос эхлэн шинэ стандартыг мөрдөн ажиллаж байна.

- Банкны стратеги, бизнес төлөвлөгөөтэй уялдуулан улирал бүр хийгддэг банкны нэгж, үйл ажиллагаа, салбар, тооцооны төвийн эрсдэлийг үнэлэх аргачлал, үзүүлэлтийг шинэчилж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Ингэснээр эрсдэлд суурилсан аудитын аргачлал илүү сайжирч, үнэлэх процесст роботик процесс автоматжуулалт нэвтрүүлснээр нийт ажиллагааны 50% нь хүний оролцоогүйгээр хийгдэж байна.

- Банкны бизнесийн нэгжүүдийн үйл ажиллагаанд, тодорхойлсон үзүүлэлтийн хүрээнд on-time

баталгаажуулалт хийх боломжтой Real-time аудитыг Роботик процесс автоматжуулалт ашиглан нэвтрүүлсэн. Ингэснээр хүний оролцоогүй баталгаажуулалт хийх процесс хийгдэж байна.

- Голомт банк НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн “Хариуцлагатай банкны зарчим”-ын хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаагаа өмнө нь хөндлөнгийн аудитын компаниар баталгаажуулалт хийлгэдэг байсан бол 2025 онд анх удаа Голомт банкны Дотоод аудитын газар нь энэхүү

баталгаажуулалтыг өөрсдийн хүчин чадалд тулгуурлан амжилттай хийлээ.

- Дотоод аудиторуд мэргэжлийн ур чадвараа дараагийн түвшинд гаргаж, Олон улсын нэр хүнд бүхий CISM /Certified Information Security Manager/ мэргэшлийн сертификатыг 1 аудитор, CEH Master /Certified Ethical Hacker Master/ сертификатыг 1 аудитор, ISO27001 Lead auditor сертификатыг 1 аудитор авч, олон улсын цол зэрэгтэй, мэргэшсэн аудиторудын тоо жил ирэх бүр өссөөр байна.

Эрсдэлийн удирдлага

Голомт банкны эрсдэлийн удирдлагын зарчим нь тогтвортой өсөлтийг дэмжихийн зэрэгцээ харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон санхүүгийн тогтолцоог бүхэлд нь хамгаалахад чиглэдэг. Банк нь макро эдийн засгийн мөчлөг, харилцагчдын хэрэгцээний өөрчлөлт, хурдацтай дижиталжилт, зохицуулалтын орчны өөрчлөлт зэрэг хүчин зүйлсээр тодорхойлогдох орчинд үйл ажиллагаа явуулдаг.

Банк нь эрсдэлийн засаглал, эрсдэлийн аппетитийн мэдэгдэл, мөн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, мониторинг хийх, тайлагнах зэрэг процессийг хамарсан Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд эрсдэлийг удирддаг. Энэхүү тогтолцоо нь Банкны бүхий л түвшинд эрсдэлийн талаар нэгдсэн ойлголттой байх, эрсдэлийг эзэмших, тогтоосон хязгаарын хүрээнд эрсдэлийг удирдах, мөн хэвийн болон стрессийн нөхцөлд Банкны өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг хангах зорилготой.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Зээлийн эрсдэл нь банкны хамгийн том санхүүгийн эрсдэлийн нэг бөгөөд иргэн, хуулийн этгээд зэрэг бүхий л төрлийн харилцагчдад олгосон аль ч зээлээс үүсэх боломжтой байдаг. Зээлийн эрсдэлийг бий болгодог гол хүчин зүйлсэд зээлдэгчийн орлого, мөнгөн урсгал муудах, өрийн дарамт өсөх, менежментийн алдаа зэрэг зээлдэгчийн түвшний нөлөөллүүд, болон макро эдийн засгийн удаашрал, хууль эрх зүй, валютын ханш ба хүүгийн хэлбэлзэл, салбарын улирлын нөлөө зэрэг гадаад орчны хүчин

зүйлс багтана. Зээлийн дефолтын эрсдэл тохиолдсон үед барьцаа хөрөнгийн үнэ цэнэ, хөрвөх чадвар, баримт бичиг ба эрхзүйн хүчин төгөлдөр байдал, өр цуглуулах болон барьцаа хөрөнгийг борлуулах хугацаа, зардал зэрэг нь ашиг алдагдлын хэмжээнд шууд нөлөөлөх тул зээлийн багцыг төрөлжилт, эрсдэлийн аппетитын мэдэгдлийн дагуу, тогтмол хяналтаар идэвхтэй удирддаг.

Голомт банкны зээлийн эрсдэлийн удирдлагын зорилго нь зээлдэгч нь зээлийн гэрээний үүргээ

биелүүлэхгүй байх эсвэл биелүүлэх чадамжгүй болох эрсдэл, үүнээс үүдэн гарч болох алдагдлыг зээлийн амьдралын мөчлөгийн бүхий л үе шатанд хараат бус байдлаар хянах, таамаглах, тодорхойлох замаар хөндлөнгийн хяналт тавьж үр дүнд нь зээлийн бодлогод зээлийн эрсдэлээс сэргийлэх, бууруулах нэмэлт өөрчлөлт оруулах болон зээлийн эрсдэлийн аппетитийн мэдэгдлийг боловсруулах замаар банкны зээлийн багцын тогтвортой байдлыг хангаж, ашигт ажиллагааг боломжит хамгийн өндөр түвшинд хадгалах явдал юм.

Зээлийн бодлого ба хэрэгжүүлэх үндсэн зарчим

Зээлийн үйл ажиллагаа нь Голомт банкны ТУЗ-өөс баталсан Зээлийн бодлого болон Банкны Эрсдэлийн аппетитын тогтолцооны хүрээнд хэрэгжинэ. Уг бодлого нь Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанкны шаардлага, зохицуулалтын шалгуур үзүүлэлтүүд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS), олон улсын холбогдох конвенциуд, мөн Банкны БОНЗ ба тогтвортой санхүүжилтийн зарчимтай нийцсэн байдаг.

Эрсдэлийн удирдлагын арга зүй

Банк нь сегмент тус бүрд тохирсон эрсдэлд суурилсан судалгаа, шийдвэрлэлтийг хэрэгжүүлдэг.

- Иргэнд олгох зээл: Иргэдийн хэрэглээний болон бизнес зээлийн хувьд зээлжих зэрэглэл, зан төлөв болон статистик мэдээлэлд суурилахын зэрэгцээ өр, орлогын харьцаа, бусад зээлийн мэдээлэл, зээлийн бүтээгдэхүүнтэй холбогдох дүрэм журмыг баримтална.

- Хуулийн этгээдэд олгох зээл: Санхүүгийн болон чанарын үнэлгээ, мөнгөн урсгалын шинжилгээ, салбарын нөхцөл байдал, эдийн засгийн орчны үнэлгээ

Мөн мэдээллийн нууцлал, мэдээллийн аюулгүй байдал, хамаарал бүхий этгээдтэй хийх хэлцлийн үед давуу эрх олгоггүйгээр энгийн иргэн, хуулийн этгээдийн адилаар хэлцлийг хийх зарчмууд, хориглох үйл ажиллагаа, зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл, сонирхлын зөрчлийн зохицуулалт зэрэг зарчим, хяналтуудыг хэрэгжүүлдэг.

зэрэг нарийвчилсан судалгаанд үндэслэн шийдвэр гаргана. Шаардлагатай тохиолдолд төвлөрлийн эрсдэлийг удирдах зорилгоор багцын төрөлжилт, хязгаарлалтын хяналтуудын дагуу шийдвэрлэнэ.

Голомт банк нь зээлийн шийдвэр гаргалтдаа байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг боловсруулж, эрсдэлийг удирдах боломжтой гэж дүгнэсэн нөхцөлд санхүүжүүлдэг. Банк байгаль орчинд ээлгүй зээлийн төсөлд асуудлыг шийдвэрлэх шаардлагыг нэн тэргүүнд тавих эсвэл зээл олгохоос татгалзах эрхтэй байдаг.

Зээлийн хяналт, анхаарал хандуулах жагсаалт, эрт илрүүлэлт

Голомт банк нь зээл олгогдсон үеэс хойш төлөлт бүрэн хийгдэх хүртэл тухайн зээл зориулалтын дагуу ашиглагдаж буй эсэх, төлөлтийн сахилга бат, зээлдэгчийн зээлжих чадварыг тогтмол хянаж, зээлийн эрсдэлийн шинж тэмдэг илэрвэл холбогдох салбар нэгжүүдийн хамтаар арга хэмжээ авч ажилладаг. Илүү өндөр хяналт шаардлагатай зээлүүдийг Анхаарал хандуулах жагсаалт/ Watchlist-д оруулж, өндөр давтамжтай хяналт болон хугацаанаас өмнө анхааруулах, засварлах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тодруулбал, хэрэглээний зээлийн багцын хувьд нийт зээлийн багцад эзлэх хувь харьцангуй өндөр, олон тооны харилцагчид байх тул урьдчилан


сэргийлэх хяналтыг сайжруулах хүрээнд бүтэцтэй, тогтмол чанарын дүн шинжилгээг холбогдох засаглалын түвшинд танилцуулан хэрэгжүүлж, дижитал/уламжлалт суваг, бүтээгдэхүүн, харилцагчдын бүтэц ангилал, салбар, бүс нутаг, олголтын чиг хандлага, насжилтын динамик, чанаргүйдлийн түгээмэл шалтгаан, залруулах арга хэмжээ, өр цуглуулалтын үр нөлөө зэрэг үндсэн хэмжээснүүд дээр хяналт тавин ажилладаг. Хяналтын үр дүнд судалгааны стандарт, хяналтын давтамж, нөхөн төлүүлэх процессын дараалал зэрэгт шаардлагатай тохируулгыг цаг тухайд нь хийдэг.

Зээлийн хяналт, анхаарал хандуулах жагсаалт, эрт илрүүлэлт

Голомт банк нь зээлийн багцын өсөлтийн зэрэгцээ сегментийн төрөлжилт болон тэнцвэрийг хадгалан ажиллаж байна.

- 2023 оны эцэст: нийт зээлийн багц 4.9 их наяд төгрөг
- 2024 оны эцэст: нийт зээлийн багц 7.5 их наяд төгрөг (өсөлт 54%)
- 2025 оны эцэст: нийт зээлийн багц 8.3 их наяд төгрөг (өсөлт 11%)

Нийт зээлийн багц ба чанаргүй зээлийн хувь




Зээлийн багцын чанарт онцгой анхаарал хандуулан ажилласны үр дүнд багцын чанар тогтмол сайжирсаар байна.

- Чанаргүй зээлийн хувь: 2.5%
- Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээний хувь (Coverage ratio): 102%

Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүдэд анхаарал хандуулахын зэрэгцээ багцын бүтэц, бүрэлдэхүүний тэнцвэрт байдлыг гадаад болон дотоод орчны хяналт судалгаанд үндэслэн тогтвортой хадгалсаар байна.

Зээлийн багцын сегментийн бүтэц



2025 оны эцэст сегментийн бүтэц:

- Корпорэйт: 2.6 их наяд төгрөг (31.3%)
- ЖДБ: 2.2 их наяд төгрөг (26.3%)
- Хэрэглээ: 2.0 их наяд төгрөг (23.8%)
- Орон сууц: 1.5 их наяд төгрөг (18.6%)

Банк нь зээлийн багцын төвлөрлийн эрсдэлийг удирдах хүрээнд эдийн засгийн сектор, холбоо хамаарал бүхий зээлдэгчид, бүтээгдэхүүн, сегмент болон гол төвлөрлийн үзүүлэлтүүдийг тогтмол хянаж, эрсдэлийн аппетитын лимитэд ойртсон тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Зээлийн үйл ажиллагааны дижитал шилжилт

Зээлийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд хяналтын тогтвортой байдал, хэмжих үзүүлэлтүүд, гүйцэтгэл, үр ашиг, бүтээмжийг сайжруулах зорилгоор Голомт банк нь 2025 онд нэгдсэн Зээлийн үйл ажиллагааны системийн сайжруулалт (Improvement on Loan Operations – ILO) төслийг хэрэгжүүлсэн. Энэ нь 2019 онд иргэдийн зээлийн RLOS, 2023 онд K2 системийг нэвтрүүлсэн хөгжлийн дараагийн шат бөгөөд зээлийн судалгаа/шийдвэр гаргалт, мониторинг, өр цуглуулалт зэрэг үйл ажиллагааг нэгтгэсэн системийн орчинд

төвлөрүүлснээр гар ажиллагааг бууруулж, уялдаа холбоо болон хяналтыг сайжруулсан.

Нэвтрүүлсэн ILO системийн модулиуд:

1. ILO – Зээлийн судалгаа / шийдвэрлэлт (Loan Origination / Assessment)
2. ILO – Мониторинг (Monitoring)
3. ILO – Өр цуглуулах (Debt Collection)

Процессын автоматжилт ба давуу тал

- Хүсэлтээс олголт хүртэл: 11 үндсэн процесс, ~700 дэд процесс нь нэг системээр төгсгөлийн шат хүртэл шийдвэрлэгдэх болж, өмнө нь хэсэгчлэн системжсэн, ихээхэн гар бүртгэлтэй, бүхэл процесс хэмжих боломж хязгаарлагдмал байсныг сайжруулсан.
- Мониторинг: Системийн хамрах хүрээ мэдэгдэхүйц өсөж, урьд өмнө боломжгүй байсан төгсгөлийн шатны процессын хэмжилт бодитоор хэрэгжих нөхцөл бүрдэв.
- Өр цуглуулалт: Голчлон гар ажиллагаатай байсан орчин системд шилжиж, гүйцэтгэл хэмжих, удирдах боломжтой болсон.

Хурд, гүйцэтгэл, хүчин чадлын сайжруулалт

- Зээлийн нийт процессын хурд 47.8%-аар сайжирсан.
- Мониторингийн цикл (дата бэлтгэхээс баталгаажуулах хүртэл) 92%-аар сайжирсан.
- Өр цуглуулах ажиллагааны хүчин чадал 11.5%-аар нэмэгдэж, өдөрт ажиллагаа явуулах боломжтой зээлийн тоог нэмэгдүүлсэн.

Өгөгдлийн суурь ба стандартжилт

- Нэгдсэн дижитал системд 1,000 гаруй талбарын өгөгдөл нэг стандартаар бүртгэгдэж, процессын ачаалал буурч, зээлийн хүсэлтийг бодит цагийн горимоор хянах боломж нэмэгдэв.
- Мониторинг болон өр цуглуулалтын ажлын жагсаалт автоматаар бэлтгэгддэг болсноор өгөгдлийн орхигдол, зөрүү гарах эрсдэл буурсан.
- Скоринг, рейтингийн загваруудын тооцоолол, бүртгэл төвлөрч, нэг стандарттай болсон.
- Зээлийн гэрээ, холбогдох баримт бичгийг системээр бэлтгэх боломж өргөжиж, зээл олголт болон өр цуглуулалтын ажиллагааны хяналт, стандартчиллыг сайжруулсан.

Цаашид Голомт банк нь ILO-ийн өгөгдлийн суурь дээр тулгуурлан бодит цагийн мониторинг, эрт илрүүлэлтийн аргачлал, процессын гүйцэтгэлийн хэмжилт, зээлийн чанарын аналитикийг сайжруулж, өгөгдөлд суурилсан тогтвортой зээлийн эрсдэлийн удирдлагыг хөгжүүлэн ажиллах суурь тавигдлаа.

“СТОУС-9”-ийн дагуу тайлагнал

Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Зөвлөл (ОУНББЗ)–өөс батлан гаргасан “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 9” (IFRS-9) стандартыг Банк 2018 онд нэвтрүүлсэн бол 2024 онд тус стандартын дагуух зээлийн тооцооллыг олон улсын PWC хөндлөнгийн аудитын фирмийн зөвлөх үйлчилгээний дагуу автоматжуулж, зохицуулагч байгууллагад сар бүр амжилттай тайлагнан ажиллаж байна.

Банк нь зээлийн үнэ цэнийн бууралтаас үүсэх эрсдэлийн санг СТОУС-9 “Санхүүгийн хэрэгсэл” стандартын дагуу тооцож, хүлээн зөвшөөрдөг. СТОУС-9-ийн хамрах хүрээ нь зээлийн эрсдэлийг урьдчилан тооцсон, ирээдүйг харгалзсан (forward-looking) байдлаар таамаглан тооцоолж, зээлийн амьдралын мөчлөгийн туршид хүлээгдэж болзошгүй эрсдэлийг цаг тухайд нь тусган тайлагнах боломжийг бүрдүүлдэг.

Хамрах хүрээ ба тооцооллын аргачлал

СТОУС-9 стандартын дагуу хүлээгдэж буй зээлийн алдагдал буюу ECL-ийн тооцооллын аргачлал нь (шаардлагатай тохиолдолд) өртгөөр хэмжигдэх болон бусад дэлгэрэнгүй ангилалд хамрах санхүүгийн хөрөнгө, мөн балансын гадуурх эрсдэлтэй үүргүүд (зээлийн амлалт, санхүүгийн баталгаа гэх мэт)-д хамаарна. Хүлээгдэж болзошгүй алдагдлыг дараах үндсэн эрсдэлийн үзүүлэлтүүдэд тулгуурлан тооцдог. Үүнд:

- Зээлдэгч дефолт болох магадлал (PD)
- Дефолтын үеийн алдагдлын хувь (LGD)
- Дефолтод өртөлт/өр төлбөрийн хэмжээ (EAD)

Тус тооцоололд макро эдийн засгийн нөхцөл байдал зэрэг ирээдүйг харгалзсан мэдээлэл тусгагдана.

Үе шатлал (staging) ба Зээлийн Эрсдэлийн Мэдэгдэхүйц Өсөлт (SICR)

Үнэ цэнийн бууралтын үнэлгээнд зээлүүдийг СТОУС-9-ийн үе шатлалаар ангилна:

- 1-р үе шат: Олгогдсоноос хойш эрсдэл мэдэгдэхүйц өсөөгүй зээл; 12 сарын ECL-ээр хэмжинэ.
- 2-р үе шат: Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн зээл; нийт насжилтын хугацааны (lifetime) ECL-ээр хэмжинэ.
- 3-р үе шат: Чанаргүй/үнэ цэн алдагдсан (credit-impaired) зээл; lifetime ECL тооцож, хүүгийн орлого таних нь СТОУС-9-ийн шаардлагад нийцнэ.

Ирээдүйг харгалзсан мэдээлэл ба хувилбарын шинжилгээ

Голомт банк нь эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт зээлдэгчийн төлбөрийн чадварт хэрхэн нөлөөлхийг цаг тухайд нь тайлагнахын тулд ECL тооцоололд макро эдийн засгийн таамаглал болон хувилбарт суурилсан

(scenario-based) шинжилгээ ашиглаж, ирээдүйг харгалзсан үнэлгээг сайжруулж ажилладаг.

Засаглал, хяналт ба тайлагналын сахилга бат

СТОУС-9 ECL-ийн хүрээнд Банк нь тогтвортой, ил тод, хянагдахуйц процессыг хангах зорилгоор дараах засаглал, хяналтуудыг хэрэгжүүлдэг:

- Бизнес, эрсдэл, санхүүгийн нэгжүүдийн үүрэг хариуцлагын тодорхой хуваарилалт;
- Өгөгдөл бэлтгэл, параметрийн шинэчлэл, модель ажиллуулах, үр дүнг хянах хяналтын журамтай процесс;
- Холбогдох хороодын түвшинд удирдлагын хяналт, хэлэлцүүлэг;
- Аргачлал, таамаглал, оролтын өөрчлөлтийн баримтжуулалт ба өөрчлөлтийн удирдлага.

Зээлийн эрсдэл бууруулалт ба барьцаа хөрөнгийн удирдлага

Барьцаа хөрөнгө болон бусад эрсдэл бууруулагч хэрэгслүүд нь Голомт банкны зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны чухал хэсэг юм. Банкны хувьд анхдагч эргэн төлөлтийн эх үүсвэр нь зээлдэгчийн үйл ажиллагааны мөнгөн урсгал, төлбөрийн чадвар бөгөөд барьцаа нь хоёрдогч нөхөн авах эх үүсвэр болж ашиглагдана.

Бодлого ба барьцааны зохистой байдлын шалгуур

Банк нь зээл, зээлтэй адилтгах хөрөнгө болон балансын гадуурх үүргүүдтэй холбоотой үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор шаардлагатай тохиолдолд зээлдэгч болон гуравдагч этгээдээс барьцаа хөрөнгө авдаг. Барьцааны зохистой байдлыг дараах хүчин зүйлсийг харгалзан үнэлнэ. Үүнд:

- Барьцааны эрхийг хууль ёсоор баталгаажуулах, хэрэгжүүлэх боломж (enforceability);
- Хөрвөх чадвар, зах зээлд борлуулах боломж;
- Үнэлгээний найдвартай байдал, үнийн хэлбэлзлийн онцлог;
- Хяналт, хадгалалт, худалдах үйл ажиллагааны хэрэгжих боломж.

Шаардлагатай тохиолдолд Банк нь баталгаа, батлан даалт зэрэг эрсдэлийг бууруулагч хэрэгслүүдийг мөн хүлээн зөвшөөрөх бөгөөд үүнд батлан даагчийн төлбөрийн чадвар, үүрэг гүйцэтгэх чадавхыг үнэлэх шалгуур хэрэгжинэ.

Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тогтолцоо

Үл хөдлөх хөрөнгө нь барьцаанд авсан хөрөнгийн дийлэнх хэсгийг эзэлдэг. Үл хөдлөх хөрөнгийн төрөл, шинж чанараас хамааран Банк нь дараах ангиллаар

2024 оноос эхлэн Голомт банк нь ECL тооцооллыг автоматжуулж, зохицуулагч байгууллагад сар бүр тайлан хүргүүлэн ажиллаж байна. Автоматжуулалт нь тогтмол хугацаанд тайлагнах чадварыг сайжруулж, гар ажиллагааны алдааг бууруулж, үр дүнг тулган шалгах (traceability) болон тайлан дахин боловсруулалт (reproducibility) зэргийг нэмэгдүүлдэг.

Нэгдсэн өгөгдөл ба мониторингийн сууринд тулгуурласан тасралтгүй сайжруулалт

Нэгдсэн ILO платформ нэвтэрснээр өгөгдөл бүртгэл стандартчилагдаж, (1,000 гаруй талбарын стандарт өгөгдөл) зээл багцын сегментчлэл, эрт илрүүлэлт, чанарын шинжилгээ зэрэг чадавхыг сайжруулах суурь бүрдсэн нь СТОУС-9 стандартын дагуу ECL-ийн засаглал, өгөгдөлд суурилсан эрсдэлийн удирдлагыг цаашид сайжруулахад дэмжлэг болж байна.

Барьцаа хөрөнгийн жишиг үнийг ашиглана:

- Орон сууц,
- Оффис талбай,
- Худалдаа, үйлчилгээний зориулалттай үл хөдлөх,
- Дулаан зогсоол,
- Амины орон сууц.

Жишиг үнэ нь хагас жил тутам шинэчлэгдэж, үнэлгээ нь Олон улсын үнэлгээний стандарт (IVS)-ын шаардлагад нийцэн хийгддэг. Мөн барьцаа хөрөнгийг зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах хангалттай нотлох баримт, хараат бус үнэлгээний материалтай байхаар бодлогоор зохицуулдаг.

Мониторинг ба дахин үнэлгээний сайжруулалт

Барьцаа хөрөнгийн үнэлгээ, хяналтыг хурдтай, ил тод, нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор Банк нь:

- Барьцаатай холбоотой өгөгдлийн чанарыг сайжруулж,
- Системийн бүртгэлийн талбаруудыг стандартчилж,
- Өдөр тутмын ажиллагаанд ашиглах барьцааны үнэлгээний мониторингийн дашбоард хөгжүүлж нэвтрүүлсэн.

Эдгээр сайжруулалт нь стандарчлал, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, барьцаатай холбоотой зөрчил/онцгой тохиолдлыг эрт илрүүлэх боломжийг нэмэгдүүлдэг. Мөн барьцаа хөрөнгө нь зээлийн хугацаанд тогтмол дахин үнэлэгдэж, үнэ цэнийн өөрчлөлтийг Банкны барьцаа үнэлгээний журмын дагуу хянаж ажиллана.

Өр цуглуулах болон барьцааг борлуулах

Зээлдэгч талд санхүүгийн хүндрэл үүссэн тохиолдолд Банк нь барьцаа хөрөнгийг нөхөн төлбөрт авах, борлуулахтай холбоотой баримт бичиг, хууль эрх зүйн уялдааг хангах тодорхой процессуудыг хэрэгжүүлдэг. Хууль тогтоомж болон дотоод журмын хүрээнд шаардлагатай үед барьцааг хураан авах, борлуулах замаар өр төлбөрийг нөхөн барагдуулах ажиллагааг зохих засаглал, хяналтын хүрээнд гүйцэтгэнэ.

Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Зах зээлийн эрсдэл гэдэг нь хүүгийн түвшин, валютын ханш, үнэт цаасны үнэ болон бусад зах зээлийн хувьсагчдын өөрчлөлтөөс шалтгаалан банкны ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгөд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг хэлнэ.

Зах зээлийн эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд банк нь стандартад суурилсан журам, аргачлал, зааварчилгааг боловсруулан мөрдөж, зах зээлийн эрсдэлийг дараах үе шаттайгаар удирдан ажилладаг. Үүнд:

- Эрсдэлийг таних, тодорхойлох;
- Эрсдэлийг хэмжих, үнэлэх;
- Эрсдэлийн лимит тогтоох, хэрэгжилтийг хянах;
- Өдөр тутмын мониторинг хийх;
- Удирдлагын болон зохицуулагч байгууллагад тайлагнах.

Банк нь зах зээлийн эрсдэлийг арилжааны багц болон арилжааны бус багцад ангилан удирддаг бөгөөд багц тус бүрд тохирсон хэмжилтийн аргачлал, лимит, хяналтын тогтолцоог хэрэгжүүлдэг.

Арга зүй

Арилжааны багцын эрсдэлийн хэмжилт

Банк нь зах зээлийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй алдагдлыг тооцоолох зорилгоор VaR (Value-at-Risk) статистик хэмжүүрийг ашигладаг. VaR тооцооллыг сүүлийн 12 сарын түүхэн өгөгдөлд тулгуурласан симуляцийн аргачлалаар гүйцэтгэж, тогтоосон дотоод лимитийн хүрээнд эрсдэлийг удирдан ажиллаж байна.

VaR нь зах зээлийн эрсдэлийг хэмжихэд өргөн хэрэглэгддэг стандарт үзүүлэлт боловч өнгөрсөн хугацааны зах зээлийн хөдөлгөөн ирээдүйн нөхцөлийг бүрэн илэрхийлэхгүй байх, онцгой хямралын нөхцөлийг хангалттай тусгахгүй байх сул талтай. Иймд банк нь VaR-аас гадна хүндрэлтэй нөхцөлийн стресс тестийг хийж гүйцэтгэх байдлаар эрсдэлийн цогц үнэлгээг хийдэг.

Стресс тестийн хүрээнд зах зээлийн огцом уналт,

Системчлэлээр дамжуулан эрсдэлийн удирдлагын үр нөлөөг нэмэгдүүлэх

Нэгдсэн зээлийн үйл ажиллагааны платформ нь өгөгдлийн бүрэн бүтэн байдал, гар ажиллагааны алдаа, засварыг бууруулж, мониторингийн үйл ажиллагааны урсгалыг илүү тогтвортой болгосноор барьцаа болон бусад эрсдэл бууруулагч хэрэгслийн бүртгэл, хяналт, онцгой тохиолдлын удирдлагыг сайжруулж, мониторингийн үр дүнг залруулах арга хэмжээтэй үр нөлөөтэй уялдуулах боломжийг нэмэгдүүлсэн.

валютын ханшийн савлагаа зэрэг таагүй нөхцөл байдлын түүхэн болон таамаглалт сценариудыг ашиглан арилжааны багцад үзүүлэх нөлөөллийг үнэлдэг.

Арилжааны бус багцын хүүгийн эрсдэл (IRRBB)

Банк нь арилжааны бус багцын хүүгийн эрсдэлийг Interest Rate Risk in the Banking Book (IRRBB) аргачлалаар тогтмол хэмжиж, хянаж ажилладаг.

IRRBB тооцооллын хүрээнд доорх нөлөөллийг тус тус тооцон үнэлдэг:

- Богино хугацаанд цэвэр хүүгийн орлогод үзүүлэх нөлөөллийг (ΔNII);
- Урт хугацаанд өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнд үзүүлэх нөлөөллийг (ΔEVE);

Харилцах болон хугацаагүй хадгаламжийн мөнгөн урсгалын тооцоололд зан төлөвийн загварчлал (behavioral model)-ыг ашиглан илүү бодитой таамаглал боловсруулдаг.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ ба стресс тест

Тайлант хугацаанд банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний хувьд Монголбанкнаас тогтоосон норматив шаардлагыг бүрэн хангаж, банкны эрсдэлийн аппетитийн мэдэгдэлтэй нийцүүлэн ажилласан.

Мөн Basel Committee on Banking Supervision-ийн Базел III стандартын хүрээнд Өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй байдлын дотоод үнэлгээ (ICAAP)-г хэрэгжүүлж, учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон стресс тестийг тогтмол гүйцэтгэж байна.

Банк доорх төрлийн стресс тестүүдийг хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- Банкны дотоод аргачлалаар гүйцэтгэдэг тогтмол стресс тест;
- Банкийг тогтворжуулах төлөвлөгөөний хүрээний стресс тест;
- ICAAP-ийн хүрээнд хийгдэх капиталын хангалттай байдлын үнэлгээ;

Систем, хяналт, тайлагнал

Банкны өгөгдөл, тайлагналын системүүд нь зах зээлийн эрсдэлийн хяналтыг үр ашигтай хэрэгжүүлэх суурь нөхцөл болдог. Иймд банк нь мэдээллийн чанар, бүрэн бүтэн байдал, системийн найдвартай ажиллагаанд тогтмол үнэлгээ хийж, шаардлагатай сайжруулалтыг хэрэгжүүлдэг.

2025 онд банк нь арилжааны үндсэн системийн шинэчилсэн хувилбарыг нэвтрүүлж, эрсдэлийн хяналтын автоматжуулсан функцуудыг хөгжүүлснээр зах зээлийн эрсдэлийн хэмжилт, мониторингийн үр ашиг, шуурхай байдлыг нэмэгдүүлсэн.

Зах зээлийн эрсдэлийн удирдлагын нэгж нь Эрсдэл хариуцсан захирал (CRO)-д шууд харьяалагддаг, хараат бус бүтэцтэй бөгөөд доорх чиг үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна:

- Зах зээлийн эрсдэлийг өдөр тутам хянах;

- Лимитийн хэрэгжилтийг хянах;

- Эрсдэлийн дүн шинжилгээ хийх;

- Эрсдэлийн удирдлагын хороонд болон удирдлагын түвшинд тогтмол тайлагнах;

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь бэлэн мөнгө эсвэл бусад хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөөр санхүүгийн өр төлбөрийг гүйцэтгэхэд хүндрэл үүсэх эрсдэл юм.

Банкны Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хөрвөх чадварын эрсдэлийг удирдах ерөнхий зарчим, хандлага, зохион байгуулалтын тогтолцоог тодорхойлсон суурь баримт бичиг болно. Уг тогтолцоо нь эрсдэлийн бодлого стратеги, эрсдэлийн түвшин, холбогдох хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын шаардлагад нийцүүлэн батлагддаг.

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд банк нь дараах зарчмыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Актив, пассивын хугацааны зохистой бүтцийг хангах;

- Ирээдүйд үүсэж болзошгүй мөнгөн урсгалын зөрчлийг нөхөх хэмжээний өндөр хөрвөх чадвартай активын зохистой түвшинг хадгалах;

- Санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, төвлөрлийг бууруулах;

- Хүндрэлийн үеийн төлөвлөгөө (Contingency Funding Plan)-г боловсруулж, хэрэгжүүлэх;

- Банкийг тогтворжуулах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

Арга зүй

Банк нь хөрвөх чадварын эрсдэлийг хэмжих, хянах зорилгоор зохицуулагч байгууллагаас тогтоосон болон

2025 оны зах зээлийн эрсдэлийн үнэлгээ

Тайлант 2025 оны турш банкны зах зээлийн эрсдэлийн түлхүүр үзүүлэлтүүд Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шаардлага болон банкны эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд заасан түвшинг тогтвортой хангаж, зохих түвшинд хадгалагдсан.

Тайлант хугацаанд Монгол Улсын макро эдийн засгийн орчин харьцангуй тогтворжиж улсын зээлжих зэрэглэл өссөн боловч геополитикийн эрсдэлүүд нэмэгдэж тодорхой бус байдал үргэлжилсэн хэвээр байна. Улмаар санхүүгийн зах зээлд хувьцаа, валют, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, зэрэг эрсдэлүүд тулгарсан ч банк зах зээлийн эрсдэлийн удирдлагын оновчтой бодлого хэрэгжүүлснээр болзошгүй алдагдлаас хамгаалж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам бэхжүүлэн ажиллаж байна. Түүнчлэн АПХ-оос батлагдсан лимитийн хүрээнд валютын ханшийн эрсдэлээс учирч болзошгүй алдагдлыг “Value at Risk” аргачлалаар тооцож, өдөр бүр хяналт тавин ажиллалаа.

дотоод лимит бүхий дараах үндсэн үзүүлэлтүүдийг тогтмол тооцоолж, мониторинг хийдэг. Үүнд:

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа;

- Актив, пассивын эргэн төлөгдөх хугацааны зөрүүний шинжилгээ (GAP);

- Эх үүсвэрийн төвлөрлийн харьцаа;

- Хөрвөх чадварын хүрэлцээтэй байдлын харьцаа (LCR);

- Цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR).

Банк нь богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг хянах зорилгоор LCR, дунд болон урт хугацааны тогтвортой санхүүжилтийн эрсдэлийг үнэлэх зорилгоор NSFR үзүүлэлтийг тогтмол тооцож, зохицуулагчийн шаардлагыг бүрэн ханган ажиллаж байна.

Хөрвөх чадварын эрсдэлийн үнэлгээг цогц байдлаар хийх зорилгоор банк нь стресс тестийг тогтмол гүйцэтгэж, зах зээлийн огцом савлагаа, хадгаламжийн гадагшлах урсгал, санхүүжилтийн өртгийн өсөлт зэрэг таагүй сценариудад мөнгөн урсгал, хөрвөх чадварт үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолдог.

Мөн банк нь хүндрэлийн үеийн нөхцөлд хэрэгжүүлэх арга хэмжээний дарааллыг тодорхойлсон “Хөрвөх чадварын хүндрэлийн үед хэрэгжүүлэх төлөвлөгөө” болон “Банкийг тогтворжуулах төлөвлөгөө”-г батлан мөрдөж, тогтмол шинэчилж байна.

Түүнчлэн Basel Committee on Banking Supervision-ийн Базел III стандартын хүрээнд Хөрвөх чадварын хүрэлцээтэй байдлын дотоод үнэлгээ (ILAAP)-г хэрэгжүүлж, учирч болзошгүй хөрвөх чадварын эрсдэлийг тодорхойлон стресс тестийн үр дүнг шийдвэр гаргалтад ашиглаж байна.

Систем, хяналт, тайлагнал

Банкны мэдээллийн болон тайлагналын системүүд нь хөрвөх чадварын эрсдэлийн хяналтыг шуурхай, үр ашигтай хэрэгжүүлэх үндэс болдог. Иймд банк нь холбогдох системүүдийн хэвийн ажиллагаа, өгөгдлийн бүрэн бүтэн байдал, мэдээллийн чанарт тогтмол үнэлгээ хийж, шаардлагатай сайжруулалтыг хэрэгжүүлдэг.

Хөрвөх чадварын эрсдэлийн өдөр тутмын хяналтыг хариуцсан нэгж нь Эрсдэл хариуцсан захирал (CRO)-д шууд харьяалагдан ажиллаж, тогтоосон лимитийн хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, эрсдэлийн удирдлагын хороонд болон удирдлагын

Комплаенсийн бодлого

Комплаенсийн эрсдэл ба аппетит

Комплаенсийн эрсдэл нь холбогдох хууль, журам, дотоод бодлого болон ёс зүйн стандартыг мөрдөж биелүүлээгүйгээс үүдэн хууль эрх зүйн болон зохицуулагч байгууллагын санкц, санхүүгийн хохирол, эсвэл нэр хүндийн эрсдэл үүсэхийг хэлнэ. Монголын санхүүгийн салбарын томоохон банкны хувьд Голомт банк хууль, дүрэм, журмын аливаа санаатай зөрчлийг үл тэвчинэ. Голомт банк нь урьдчилан сэргийлэлт, дотоод сахилга бат, эрсдэлийг эрт илрүүлэх тогтолцоо болон түргэн шуурхай залруулах үйл ажиллагааг чухалчилдаг.

Засаглал

Комплаенсийн эрсдэлийн хяналтыг ТУЗ ийн Эрсдэлийн хороо хэрэгжүүлж, комплаенсийн эрсдэлийн аппетитыг батлах ба банкны стратегитай нийцэж буй эсэхийг хянана. Өдөр тутмын үйл ажиллагааг COMPLAENCIЙН нэгжийн захирал болон Эрсдэл хариуцсан захирал бие даасан байдлаар удирдан зохион байгуулж, бизнесийн нэгжүүдийг заавар, зөвлөгөөгөөр хангаж, хоёрдугаар шугамын хяналтыг хэрэгжүүлдэг. Нэгдүгээр шугам дахь нэгжүүд эрсдэлийн гол эзэмшигч бөгөөд Дотоод аудит гуравдугаар шугамын хувьд комплаенсийн засаглал, хяналтын үр дүнтэй байдлыг бие даан баталгаажуулдаг.

Эрсдэлийн удирдлага

Голомт банк нь харилцагчийн төрөл, газарзүйн байршил, бүтээгдэхүүн/үйлчилгээний төрөл болон тэдгээрийн түгээлтийн сувгийг хамарсан эрсдэлд суурилсан комплаенсийн тогтолцоо хэрэгжүүлдэг. Эрсдэлийн үнэлгээг жил бүр болон шаардлагатай тохиолдолд хийж, гол эрсдэлүүдийг тодорхойлох, хяналтын үр нөлөөг үнэлэх, эрсдэлийн зэрэглэлийг тодорхойлж холбогдох бодлого, журам, зохицуулалтын шинэчлэлийг

түвшинд тогтмол тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2025 оны хөрвөх чадварын эрсдэлийн үнэлгээ

Тайлант 2025 оны турш банкны хөрвөх чадвар нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шаардлага болон банкны эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд заасан түвшинг тогтвортой хангаж, зохих түвшинд хадгалагдсан.

Банк нь Базел III стандартын хүрээнд LCR болон NSFR үзүүлэлтүүдийг тогтмол тооцоолж, 2025 оны турш 100.0%-аас дээш хэмжээнд ханган ажилласан.

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг улам боловсронгуй болгох зорилгоор дотоод бодлого, журам, аргачлал, хүндрэлийн үеийн төлөвлөгөөг олон улсын стандартад нийцүүлэн сайжруулж, ILAAP-ийн хүрээнд хийгдсэн стресс тестийн үр дүнг стратеги болон санхүүжилтийн шийдвэр гаргалтад тусган ажилласан.

хийдэг. Бодлогуудын хэрэгжилт болон зохицуулалтын өөрчлөлттэй нийцсэн байдлыг тогтмол шинэчилдэг. Хуульд заасны дагуу харилцагчийн болон гүйлгээний мэдээллийг тухайн харилцагчаас харилцаагаа цуцалснаас хойш, эсвэл данс хаагдсанаас хойш тав болон түүнээс дээш жилийн хугацаанд хадгалдаг.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) ба хориг арга хэмжээний хэрэгжилт

Банк нь Монгол Улсын МУТСТ тухай хууль болон ФАТФ (FATF) ийн олон улсын стандартыг чанд мөрддөг. Банкны МУТСТ дотоод хяналтын хөтөлбөрт харилцагч таньж мэдэх шалгуур, харилцагч болон гүйлгээний скрининг, мониторинг, сэжигтэй гүйлгээний тайлагнал зэрэг багтана. Эрсдэл өндөртэй салбар, нутаг дэвсгэр болон харилцаанд нарийвчилсан хяналт болон удирдах түвшний зөвшөөрөл шаарддаг. Хориг арга хэмжээг дагаж мөрдөх ажиллагааны хүрээнд НҮБ, АНУ-ын Сангийн яамны дэргэдэх Гадаадын хөрөнгийн хяналтын алба (Office of Foreign Asset Control), Европын Холбооны Аюулгүй Зөвлөл, ИБУИНВУ-ын Her Majesty Treasury (НМТ) болон бусад шаардлагатай зохицуулалтын хоригийн хэрэгжилтийг хангаж ажилладаг.

Авлига, хээл хахуультай тэмцэх, луйврын эсрэг хяналт болон зөрчлийг мэдээлэх бодлого

Голомт банк нь ёс зүй, ил тод байдал болон хариуцлагатай үйл ажиллагааны соёлыг дэмжиж, сурталчлан таниулж ажилладаг. Ёс зүйн дүрэм нь авлигын эсрэг стандарт, ашиг сонирхлын зөрчил, шударга үйлчилгээ болон мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг тодорхойлдог. Эрсдэлтэй зан үйлийн хандлагыг илрүүлэх хяналтын болон тандалтын хэрэгслүүдийг ашигладаг.

Банк нь аливаа ёс зүйгүй үйлдлийг нуун дарагдуулахыг

үл тэвчих бөгөөд нууцлалтай, хараат бус удирдлагатай зөрчлийг мэдээлэх шугамуудыг ажиллуулж ажилтнууддаа хууль зөрчил, залилан, авлига, ашиг сонирхолтой шийдвэр, зохицуулагч байгууллагын шаардлагыг зөрчсөн зэрэг сэжигтэй үйлдлүүдийг нэрээ нууцлан аюулгүйгээр мэдээлэх боломжийг олгодог. Ирүүлсэн бүх мэдээллийг шуурхай, шударга, хараат бусаар шалгаж, тогтоосон журмын дагуу шийдвэрлэдэг. Мэдээлэгчийн нууцлал болон эрхийг чандлан хамгаалдаг.

Комплаенсийн болон ёс зүйн сургалт нь банкны нийт ажилтны хувьд заавал хамрагдах төрлийн сургалт бөгөөд эрсдэл өндөртэй ажлын байруудад гүнзгийрүүлсэн сургалтуудыг тусгайлан зохион байгуулдаг.

Дотоод хяналт

Банк нь эрсдэлийг цаг тухайд нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор скрининг, мониторинг, кейс менежментийн дэвшилтэт технологид тасралтгүй хөрөнгө оруулалт хийдэг. Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлагдсан эрсдэлийн аппетит болон Комплаенсийн бодлогын шаардлагыг зөрчсөн тохиолдолд банк тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлах, түдгэлзүүлэх, эсвэл татгалзах санал гаргаж болно.

Зохицуулагч байгууллагатай хамтран ажиллах

Голомт банк хууль сахиулах байгууллагуудтай идэвхтэй харилцаа холбоогоо хадгалж, харилцагч таньж мэдэх, цахим гуйвуулгын ил тод байдал, харилцагчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, мэдээлэл хадгалах зэрэг үйл ажиллагаандаа холбогдох шинэчлэл, өөрчлөлтийг хийж хуулийн шаардлагад нийцүүлэв. Зохицуулагч байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж ажиллав.

Банк нь салбартаа тэргүүлэгч санхүүгийн байгууллагын хувьд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эмзэг байдлын үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлын хэсгүүдэд идэвхтэй оролцож, практик туршлагаа хуваалцаж, илүү хүчирхэг, бат бөх үндэсний МУТСТ тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсаар ирсэн.

2025 оны товч үр дүн

- Арга хэмжээ: Голомт банк корреспондент харилцаатай АНУ-ын томоохон банк, санхүүгийн байгууллага болох BNY банктай хамтран Комплаенсийн воркшопыг амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд дотоодын зохицуулагч байгууллагууд, гадны банк, санхүүгийн байгууллагын төлөөлөгчид, Монголын банк, санхүүгийн салбарын Комплаенс болон мөнгө угаахтай тэмцэх ажилтнууд зэрэг 100 гаруй мэргэжилтэн оролцов.

- Бодлого, журмын зохицуулалт: Банк нь Комплаенсийн бодлого болон МУТСТ дотоод хяналтын хөтөлбөртөө 2026-2028 онуудад дагаж мөрдөх стандарт, шаардлагатай өөрчлөлтийг оруулан шинэчлэн боловсруулж, ТУЗ-өөр батлуулав.

- Сургалт: Комплаенс, ёс зүй, МУТСТ, хориг арга хэмжээний сургалтуудын ирц болон нийт ажилтны шалгалтын дундаж дүн өндөр үзүүлэлттэй гарав.

- Гүйлгээний хяналт, хоригийн хэрэгжилт: Олон улсын геополитикийн нөхцөл байдал хурцдаж буй өнөө үед Банк нь хориг арга хэмжээг зөрчихгүй байхад чухал ач холбогдол өгч, энэ чиглэлийн шинэ технологи, хяналтын системд хөрөнгө оруулалт хийж, өөрийн гадаад харилцаа, харилцагчийн үйл ажиллагаа, төлбөр тооцоог хоригийн жагсаалттай тулган шалгах үйл ажиллагаагаа дараагийн түвшинд гаргав.

- Хараат бус хяналт: Банк нь өөрийн МУТСТ дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд олон улсын нэр хүнд бүхий мэргэжлийн байгууллагаар хараат бус хяналт, шалгалт хийлгэж өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Эрсдэлийн соёлын хөтөлбөр

- Банк нь жил бүр Эрсдэлийн соёлын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд хөтөлбөрийн хүрээнд ёс зүй, эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, мэдээллийг бататгах, дээшлүүлэх сургалт, өдөрлөгийг зохион байгуулдаг.

- 2025 онд “Ёс зүй, эрсдэлийн форум”-ыг 2019 оноос хойш 4 дэх удаагаа амжилттай зохион байгуулсан. Форумд төвийн болон салбар нэгжийн Ёс зүйн төлөөлөгч нар танхимаар болон цахим платформоор оролцсон.



Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь банкны дотоод үйл ажиллагаа, системүүдийн хяналтын хангалтгүй байдал, гадаад орчны таагүй нөлөөлөл болон хүний хүчин зүйлээс шалтгаалан эрсдэлийн зохистой түвшинг хангаж чадахгүй болохыг хэлнэ.

Эрсдэлийн удирдлагын бодлого

Банкны Эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам нь үйл ажиллагааны эрсдэлийг удирдах арга аргачлал, үүрэг хариуцлага, хяналтын тогтолцоо болон эрсдэлийг удирдах үйл ажиллагааг зохицуулсан суурь баримт бичиг юм.

Банкны Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам болон түүнд нийцүүлэн гаргасан бусад бодлого, журам, заавар, аргачлалын хүрээнд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлдэг. Үүнд:

- Эрсдэл, хяналтын өөрийн үнэлгээ, Тохиолдлын сан болон Эрсдэлийн түлхүүр үзүүлэлтийн тайлагнал

- Бизнесийн тасралтгүй ажиллагаа, Нөөцөөс сэргээх төлөвлөгөө болон бизнесийн тасралтгүй ажиллагааны бэлэн байдлын туршилт

- Гуравдагч талын эрсдэлийн удирдлага (магадлан шалгах, гэрээний хяналт болон гүйцэтгэлийн мониторинг)

- Зохицуулагч байгууллага болон олон улсын стандартад нийцсэн мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдлын хяналтууд (хандалтын удирдлага, эмзэг байдлын удирдлага, аюулгүй байдлын мониторинг, будилаанд хариу үзүүлэх төлөвлөгөө)

- Луйврын эрсдэлийн удирдлага (гүйлгээний хяналт, харилцагчийг танин баталгаажуулах, ажилтнуудын мэдлэгийг сайжруулах, баталгаажуулах)

- Хяналтын сул талыг арилгах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих

Эрсдэлийн удирдлагын арга зүй

Эрсдэлийн тохиолдлын сан

Банк нь Үйл ажиллагааны эрсдэлийг Банкны хяналтын Базелийн хорооноос гаргасан дараах ангилалд нийцүүлэн ангилж, бүртгэж, тайлагнадаг. Үүнд:

1. Дотоод луйвар
2. Гадаад луйвар
3. Хөдөлмөр эрхлэлт ба ажлын байрны аюулгүй байдал
4. Хэрэглэгч, бүтээгдэхүүн үйлчилгээ ба бизнесийн туршлага
5. Биет хөрөнгийн хохирол
6. Бизнесийн тасалдал, системийн доголдол

7. Гүйцэтгэл, хүргэлт ба процесс менежмент

Эрсдэл, хяналтын өөрийн үнэлгээ

Банк нь үйл ажиллагаанд тохиолдож болзошгүй эрсдэлийг илрүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс жил бүр бүх нэгжээр Эрсдэл, хяналтын өөрийн үнэлгээг хийлгэж, үр дүнг холбогдох хороо болон удирдлагуудад тайлагнадаг.

Эрсдэлийн түлхүүр үзүүлэлт

Банкны Эрсдэлийн аппетитийн мэдэгдэл, бизнес төлөвлөгөөтэй нийцсэн Эрсдэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг бөгөөд дараах үйл ажиллагаанд онцгой ач холбогдол өгч ажилладаг. Үүнд:

- Банкны үндсэн системүүдийн хэвийн ажиллагаа, логийн бүрэн бүтэн байдал

- Кибер аюулын орчин болон бэлэн байдал

- Процесс автоматжуулалт болон өөрчлөлтийн удирдлагын чанар

- Гол үйлчилгээ болон нийлүүлэгчдийн тогтвортой байдал

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын үр дүнтэй байдал болон оновчтой шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор Эрсдэлийг хянах самбар, Эрсдэлийн бүртгэл, Тохиолдлын сан, Эрсдэлийн түлхүүр үзүүлэлт болон Эрсдэлийн зөвлөмжийн бүртгэл зэрэг функциональ боломжтой Эрсдэлийн удирдлагын системийг ашигласан. Үүний үр дүнд үйл ажиллагааны эрсдэлийн аппетитийг хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.

Тайлант хугацаанд, Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, Эрх зохицуулалтын журам, Даатгалын ерөнхий журам болон Зайнаас ажиллах эрсдэлийн үнэлгээ аргачлал зэрэг баримт бичгүүдийг шинэчлэн сайжрууллаа.

Түүнчлэн санхүүгийн бус эрсдэлийн удирдлагыг сайжруулах үүднээс Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хороог байгууллаа.

Бизнесийн тасралтгүй ажиллагаа

Голомт банк 2024 онд Бизнесийн тасралтгүй ажиллагааны олон улсын ISO 22301:2019 стандартыг нэвтрүүлж, баталгаажуулсан Монгол Улсын анхны банк санхүүгийн байгууллага болсон.

ISO 22301:2019 (Business Continuity Management System) стандартыг нэвтрүүлснээр Голомт банк аливаа эрсдэлийн үед уян хатан байдлаа хадгалж, үйл ажиллагаагаа тогтвортой, хэвийн үргэлжлүүлэх бүрэн чадамжтай гэдгийг нотолж буйн баталгаа юм.

Тайлан хугацаанд Банк нь стандартын шаардлагыг бүрэн хангасан гэж хараат бус аудиторроор жил бүрийн хяналтын аудитын хүрээнд амжилттай үнэлэгдсэн.

Мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлага

Голомт банк мэдээллийн технологиос үүдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс мэдээллийн технологитой холбоотой эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, үнэлэх, хариу арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх болон тайлагнах процессыг тогтмол хэрэгжүүлж байна.

Эрсдэлийн удирдлагын бодлого

Банкны Эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон Мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын журам нь мэдээллийн технологийн эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, бууруулах арга хэмжээ авах, хянах, тайлагнах ажиллагааг зохицуулсан суурь баримт бичиг юм.

Мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын журмын зорилтууд нь:

- Мэдээллийн технологийн өөрчлөлттэй холбоотой үүсэж болзошгүй эрсдэлийг удирдах;
- Нийлүүлэгч байгууллагатай холбоотой эрсдэлийг удирдах;
- Бизнесийн тасралтгүй ажиллагаатай холбоотой эрсдэлийг удирдах;
- Логийн бичилт, хадгалалт, бүрэн бүтэн байдлын эрсдэлийг удирдах.

Эрсдэлийн удирдлагын арга зүй

Банкны мэдээллийн технологийн эрсдэлийг удирдах дараах төрлийн хяналтуудыг тогтмол хэрэгжүүлдэг. Үүнд:

- Мэдээллийн технологийн нийлүүлэгчийн эрсдэлийн удирдлага
- Банкны дата төвүүдийн шалгалт
- Банкны Бизнесийн тасралтгүй ажиллагааны болон Нөөцөөс сэргээх туршилт
- Мэдээллийн технологийн эрсдэлийн аппетит, гүйцэтгэлийн мониторинг
- Системийн логийн бүрэн бүтэн байдлын шалгалт
- Банканд хэрэгжиж буй төслийн хяналт
- Бизнесийн нөлөөллийн дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ

Тайлант хугацаанд Мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын журам, Лог удирдлагын журам, Мэдээллийн технологийн нийлүүлэгчийн эрсдэлийн үнэлгээний аргачлал, Бизнесийн нөлөөллийн шинжилгээний болон эрсдэлийн үнэлгээний аргачлалыг шинэчлэн сайжрууллаа.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл

Голомт банк нь харилцагчийн мэдээллийг хамгаалахын тулд олон улсын нэр хүнд бүхий шинэчлэгдсэн мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болох ISO27001:2022 стандарт, Төлбөрийн картын аюулгүй байдлын PCI-DSS 4.0, PCI-3DS 1.0 стандартууд болон хувь хүний өгөгдөл хамгааллын хуулийн хэрэгжилтийг хангах GDPR буюу Европын холбооны хувь хүний өгөгдөл хамгаалах тухай хуулийн шаардлага, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай ISO27701:2019 стандартуудыг ханган үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн олон улсын төлбөрийн систем болох Swift -ийн хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангах Customer Security Program v2025 (CSP)-ын хэрэгжилтийн үнэлгээг дотоод болон ОУ-ын гуравдагч байгууллагаар баталгаажуулсан.

2025 онд мэдээллийн аюулгүй байдлын хамгаалах олон төрлийн арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам,

зааварчилгааг шинэчлэн боловсруулж, ажилтнуудад зориулсан сургалт болон чиглэсэн хөтөлбөрүүдийг зохион байгуулсан. Онцлох арга хэмжээ нь банкны нийт ажилтныг чадавхжуулах МАБ-ын мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулдаг Golomt Guard “Capture the Flag” тэмцээн байдаг. Мөн бүх төрлийн эрсдэл өндөр бүхий ажилтнаас шалтгаалж болох халдлагын симуляциудыг зохион байгуулж байна. (Жишээ нь SMS фишинг, и-мэйл фишинг гэх мэт)

Голомт банк нь улам нарийсч буй кибер аюул заналын орчинд кибер хамгаалалтыг бэхжүүлэх зорилтоо тасралтгүй ханган ажиллаж байна. Үүний тод илрэл нь банкны систем руу чиглэсэн гадны кибер халдлагаас хамгаалах зорилгоор Security Operations Maturity Model (SOMM) стандартын шаардлагуудыг бүрэн хангасан Кибер Аюулгүй Байдлын Удирдлагын төв (КАБУТ)-ийг бий болгон ажиллаж байна. Энэхүү төв хосолсон хэлбэрээр буюу ОУ-ын кибер аюулгүй байдлын хяналтын

үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хамтран 24/7 бодит цагийн горимоор хяналтыг хэрэгжүүлэн илэрсэн халдлага, довтолгоог зогсоох, хариу арга хэмжээ авах (SOAR), урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн кибер аюулгүй байдлын хамгаалалтын тоног төхөөрөмж, программ хангамжууд нь олон улсын судалгааны байгууллагуудаар үнэлэгдэж салбартаа шилдэг (Leader) шийдлүүдийг ашиглаж байна. Банк нь “defence-in-depth” буюу давхарласан хамгаалалтыг хүн-процесс-технологийн түвшинд хэрэгжүүлж ажилладаг. Мөн кибер эрсдэлийг бууруулах арга хэмжээг банкны процесстэй уялдуулан хэрэгжүүлэхийн зэрэгцээ, томоохон кибер эрсдэлийн үед үүсэж болзошгүй тодорхой зардлуудын санхүүгийн нөлөөллийг бууруулах зорилгоор кибер эрсдэлийн даатгалын хамгаалалтыг ашигладаг.

Банкны системүүд рүү ажилтнуудын хандах үйл ажиллагааг олон улсын шилдэг зарчмууд (Хамгийн бага эрхийн зарчим, Тэг итгэлцлийн зарчим болон хиймэл оюун ухаанд суурилсан зөрчил илрүүлэх систем) дээр тулгуурлан хяналт тавьж ажиллаж байна. Мэдээллийн аюулгүй байдлын нэгж нь банкны ажилтнуудын үндсэн системүүдийн эрхийн хяналтыг тогтмол хийж гүйцэтгэдэг нь дотоод залилан, луйвар гаргахаас урьдчилан сэргийлж байна.

Банкны интернэт хандалттай болон дотоод системүүдийн эмзэг байдлын шалгалтыг олон улсын хөндлөнгийн болон дотоодын шилдэг гэрээт кибер аюулгүй байдлын экспертүүд хийж гүйцэтгэдэг. Мөн Bug Bounty хөтөлбөр буюу олон улсын ёс зүйт хакерууд нь банкны системээс

эмзэг байдлыг илрүүлэн урамшуулал авах хөтөлбөрт Голомт банк нэгдсэн байдаг. Ингэснээр эмзэг байдал ашиглан харилцагчийн мэдээлэл руу халдах гэсэн оролдлогыг цаг алдалгүй мэдэх боломжтой болсон.

Дижитал банкны үйлчилгээ өргөжин тэлэхийн хэрээр цахим залилан (fraud), нийгмийн инженерчлэлд суурилсан халдлага, цахим сувгаар үйлдэгдэх санхүүгийн луйвар нь банкны хувьд анхаарах ёстой өндөр ач холбогдолтой эрсдэл болж байна. Үүнд харилцагчийн эрхийг хууль бусаар ашиглах, данс булаах (Account Takeover), цахим төлбөр тооцооны залилан, фишинг болон мессежээр үйлдэгдэх залилан зэрэг эрсдэл багтдаг.

Голомт банк нь эдгээр дижитал эрсдэлийг бууруулах зорилгоор хүн процесс технологи д суурилсан нэгдсэн хяналт, хамгаалалтын тогтолцоог хэрэгжүүлж байна. Үүнд, харилцагчийн гүйлгээ, нэвтрэлтийн хэв шинжид зан төлөвийн шинжилгээ (behavior analytics) хийж, хиймэл оюун ухаанд суурилсан залилан илрүүлэх, урьдчилан сэргийлэх системүүдийг бодит цагийн горимоор ашиглаж байна. Сэжигтэй үйлдэл илэрсэн тохиолдолд гүйлгээг автоматаар саатуулах, нэмэлт баталгаажуулалт хийх, эрсдэлийн түвшингээр ангилан хариу арга хэмжээ авах механизмыг хэрэгжүүлдэг. Мөн банк нь олон хүчин зүйлт баталгаажуулалт (MFA), гүйлгээний хязгаарлалт, эрсдэлд суурилсан нэвтрэлтийн бодлого, төхөөрөмж болон байршлын хяналтыг цахим сувгуудад нэвтрүүлснээр харилцагчийн данс, мэдээлэлд хууль бус нэвтрэх оролдлогыг бууруулж байна.



Тогтвортой хөгжил

Голомт банкны уур амьсгал болон усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах дунд болон урт хугацааны зорилтууд.

Хүлэмжийн хийн ялгарал

2030 30%
2050 50%

Усны нөөц


2030 5%
2050 10%

Тогтвортой санхүүжилт

Голомт банк байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажиллана гэдгээ стратегийн нэг чиглэл болгон баталж, 2019 оноос эхлэн Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд харилцагчдын ногоон шилжилтийг дэмжин ажиллаж байна. Өнгөрсөн 6 жил гаруйн хугацаанд бид нийт 1.1 их наяд төгрөгийн

тогтвортой, ногоон санхүүжилтийг олгожээ. Үүнээс 2025 онд нийт 270 тэрбум (2024: 308 тэрбум төгрөг) төгрөгийн ногоон санхүүжилт олгосон ба 2025 оны 12-р сарын 31-ний байдлаарх тогтвортой, ногоон зээлийн багц 406 тэрбум (2024: 265 тэрбум төгрөг) төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Голомт банкны ногоон зээлийн багц /сая төгрөг/



Ингэснээр Голомт банкны нийт зээлийн багцын 4.9%-ийг ногоон зээлийн багц бүрдүүлж байна. Банк нь 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувийг тогтвортой, ногоон зээлийн багцаар бүрдүүлэх зорилтыг тавин

ажиллаж байна. Тус зорилтод хүрэхээр дараах 6 төрлийн тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгоод байна.


Голомт банк харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүний сонголтыг нэмэгдүүлэв.

	Хүү (сарын)	Дээд хэмжээ	Хугацаа
Тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүн	1.2% - 1.4%	5-10 тэрбум төгрөг	30-84 сар
Хүү хуваан төлөх нөхцөлтэй бизнесийн ногоон зээл	1.2% - 1.4%	Бүтээгдэхүүний дүнгээс хамаарна	84 сар
Ногоон АОС зээл	1.25%-1.4%	160-300 сая төгрөг	120-240 сар
Эко автомашины зээл	1%-1.1%	Бүтээгдэхүүний дүнгээс хамаарна	30-96 сар
Ногоон хэрэглээний зээл	1.25%	Бүтээгдэхүүний дүнгээс хамаарна	30 сар
Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих	1.2% - 1.4%	100 сая төгрөг	36 сар

Зээлийн үйл ажиллагаандаа Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг олон улсын болон дотоодын дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж байна.

Голомт банк байгаль орчин, нийгмийн эрсдэлийг таних, хэмжих, үнэлэх, хянах, тайлагнах, бууруулах, удирдахад шаардлагатай банкны бодлого журмууд болон тогтолцоог ногоон эдийн засагт шилжих Үндэсний төлөвлөгөөтэй уялдуулан байгаль орчны холбогдох хууль тогтоомж, бодлого журамд нийцүүлэн үйл ажиллагаанаас учирч болох эрсдэлийг удирдаж байна.

2025 онд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн нийт 1646 үнэлгээг зээлийн үйл ажиллагаанд хийж гүйцэтгэлээ. Нийт хийсэн үнэлгээний 71% нь эрсдэлгүй салбаруудад харьяалагдах ба үүнээс 69%-д нь санхүүжилт олгогдсон байна. Үлдсэн 29% нь байгаль орчин, нийгэмд нөлөөлөх нөлөө өндөр салбаруудад харьяалагдах ба үүнээс 56%-д нь санхүүжилт олгогджээ.



Дотоод карбон үнэ ба шилжилтийн санхүүжилт

Голомт банк санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн шилжилтийн эрсдэлийг удирдах зорилгоор анх удаа дотоод карбон үнийг баталж, зээлийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэллээ. Ингэснээр тогтвортой ногоон санхүүжилтийг эрчимжүүлэх,

харилцагчдын ногоон бизнесийн шилжилтийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн шилжилтийн эрсдэлийг удирдах боломжтой болохоос гадна санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах зорилгын хэрэгжилтийг хангахад хөшүүрэг болж байна.

Банкнаас хэрэгжүүлсэн, дэмжин ажилласан төсөл, хөтөлбөр, арга хэмжээ

"Цэнхэр" санхүүжилтийн боломжууд ба олон талт хамтын оролцоо	"Ногоон дэлхийг өвлүүлье" хөтөлбөр	"Цөлжилттэй тэмцэхэд залуусын оролцоо" Үндэсний форум
"Жендэрийн хүртээмжтэй манлайлал" удирдлагын түвшний сургалт	Ногоон өсөлт 2025 бизнес аялал	"Урьдчилан цэвэрлэх байгууламж барих" чиглэлээр Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сантай хамтарсан техник туслалцаа

Бизнесийн үйл ажиллагаа

Байгууллагын зах зээл

The best Corporate Banking in Mongolia

Голомт банк Монгол Улсын эдийн засгийн хөдөлгөгч хүч, салбарын манлайлагч болсон ТОП 100 аж ахуйн нэгжийн 95 хувьтай хамтран ажиллаж байна. Мөн стратегийн ач холбогдол бүхий томоохон аж ахуйн нэгж байгууллагууд, эдийн засгийг бүрдүүлэгч бизнесийн салбарын гол төлөөлөгч байгууллагуудад санхүүжилт олгох, тэдгээрийн шаардлагад нийцсэн тусгайлсан үйлчилгээг хүргэх замаар хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллалаа.

2025 онд банкны секторт байгууллагын зээлийн 21.8 хувь, эх үүсвэрийн 25.8 хувийг бүрдүүлжээ.

- Тайлант хугацаанд харилцагчийн сэтгэл ханамжийг 91%-д хадгалж, “Best Corporate Banking” амжилтаа бататгав.

- Эрчим хүч, ус дулааны хэмнэлттэй, дулаан тохируулгын смарт системтэй барилгын төслүүдэд нийт 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шинээр олгож, тогтвортой, ногоон зээлийн багцыг 230 тэрбум төгрөгт хүргэлээ.

- Монгол Улсын хэмжээний нийт биет алт тушаалтын 48%-ийг

дангаар бүрдүүлж, тэргүүлэх байр сууриа хадгалав.

- Санхүүгийн түрээсийн албан ёсны дилер байгууллагын тоог 2 дахин нэмэгдүүлснээр багцыг 2 дахин нэмэгдүүлж, 257.3 тэрбум төгрөгт хүргэв.

Дижиталчлал

Нийт корпорэйт харилцагчийн 99% нь интернэт банкны үйлчилгээ ашигладаг бөгөөд тэдгээрийн 21% нь корпорэйт гэйтвэй, 16% нь и-коммерс, 20% нь payroll, 10% нь SocialPay үйлчилгээг ашигладаг боллоо.

Интернэт банк

99%

Payroll

20%

Корпорэйт гэйтвэй

21%

SocialPay

10%

И-Коммерс

16%

Санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр

Шатахууны нийлүүлэлт

Монгол Улсын шатахууны төлбөр тооцооны 80-85%-ийг, газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх, шатахууны хангамжийн тасралтгүй байдлыг хадгалахад 40 орчим мянган тонн газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх санхүүжилтийн 33%-ийг Голомт банк дангаараа санхүүжүүлж байна.

Худалдааны үйлчилгээний салбар

Улаанбаатар хотод шинээр нээгдсэн томоохон худалдаа, үйлчилгээний

төвүүдэд 80 тэрбум төгрөгийн санхүүжилт олгов.

Ноолуур

“Цагаан алт” хөтөлбөрийн зээлээр 48 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд Голомт банк ноолууран эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 80%-ийг дангаар санхүүжүүлэхээр боллоо.

Эмийн бүтээгдэхүүний үйлдвэр

Монгол Улс төдийгүй төв Ази тивд анхны ургамлын гаралтай хатуу

эмийн бүтээгдэхүүний үйлдвэрийг ногоон зээлээр санхүүжүүлэв. Энэхүү үйлдвэр нь цаашид Монгол Улсын экспортын орлогыг нэмэгдүүлэх өндөр ач холбогдолтой.

Хүнс, хөдөө аж ахуй

- АТАР-4 хүнсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлийн хүрээнд шингэн хүнс, сүү, ус, ундааны үйлдвэрүүд, даршилсан ногоо болон чихрийн үйлдвэрт шинээр 20 тэрбум төгрөгийн санхүүжилт олгов.

- АТАР-4 хөдөө аж ахуй, газар тариалангийн тогтвортой хөгжлийн чиглэлийн хүрээнд 32 тэрбум төгрөгийн санхүүжилт шинээр олголоо.

Уул уурхай

Голомт банк уул уурхайн салбарын нийт санхүүжилтийн 20 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Эрчим хүч

Монгол Улсын эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадлыг 2025 онд 12.7 хувиар нэмэгдүүлж, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангахад санхүүжилтээр хувь нэмрээ оруулан ажиллалаа.

Мега төсөл

- Франц улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр

санхүүжүүлсэн, Улаанбаатар хотод 2026 онд 3-р улиралд ашиглалтад орох “Нийслэлийн нийтийн тээвэрт Дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-д 1.36 сая еврогийн баталгаа гаргав.

- Дэд бүтэц, барилга, цахилгаан станц, авто зам, гүүр зэрэг улсын хэмжээний 27 төсөлд 100 гаруй тэрбум төгрөгийн дотоодын баталгаа гаргалаа.

Арга хэмжээ

 <p>500+ корпорэйт байгууллагын санхүүгийн менежер</p>	 <p>400+ хариуцлагатай уул уурхайн компани 6+ жил</p>	<p>Элчин сайдын яамдуудын хөлбөмбөгийн тэмцээн 18 байгууллагын 400 гаруй төлөөлөл 13+ жил</p>
<p>Топ харилцагчийн хүлээн авалт 300+ Топ корпорэйт компанийн захирлууд болон хувьцаа эзэмшигчид 10+ жил</p>	<p>Ulaanbaatar Auto Show 2025 Алтан ивээн тэтгэгч 2+ жил</p>	<p>ADVENTURE TOUR 2025 6+ жил</p>
		<p>Mining week & MinePro 2025 Ивээн тэтгэгч 4+ жил</p>

Жижиг, дунд бизнесийн зах зээл

Голомт банк “Жижиг, дунд бизнесийг дэмжигч банк” уриан дор 2025 онд бизнес эрхлэгчид болон банк хоорондын харилцаа, хамтын ажиллагааг илүү хүчирхэгжүүлэх зорилт тавин ажиллалаа. Үүний хүрээнд:

- Бизнес эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээг нь хангах зорилготой зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулж, шаардлагатай санхүүжилтүүдийг олгов.

- Бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, бойжуулах бизнес хөгжлийн хөтөлбөрүүд болон нетворкинг арга хэмжээнүүдийг зохион байгуулав.

- “Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжигч банк” уриан дор эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан тусгайлан сургалт хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээ.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгосон зээлийн багцын өсөлт

27%

Жижиг, дунд бизнес эрхлэгчдээс татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн өсөлт

24%

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих шинэ бүтээгдэхүүн:

- Худалдааны бичил зээл
- Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан шуурхай зээл
- Дотоодын шуурхай баталгаа

Нийт жижиг, дунд бизнесийн зээлдэгчийн тоон өсөлт

18%

Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан бизнесийн зээлийн багцын өсөлт

28%

Бизнес хадгаламж

- Байгууллагын хуримтлал

Бизнес эрхлэгчдэд чиглэсэн тусгайлан үйлчилгээ явуулах зорилтот 2 бизнес төвийг Ай Си Тауэр болон Блю скай оффист байгуулав.

Хамтын ажиллагаа

- Голомт банк болон МҮХАҮТ хамтран ажиллах санамж бичиг байгуулж, ОУ-ын WEIDE fund төсөлд шалгарсан бизнес эрхлэгч 50 эмэгтэйд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр хүргэх боломжтой болов.
- Голомт банк эдийн засагт жөндөрийн тэгш боломж, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах, бизнесийн үйл ажиллагааг нь дэмжих зорилгоор Санхүү банкны эмэгтэйчүүдийн холбоо, бусад банк болон

холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах “Хамтын түншлэл” үндэсний хөтөлбөр-т нэгдэв.

- Монголын банкны холбоо, ЕСБХБ болон Дэлхийн банкны санаачилгаар Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлж буй “We finance code – Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн код хөтөлбөр”-т Голомт банк нэгдлээ. Ингэснээр бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг тэлэв.

- Голомт банк хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, санхүүгийн боловсрол олгох зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш хүртээмж итгэл” ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулав. Хамтын ажиллагааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж, банкны арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүддээ хамруулахаас гадна хөнгөлөлттэй санхүүгийн бүтээгдэхүүн санал болгоно.

Үйл ажиллагаа



Бизнес эрхлэгчдэд зориулсан хөгжлийн хөтөлбөр



Business conference 2025

“Business conference” арга хэмжээг Улаанбаатар, Дархан хотод зохион байгууллаа. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулан 6 дахь жилдээ зохион байгуулж буй арга хэмжээний хүрээнд геополитик, хиймэл оюун ухааны шийдлүүд, макро эдийн засгийн төлөв байдал, шинэ үеийн менежментийн чиг хандлага болон жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тулгарч буй асуудлын талаар сонирхолтой илтгэлүүдийг хүргэж, хамтдаа туршлагаа хуваалцлаа.



Менторшип 2025 хөтөлбөр

Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг чадавхжуулах, бойжуулах зорилготой “Менторшип 2025” хөтөлбөрийг 4 дэх жилдээ зохион байгуулж, 100 харилцагчийг хамрууллаа. Харилцагчид хөтөлбөрт хамрагдсанаар борлуулалтын орлого нь 30-40 хувь, үр ашиг 17 хувиар өсөж, шинээр 37 ажлын байр нэмэгдүүлж, шинээр 13 салбар нэгж нээсэн амжилттай үзүүлэлттэй байна.

SME Business Academy

Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан бизнес хөгжлийн хөтөлбөрүүдийг Голомт - Бизнес академиас хэрэгжүүллээ. Энэ хүрээнд:

- Бизнес эрхлэгчдэд тулгардаг асуудлуудын шийдлийг олох, бизнесийн үйл ажиллагаагаа дараагийн шатанд гаргахад нь шаардлагатай сургалт, мэргэжлийн зөвлөгөө өгөх;
- Бодит бизнесийн сайн туршлагаудтай танилцуулах;
- Борлуулалтыг дэмжсэн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах;
- Харилцагч болон хамтран ажилладаг байгууллагуудын арга хэмжээнд банкны болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг таниулан сурталчлах зэрэг өргөн цар хүрээтэй ажлуудыг хийж гүйцэтгэв.

Хөгжлийн хөтөлбөрт бизнес эрхлэгч 1,000 эмэгтэй, 1,700 бизнес эрхлэгчийг хамруулж, сургалт, зөвлөгөө, нетворкинг арга хэмжээнд оролцуулав.

Иргэдийн зах зээл

Голомт банк тайлант хугацаанд зах зээлд эзлэх иргэдийн сегментийн байр сууриа нэмэгдүүлэх, харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулж, салбарт чиглэсэн дижитал шилжилтийн өнгө төрхийг бий болгох чиглэлээр ажиллалаа.

Иргэдийн эх үүсвэрийн зах зээлд эзлэх хувь

17%

Даатгалын зуучлалын үйл ажиллагаа

Нийт харилцагч, зээлдэгч нартаа санхүүгийн нэгдсэн үйлчилгээг үзүүлж, банкны даатгалын зуучлалын зах зээлийн 28 хувийг бүрдүүлж, банкны даатгалын зуучлалын /банкашуранс/ зах зээлийг тэргүүлэв.

Даатгалын хүртээмж

- Даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж, ач холбогдлыг таниулан сурталчилж, зээлдэгч нарын 92-оос дээш хувийг тогтмол даатгалд хамруулж байна.
- Амьдралын даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, ипотекийн болон өөрийн эх үүсвэрийн орон сууцны зээлдэгч нарт санал болгож байна.
- Алтантүлхүүр хүүхдийн хадгаламж эзэмшигч хүүхдүүдийг гэнэтийн ослын даатгалд хамруулав.
- VIP харилцагч нартаа зориулсан Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг нэвтрүүлэв.

Орон сууцны зээл

Хамтран ажилладаг төсөл хэрэгжүүлэгч, гэрээт байгууллагуудын тоог нэмэгдүүлж, орон сууцны зээлийн борлуулалтаар дэмжин ажиллалаа. 2024 онтой харьцуулахад 2025 оны 4-р улирлын байдлаар өөрийн эх үүсвэрийн орон сууцны зээл 29.6%-аар өсөв.

Иргэдийн зээлийн зах зээлд эзлэх хувь

17%

Ипотекийн зээл

Ипотекийн зээлийг нэн тэргүүнд зорилтот харилцагчид нь хүргэх, нээлттэй шударга тогтолцоог бүрдүүлэхийг зорилгоо болгож, зохицуулагч байгууллагуудтай хамтран удирдлагаар ханган ажиллалаа. Тайлант хугацаанд 3 багцын 351 тэрбум төгрөгийн багц худалдаж, Монголбанк болон Банкны өөрийн эх үүсвэрээс 267 тэрбум төгрөгийн зээлийг 6 хувийн хүүтэйгээр 2,118 иргэнд олгож, орон сууцжуулав.

Сувгийн өргөжилт

2025 онд нийт 5 салбар тооцооны төв, 1 хадгаламжийн кассыг нээж, үйл ажиллагааг амжилттай эхлүүлэв. Мөн харилцагчдад банкны үйлчилгээг тав тухтай орчинд хүргэх, ажилтнуудыг таатай ажлын байранд үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор тайлант хугацаанд салбар, тооцооны төвүүдийн байршил өөрчлөх, талбай нэмэх, талбайн зохион байгуулалт зэрэг засвар тохижилтын ажлыг хийж, гүйцэтгэв.

Борлуулалтын бусад ажил

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдад шуурхай хүргэх зорилгоор газар дээр нь борлуулах, бүртгэх, мэдээлэл өгөх арга хэмжээг хэмжээг зохион байгуулдаг. Тайлант хугацаанд Шууд борлуулалтын алба нь 628 байгууллагатай хамтран ажиллаж, банкны 37 мянга гаруй бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулан ажиллалаа. Энэ хүрээнд нийт 26.2 тэрбум гаруй төгрөгийн зээлийн багцыг бүрдүүлэв.

VIP харилцагчийн сэтгэл ханамж, харилцагчийн үйлчилгээний ялгарлыг сайжруулах зорилготой консьерж үйлчилгээг үзүүлж



PREMIER
BANKING

эхэллээ. Ингэхдээ банк санхүүгийн үндсэн бүтээгдэхүүнийг дагалдуулж, харилцагчийн бусад хэрэгцээ шаардлагыг хангах, банкны өөрийн болон гуравдагч байгууллагуудын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг авах эрх олгох, бэлэглэх, зуучлах, дамжуулан хүргэх хэлбэрээр 26 төрлийн үйлчилгээг үзүүлж байна.

Олон улсын бизнес, хамтын ажиллагаа

Голомт банк 2011 оноос хойш дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагууд болох Moody's, S&P Global болон Fitch Ratings-тэй хамтран ажиллаж, өөрийн зээлжих зэрэглэлийг тогтмол үнэлүүлж ирсэн. 2025 онд эдгээр үнэлгээний агентлаг нь Голомт банкны зээлжих зэрэглэлд дараах сайжруулалтыг хийв.

- Moody's: Зээлжих зэрэглэлийг нэг шат ахиулж, "B1, тогтвортой"

төлөвтэй болгов.

- S&P Global: Зэрэглэлийг B+ хэвээр хадгалж, төлөвийг "эерэг" болгон өөрчлөв.
- Fitch Ratings: Зээлжих зэрэглэлийг "B+, тогтвортой" гэж үнэлэв.

Эдгээр эерэг өөрчлөлт нь Голомт банкны санхүүгийн тогтвортой байдлыг бататгаж, олон улсын хөрөнгө оруулагчдын итгэлийг улам нэмэгдүүлж буйг илтгэж байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэл

- Moody's: Нэг шат ахиулж, "B2, тогтвортой"-оос "B1, тогтвортой" болгон сайжруулав.
- S&P Global: Зээлжих зэрэглэлийг BB-, тогтвортой болгон шинэчлэв.
- Fitch Ratings: Монгол Улсын зэрэглэлийг "B+, тогтвортой" төлөвтэй хэвээр хадгалав.

Moody's

Ангилал	"Moody's" үнэлгээ
Зээлжих зэрэглэлийн үнэлгээ	B1
Төлөв	Stable
Зээлжих чадварын суурь үнэлгээ	B3
Үнэт цаасны үнэлгээ	B2

S&P Global

Ангилал	"S&P" үнэлгээ
Зээлжих зэрэглэлийн үнэлгээ	B+
Төлөв	Positive
Үнэт цаасны үнэлгээ	B+

Fitch Ratings

Ангилал	"Fitch" үнэлгээ
Зээлжих зэрэглэлийн үнэлгээ	B+
Төлөв	Stable
Тогтвортой байдлын үнэлгээ	B

Хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч түнш байгууллагууд



Олон улсын санхүүгийн байгууллагуудаас татсан урт хугацаат санхүүжилтийн хэмжээ

+\$320 сая

- Голомт банк 2025 онд Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд ногоон болон цэнхэр санхүүжилт, жижиг, дунд бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн урт хугацаат санхүүжилтийн эх үүсвэрийг амжилттай татан төвлөрүүлэв.
- Олон улсын ашгийн бус байгууллага болох Water.org болон АНУ-ын WaterEquity байгууллагатай хамтран ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр нийт 13 сая ам.долларын санхүүжилт бүхий гадаадын эх үүсвэрийг амжилттай татан төвлөрүүлэв. Хамтын ажиллагааны хүрээнд Голомт банк 2023-2025 он хүртэл нийт 23.3 тэрбум төгрөгийн зээлийг олгож, 23 жижиг, дунд бизнес эрхлэгчийн төслийг дэмжин ажиллаж, харилцагчдадаа усны үр ашигтай хэрэглээ, хэмнэлтийн талаар сургалт, зөвлөгөөнд хамрууллаа.



• Голомт банк олон улсад нэр хүндтэй, томоохон хөрөнгө оруулалтын сан болох Triple Jump байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлж, анхны санхүүжилтийг татлаа. 5.8 сая ам.долларын урт хугацаат санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ. Уг санхүүжилт нь Голомт банкны бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, өрхийн аж ахуй, худалдаа, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэх юм.



Олон улсын хурал, уулзалт, арга хэмжээ

Голомт банк олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол Улсын банк, санхүүгийн салбарыг сурталчлан таниулах зорилгоор 2025 онд олон улсын хурал, зөвлөгөөн, уулзалтад амжилттай оролцлоо.

AFIFORUM 2025	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны 2025 оны Жилийн уулзалт	Азийн хөгжлийн банкны 58 дахь удаагийн жилийн уулзалт
CIPS Exhibition on Bank-Enterprise Collaboration (CEBEC) арга хэмжээ	SIBOS 2025	Худалдааны салбар дахь эмэгтэйчүүдийн манлайлал хөтөлбөр
	ADB TSCFP AWARD 2025	

Олон улсын корреспондент банкнууд

Тайлант хугацаанд Голомт банк 15 төрлийн валютын 49 корреспондент дансны өргөн сүлжээгээр дамжуулан харилцагчдадаа гадаад төлбөр тооцооны үйлчилгээг найдвартай, хурдан, зардал багатайгаар хүргэсээр байна.

Гадаад төлбөр тооцооны зах зээлд эзлэх хувь

Монгол Улсын хэмжээнд нийт гадаад төлбөр тооцооны гүйлгээний 29%-ийг, гүйлгээний дүнгээр 32%-ийг Голомт банк дангаар гүйцэтгэлээ.

KB Kookmin Bank	OCBC Bank	KEB Hana Bank	SHINHAN BANK	中國銀行 BANK OF CHINA
交通銀行 BANK OF COMMUNICATIONS	蒙商银行 MENG SHANG BANK	ICBC	Bank of Inner Mongolia	Berliner Sparkasse
DBS	ODDO BHF	COMMERZBANK	BNY	Crown Agents Bank
CaixaBank	中国农业银行 AGRICULTURAL BANK OF CHINA	中国建设银行 China Construction Bank	MIZUHO	SMBC
MUFG	ANZ	mBank	TÜRKIYE BANKASI	ANZ


Гадаад худалдааны санхүүжилт

Голомт банк гадаад худалдааны санхүүжилтийн үйлчилгээгээр тэргүүлэгч байр сууриа хадгалсаар байна.

Голомт банк гадаад худалдаа эрхэлдэг харилцагч нартаа худалдааны санхүүжилтийн цогц үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд саадгүй хүргэх зорилгоор олон улсын 300 гаруй түнш банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран өртөг багатай санхүүжилтийн шийдлийг санал болгохын зэрэгцээ импорт, экспортын эргэлтийг нэмэгдүүлэх, үүсэж болох төлбөрийн болон нийлүүлэлтийн эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тухайлбал, 2025 онд Голомт банкны Худалдааны санхүүжилтийн нийт багц 557.93 тэрбум төгрөг (үлдэгдлээр) байгаа бол банкны нийт Гадаад худалдааны санхүүжилтийн эргэлт 2.03 их наяд төгрөг (олголтоор) буюу энэ

хэмжээний бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж болон төслүүдийг худалдааны санхүүжилтийн үйлчилгээгээр дэмжин ажиллалаа. Үүнээс 137.44 тэрбум төгрөгийн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, 136 тэрбум төгрөгийн уул уурхай, автомашин, сэлбэг хэрэгслийг худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүнээр санхүүжүүлээ.

Зах зээлд эзлэх тэргүүлэх байр суурь



Олон улсын SWIFT байгууллагаас гаргасан тоон мэдээгээр Голомт банк нь 2025 онд гадаад баталгаа, аккредитив нээх үйлчилгээгээр зах зээлд тэргүүлэх байр сууриа хадгалж 60.6%-ийг эзэлж байна.

Олон улсын худалдааны санхүүжилтийн хөтөлбөр



Олон улсын санхүүгийн корпораци болон Азийн хөгжлийн банкны “Гадаад худалдааны санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хамтын ажиллагааны хүрээнд нийт 83.4 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн импортыг санхүүжүүлэв.



Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Азийн хөгжлийн банкнаас 2025 онд “Худалдаа, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлсэн бүс нутгийн тэргүүлэх банк, санхүүгийн байгууллагуудыг шалгаруулж, Голомт банканд нэр хүнд бүхий “Монгол Улс дахь Шилдэг түнш банк” шагналыг хүртээлээ.



Монгол Улсын экспорт болон дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг худалдааны санхүүжилтээр дэмжин ажиллав

Тайлант хугацаанд Голомт банк экспортын бүтээгдэхүүний олборлолтыг дэмжихэд зориулж, нийт 88.6 тэрбум төгрөгийн уул уурхайн машин техник, тоног төхөөрөмжийн импортын

аккредитив нээв. Түүнчлэн БНХАУ-ын Bank of China, Agricultural Bank of China, ICBC, China Construction Bank, China CITIC Bank, China Minsheng Bank болон БНСУ-ын KEB Hana Bank банкнуудтай

хамтран Монгол Улсад зарлагдсан дэд бүтцийг сайжруулах төсөл, хөтөлбөрүүд рүү чиглэсэн 144.4 тэрбум төгрөгийн баталгаануудыг нээж, дэмжин ажиллалаа.



Голомт банк Монгол Улсын 2025 оны “Усны элч” байгууллагын хувьд Улаанбаатар хотын усны хангамжийг нэмэгдүүлэх, усны

салбарын тогтвортой байдлыг хангах зорилготой Монголын Мянганы сорилтын сангийн “Усны компакт” төслийн хүрээнд “Ус

гүн цэвэршүүлэх үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтын гүйцэтгэлд зориулж, БНТУ-ын Ziraat bank-тай хамтран баталгаануудыг нээлээ.

Хөрөнгийн удирдлага

Актив, пассивын удирдлага

Голомт банк 2025 онд Актив, пассивын удирдлагын хүрээнд Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж, эрсдэлийг зохистой түвшинд удирдаж ажиллалаа. Активын ашиглалтыг сайжруулж, эх үүсвэрийн бүтцийг төрөлжүүлэх замаар ашигт ажиллагааг зохистой түвшинд ханган ажиллаж байна.

Зохистой харьцаа

Тайлант хугацаанд Голомт банк актив, пассивын эргэн төлөлтийн хугацааны зөрүүг харилцагчдын зан төлөв дээр суурилан тооцох аргачлалаа ашиглаж, хүүгийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ тогтмол удирдан ажиллав.

Банк хөрвөх чадвараа өндөр түвшинд хадгалж, төлбөр

түргэн гүйцэтгэх чадварын харьцааг тогтмол 30%-аас дээш хангаж ажиллахын хажуугаар Базелын хорооны хөрвөх чадварын харьцааны үзүүлэлтүүд болох LCR (30 хоногийн хөрвөх чадвар), NSFR (1 жилийн тогтвортой эх үүсвэр)-ийн үзүүлэлтүүдийг тооцож, тогтмол 100%-аас дээш хангаж ажиллаад байна.

Түүнчлэн банк өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг зохистой түвшинд барьж, өөрийн хөрөнгийн хүрэлцээгээ хангаж ажиллалаа.

Ашигт ажиллагаа

Голомт банк 2025 онд сул активын ашиглалтыг сайжруулахад анхаарч, бондын зах зээлд оролцон Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжиж ажиллахаас гадна зээлийн багцаа нэмэгдүүлж, төрөлжүүлэх чиглэлд төвлөрөн ажиллав.

Хувь хүний хөрөнгийн удирдлагын үйлчилгээ

Голомт банк 2023 оноос хойш Монгол Улсад Хувь хүний хөрөнгийн удирдлагын үйлчилгээг (Private Wealth Management) харилцагчдадаа хүргэн ажиллаж байна. Бид

банкны Хөрөнгө оруулалтын хадгаламжийн бүтээгдэхүүнээр дамжуулан харилцагчдын хөрөнгө оруулалтын зорилго, эрсдэл даах чадварын хүрээнд оновчтой хөрөнгө оруулалтын багц бүрдүүлж, санхүүгийн цогц үйлчилгээг хүргэн ажилладаг.

Ийнхүү 2025 онд удирдаж буй хөрөнгийн хэмжээгээр Монгол Улсын зах зээлд тэргүүлэх түвшинд хүрсэн бөгөөд цаашид бид дижитал, хурдан шуурхай үйлчилгээг харилцагчдадаа хүргэх зорилт тавин ажиллаж байна.

Харилцагчийн үйлчилгээ

Харилцагч төвтэй бодлого

Голомт банкны Харилцагч төвтэй бодлогыг шинэчилж, банкны үйлчилгээний сувгуудаар дамжуулан чанартай үйлчилгээг хариуцлагатай, мэргэшсэн ажилтнаар харилцагчид цаг алдалгүй үзүүлж харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгыг тодорхойлов.

ISO 9001:2015; 23592:2021 стандарт

Банкны Contact center болон Гомдол шийдвэрлэх үйл ажиллагаанд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 23592:2021 Үйлчилгээний төгөлдөршил олон улсын стандартыг Монсерфт ХХК болон БНФУ-ын Афнор группээр дахин магадлах аудитыг хийлгэж, ISO гэрчилгээг амжилттай баталгаажууллаа.

AI BOT нэвтрүүлэлт

- Contact center-ийн үйл ажиллагаанд AI BOT-ыг нэвтрүүлж, хиймэл оюун ухааныг ашиглан хүнтэй төстэйгөөр харилцагчийн асуултыг ойлгон дэлгэрэнгүй хариулт өгөх чадвартайгаар тасралтгүй хөгжүүлж байна. Тус AI BOT нь нэг дор 5 харилцагчид зэрэг хариулт өгөх хүчин чадалтайгаас гадна манай онлайн хандалтын ачааллын 67%-г виртуал агентаар шийдвэрлэж байна.
- 2025 онд авто voice харилцагч руу илгээх робот хөгжүүлэлтийн шийдлийг нэвтрүүлснээр хүн цагийг хэмнэсэн бөгөөд нийт 607,686 харилцагчид цаг үеийн болон бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээллийг амжилттай хүргэлээ.

Харилцагчийн эрх ашгийг хамгаалах

Харилцагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд Харилцагч төвтэй банкны бодлого, Банкны үйлчилгээний кодексыг дагаж, мөрдөх чиглэлд Голомт банкны нийт ажилтанд таниулах, мэдлэг олгох зэрэг нөлөөллийн ажлуудыг үе шаттай хэрэгжүүлж, ажилтнуудын мэдлэг, ойлголтыг тогтмол хугацаанд бататгав.

Зайны үйлчилгээний цар хүрээ

- 2025 онд Contact center-ийн дуудлагын системийг бүрэн шинэчилж, Чимэгэ системийг дэмжих, дата баазыг нэмэгдүүлж, ажилтны гар ажиллагааг багасгах шийдлүүдийг нэвтрүүлэн бүтээмжийг нэмлээ. Нийт 1,954,000 хандалтыг 98%-ийн амжилттай хүлээн авснаар харилцагчдадаа зөвлөгөө, мэдээлэл өгч, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэн хүртээмжтэй ажиллалаа.
- 2025 онд онлайн үйлчилгээний хэсэгт 3 томоохон суваг болох Wechat, Whatsapp, Kakao talk дижитал сувгийг нэмж, харилцагч дэлхийн хаанаас ч банкны бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээлэл зөвлөгөөг авах боломжийг тэлэв.
- ПОС төхөөрөмж ашиглагдаж харилцагч нарт зориулан тусгай дуудлагын шугамыг нэвтрүүлж, харилцагчид үйлчилгээ үзүүлж байна.
- Харилцагчийг зайнаас халамжилж, хэрэгцээт бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулах процессыг тодорхойлж, 2,000 гаруй харилцагчид амжилттай борлууллаа. Харилцагчийн төрөлд нийцүүлэн мэдээлэл,

үйлчилгээ хүргэж, борлуулалтын үр ашгийг өсгөх замаар үнэнч харилцагчийг бий болгож, тэдгээрийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх тасралтгүй үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Үйлчилгээний чанар

- Гомдол шийдвэрлэх үйл явцыг сайжруулж, харилцагчид үүссэн асуудлыг анхны хандалтаар түргэн шуурхай шийдвэрлэн чанарыг хангуулж байна.
- Харилцагчийн гомдолд анализ хийж, алдаа асуудал үүсэхээс сэргийлэх үе шаттай ажлуудыг амжилттай хэрэгжүүлж, гомдол шийдвэрлэх, алдаа дахин гаргахгүй байх чанарын метрикс үзүүлэлт 98%-ийн гүйцэтгэл хангаж, харилцагчийн гомдлын тоон үзүүлэлт 35%-аар буурав.
- Харилцагчийн цаг хугацааг хэмнэх дижитал шийдлийг тодорхойлж, 2025 оны 5-р сараас эхлэн салбарт үйлчилгээ авах дугаарыг онлайн-аар захиалах боломжийг нэвтрүүлснээр цаасны хэрэглээг буурууллаа.
- 2025 онд Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний замнал, бүтээгдэхүүний чанарын үндсэн 8 метрикс үзүүлэлтийн дундаж үнэлгээ 98.8%, салбар, тооцооны төвийн нийт ажилтны мэдлэг, харилцагчийн үйлчилгээний стандарт 98.4%, нийт салбар, тооцооны төвийн тохижилтын стандартыг 99.5%-тай хангаж ажиллалаа.
- Харилцагч төвтэй банкны бодлогын хүрээнд нийт ажилтан руу чиглэсэн мэргэшүүлэх, хөгжүүлэх 3978 хүн/цагийн сургалт зохион байгуулж, ажилтнуудын мэргэжлийн байдлыг нэмэгдүүлэн ажиллаж байна.


Санхүүгийн үзүүлэлт болон бусад тайлан

Голомт банкны санхүүгийн үр дүн


Голомт банкны нийт актив өмнөх оны эцэстэй харьцуулахад 23 хувиар өсөж, 19.2 их наяд төгрөгт хүрсэн бол харилцагчийн эх үүсвэр 1.4 их наяд төгрөгөөр буюу 15 хувиар нэмэгдэн 10.8 их наяд төгрөгт хүрээд байна. Харилцагчийн эх үүсвэрийн өсөлтөд иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж тэнцвэртэй хувь нэмэр оруулсан нь сегментүүдийн тогтвортой

байдал хадгалагдаж, төвлөрөл багатай, эрсдэл даах чадвартай санхүүжилтийн бүтэц бүрдсэнийг илтгэж байна. Эдгээр бодлого, стратегийн хэрэгжилтийн үр дүнд банк 2025 оны эцэст харилцагчийн эх үүсвэрийн зах зээлийн 20.6 хувийг эзэлж, салбар дахь тогтвортой өсөлт бүхий байр сууриа улам бататгав.

Нийт хөрөнгө




Харилцах, хадгаламж



Голомт банк нь олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа тасралтгүй өргөжүүлж, тогтвортой хөгжилд чиглэсэн бодлого, үйл ажиллагаагаа тууштай хэрэгжүүлсний үр дүнд олон улсын хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсээр байна. Энэхүү итгэл нь банкны санхүүгийн тогтвортой байдал, зах зээл дэх нэр хүндийг бататгахын зэрэгцээ урт хугацааны өсөлт, хөгжлийг дэмжих чухал хүчин зүйл болж байна. Тус хүрээнд дараах томоохон санхүүжилтийн эх үүсвэрүүдийг амжилттай татан төвлөрүүллээ.

Бусад эх үүсвэр




• 1-р сард Голомт банк олон улсын зах зээлд 5 жилийн хугацаатай, 50 сая ам.долларын ногоон болон нийгмийн чиглэлийн бондыг жилийн 8 хувийн хүүтэйгээр амжилттай гаргасан. Энэхүү бонд нь Монгол Улсын корпорейт бондуудаас олон улсын зах зээлд гарсан хамгийн хямд хүүтэй мөн сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй төслүүдийг санхүүжүүлэх бонд гэдгээрээ онцлог юм.

• 11-р сард Голомт банк Япон Улсын зах зээлд 3 жилийн хугацаатай, 15 тэрбум иений Самурай бондыг амжилттай гаргаж, олон улсын хөрөнгө оруулагчдын итгэлийг дахин баталгаажууллаа.


• Үүнээс гадна олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас 170 сая ам.долларын нэмэлт санхүүжилт татан төвлөрүүлснээр банкны санхүүжилтийн суурь улам бэхжиж, харилцагчдад хүрэх боломж, үйлчилгээний цар хүрээ өргөжив.

Өөрийн хөрөнгө



Банкны ашигт ажиллагааны үр дүнд 2025 онд өөрийн хөрөнгө 17.8 хувиар өсөж, 1.7 их наяд төгрөгт хүрлээ. Түүнчлэн 2024 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаанд 100 төгрөг, нийт 80.8 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр ногдол ашиг болгон тараасан.

Цэвэр зээл




Цэвэр зээлийн хэмжээ 11.1 хувиар өсөж, 8.2 их наяд төгрөгт хүрэв. Банк нь активын чанарын удирдлага болон зээлийн эрсдэлийн менежментийг хэрэгжүүлж, зээлийн чанарыг зохистой түвшинд хадгалах бодлогыг баримталсан. Үүний зэрэгцээ эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болох бизнесийн зээлийн санхүүжилтийг, ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгчдэд чиглэсэн зээлийн бодлогыг эрчимжүүлж, санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн сацуу зээлийн бүтцийг жигд, тэнцвэртэй хадгалан ажиллав.

Эдгээр арга хэмжээний үр дүнд активын чанар сайжирч, чанаргүй зээлийн харьцаа 2.5 хувь болж буурсан бөгөөд банк 2025 оны эцэст системийн зээлийн багцын 18.8 хувийг эзэлж байна.

Дотоод	395,194,964	-	-	-	395,194,964
Бусад банкуудад анх 3 сараас их хугацаагаар байршуулсан хөрөнгө	386,124,292	-	-	-	386,124,292
Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа	6,903,403,768	447,977,393	-	-	7,351,381,161
Бизнесийн зээл	2,355,176,485	-	-	-	2,355,176,485
Жижиг дунд бизнесийн зээл	1,696,965,260	-	-	-	1,696,965,260
Хувь хүнд олгосон орон сууцны зээл	1,917,684,687	-	-	-	1,917,684,687
Хувь хүнд олгосон орон сууцны зээл	933,577,336	-	-	-	933,577,336
Ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөх бизнесийн зээл	-	3,143,234	-	-	3,143,234
Ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөх жижиг дунд бизнесийн зээл	-	5,461,570	-	-	5,461,570
Буцаах нөхцөлтэй МИК-д худалдсан орон сууцны зээл	-	439,372,589	-	-	439,372,589
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр-хөрөнгө	14,931,399	235,679,985	-	-	235,679,985
Бусад санхүүгийн хөрөнгө	-	13,154,667	-	-	28,086,066
Үнэт металл	-	13,154,667	-	-	13,154,667
Компаниудаас авах авлага	9,347,187	-	-	-	9,347,187
Хувь хүмүүсээс авах авлага	3,016,631	-	-	-	3,016,631
Бэлэн мөнгө гүйлгээний авлага	5,734,890	-	-	-	5,734,890
Бусад санхүүгийн хөрөнгө	2,739,041	-	-	-	2,739,041
Хасах: Үнэ цэнийн бууралтын сан	(5,906,350)	-	-	-	(5,906,350)
Нийт санхүүгийн хөрөнгө	11,157,043,026	1,387,866,669	2,281,166,365	1,143,186	14,827,219,246

2025 оны 12 дугаар сарын 31 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үүсмэл санхүүгийн өртөг төлбөрөөс бусад Банкны санхүүгийн өртөг төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэсэн. Үүсмэл санхүүгийн өртөг төлбөрийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэсэн.

Голомт Банк ХК

Санхүүгийн тайлангуудын тодруулга – 2025 оны 12 дугаар сарын 31

44 Холбоотой талуудын ажил гүйлгээ

Эдгээр санхүүгийн тайлангийн зорилгоор талууд нь НББОУС 24 буюу “Холбоотой Талын Тодруулга”-д тодорхойлсноор хэрвээ тухайн этгээд нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтанд нөлөө үзүүлэх буюу хяналт тавих чадвартай бол холбоотой талууд гэж тодорхойлно. Холбоотой талуудын магадлалт хамаарлыг авч үзэхдээ хуулийн хэлбэрээс илүү эдийн засгийн холбоо хамаарлыг авч үздэг.

Бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад Банк нь хувь нийлүүлэгчид, захирлууд болон бусад холбоотой талуудтай ажил гүйлгээ хийдэг. Эдгээр ажил гүйлгээнүүдэд төлбөр тооцоо, зээл олгох, хадгаламж татан төвлөрүүлэх, баталгаа гаргах, арилжаа, гадаад валютын гүйлгээ зэрэг багтана. Банкны бодлогын дагуу холбоотой талуудын ажил гүйлгээнүүд гэдэгт тухайн ажил гүйлгээнд зонхилон гарч ирдэг ижил нөхцөлөөр хийгдсэн холбоотой талуудын ажил гүйлгээг хамруулна.

Холбоотой талуудыг доорх байдлаар ангилна:

Толгой компани	Голомт Файнэншил Групп ХХК нь Голомт банкны гол хувьцаа эзэмшигч компани юм. Тодруулга 1-ээс харна уу.
Нийтлэг эрх бүхий байгууллага	Нийтлэг эрх бүхий байгууллагууд гэдэг нь Голомт Файнэншил Групп ХХК-ийн дотор байдаг компаниуд болон бусад компаниуд бөгөөд эцсийн шатны эзэмшигч нь хяналт тавьдаг эсвэл мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг аж ахуйн нэгжүүд юм.
Захирлууд болон эрх бүхий албан тушаалтнууд	ТУЗ болон Банкны гүйцэтгэх удирдлагын баг.

2025 оны 12 дугаар сарын 31 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны шууд болон эцсийн шатны толгой компани болон шууд хянадаг, эцсийн шатны эзэмшигчийн талаар Тодруулга 1-ээс харна уу.

Голомт Банк ХК
Санхүүгийн тайлангуудын тодруулга – 2025 оны 12 дугаар сарын 31

44 Холбоотой талуудын ажил гүйлгээ (үргэлжлэл)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны холбоотой талуудтай хийсэн гүйлгээний үлдэгдэл дүн дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Захирлууд болон эрх бүхий албан тушаалтнууд	Толгой компани	Нийтлэг эрх бүхий байгууллага	Бусад	Нийт дүн
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт цэвэр дүн (үр ашигт хүүгийн хувь 6% - 24%)	8,804,515	-	94,036,935	213,820	103,055,270
Бусад хөрөнгө	-	-	61,600	-	61,600
Харилцагчийн харилцах, хадгаламж (гэрээний хүүгийн хувь 0% - 16.5%)	50,560,073	9,192,932	95,045,169	285,992	155,084,166

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны холбоотой талуудтай хийсэн гүйлгээний үлдэгдэл дүн дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	Захирлууд болон эрх бүхий албан тушаалтнууд	Толгой компани	Нийтлэг эрх бүхий байгууллага	Бусад	Нийт дүн
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны нийт цэвэр дүн (үр ашигт хүүгийн хувь 6% - 24%)	8,427,530	-	237,319,765	16,405,023	262,152,318
Бусад хөрөнгө	-	-	645,010	-	645,010
Харилцагчийн харилцах, хадгаламж (гэрээний хүүгийн хувь 0% - 15.6%)	49,939,267	11,880,052	199,802,852	9,038,925	270,661,096

Голомт Банк ХК
Санхүүгийн тайлангуудын тодруулга – 2025 оны 12 дугаар сарын 31

44 Холбоотой талуудын ажил гүйлгээ (үргэлжлэл)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх холбоотой талуудад олгосон зээл ба урьдчилгаа дансны өөрчлөлт, хөдөлгөөнийг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Захирлууд болон эрх бүхий албан тушаалтнууд	Толгой компани	Нийтлэг эрх бүхий байгууллага	Бусад	Нийт дүн
Гэрээний хүүгийн хувь	6% - 24%	24%	9% - 24%	15% - 24%	
Харилцагчдад олгосон зээл	8,427,530	-	237,319,765	16,405,023	262,152,318
2025 оны 01 сарын 01-нээрх харилцагчдад олгосон зээл	322,977,924	246,064	45,344,930	1,287,667	369,856,585
Тайлант хугацаанд харилцагчдад олгосон зээл	(322,669,014)	(246,097)	(189,112,863)	(17,484,884)	(529,512,858)
Тайлант хугацаанд төлөгдсөн зээл	59,749	-	478,683	-	538,432
2025 оны 12 сарын 31-нээрх хуримтлагдсан хүү	(6,859)	(11)	(1,582,729)	(1,386)	(1,590,985)
Хасах нь: Зээлийн алдагдлын сан	15,185	44	1,589,150	7,399	1,611,778
Ханшийн зөрүү					
2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх харилцагчдад олгосон зээл	8,804,515	-	94,036,936	213,819	103,055,270

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх холбоотой талуудад олгосон зээл ба урьдчилгаа дансны өөрчлөлт, хөдөлгөөнийг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Захирлууд болон эрх бүхий албан тушаалтнууд	Толгой компани	Нийтлэг эрх бүхий байгууллага	Бусад	Нийт дүн
Гэрээний хүүгийн хувь	6% - 24%	24%	9% - 24%	15% - 24%	
Харилцагчдад олгосон зээл	3,863,988	-	76,509,102	36,962,089	117,335,179
2024 оны 01 сарын 01-нээрх харилцагчдад олгосон зээл	190,963,436	111,251	246,956,138	15,422,117	453,452,942
Тайлант хугацаанд харилцагчдад олгосон зээл	(186,456,335)	(111,265)	(92,983,197)	(37,338,009)	(316,888,806)
Тайлант хугацаанд төлөгдсөн зээл	60,968	-	7,738,301	1,374,246	9,173,515
2024 оны 12 сарын 31-нээрх хуримтлагдсан хүү	(4,305)	-	(1,027,752)	(15,802)	(1,047,859)
Хасах нь: Зээлийн алдагдлын сан	(222)	14	127,173	382	127,347
Ханшийн зөрүү					
2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх харилцагчдад олгосон зээл	8,427,530	-	237,319,765	16,405,023	262,152,318

Эрх бүхий албан тушаалтнуудад олгосон зээлийг банкны ажилчдад олгосон зээлтэй адил хөнгөлөлттэй хүүгээр олгодог (Тодруулга 12-оос үзнэ үү). Эрх бүхий албан тушаалтнуудад санал болгож буй нөхцөл нь бусад ажилчдад санал болгож буй нөхцөлөөс тийм ч их ялгаатай биш.

Голомт Банк ХК
Санхүүгийн тайлангуудын тодруулга – 2025 оны 12 дугаар сарын 31

44 Холбоотой талуудын ажил гүйлгээ (үргэлжлэл)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар холбоотой талуудын харилцах, хадгаламжийн үлдэгдэл болон тайлант хугацаанд хийгдсэн гүйлгээг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Захирлууд болон эрх бүхий албан тушаалтнууд	Толгой компани	Нийтлэг эрх бүхий байгууллага	Бусад	Нийт дүн
	Гэрээний хүүгийн хувь				
	Харилцагчдын харилцах, хадгаламж				
	2025 оны 01 сарын 01-нээрх харилцагчдын харилцах, хадгаламж	49,939,267	11,880,052	199,802,852	270,661,096
	Тайлант жилд хүлээн авсан	2,974,936,160	234,815,597	1,864,930,145	5,143,324,511
	Тайлант жил буцаан төлсөн	(2,884,880,871)	(237,785,868)	(2,026,741,772)	(5,226,810,416)
	2025 оны 12 сарын 31-нээрх хуримтлагдсан хүү	581,951	5,793	1,511,767	2,099,511
	Ханшийн зөрүү	(90,016,434)	277,360	55,542,177	(34,190,534)
	2025 оны 12 сарын 31-нээрх харилцагчдын харилцах, хадгаламж	50,560,073	9,192,934	95,045,169	155,084,168

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар холбоотой талуудын харилцах, хадгаламжийн үлдэгдэл болон тайлант хугацаанд хийгдсэн гүйлгээг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Захирлууд болон эрх бүхий албан тушаалтнууд	Толгой компани	Нийтлэг эрх бүхий байгууллага	Бусад	Нийт дүн
	Гэрээний хүүгийн хувь				
	Харилцагчдын харилцах, хадгаламж				
	2024 оны 01 сарын 01-нээрх харилцагчдын харилцах, хадгаламж	4,824,272	3,424,427	127,570,942	137,646,112
	Тайлант жилд хүлээн авсан	2,803,561,404	146,609,859	2,569,218,009	89,300,131
	Тайлант жил буцаан төлсөн	(2,758,881,051)	(138,319,455)	(2,508,746,689)	(5,608,689,403)
	2024 оны 12 сарын 31-нээрх хуримтлагдсан хүү	296,134	5,331	11,850,313	12,737,029
	Ханшийн зөрүү	138,508	159,890	(89,723)	199,342
	2024 оны 12 сарын 31-нээрх харилцагчдын харилцах, хадгаламж	49,939,267	11,880,052	199,802,852	270,661,096

Голомт Банк ХК

Санхүүгийн тайлангуудын тодруулга – 2025 оны 12 дугаар сарын 31

44 Холбоотой талуудын ажил гүйлгээ (үргэлжлэл)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны холбоотой талуудтай хийсэн орлого болон зардлыг дор харуулав:

Мянган төгрөгөөр	Захирлууд болон эрх бүхий албан тушаалтнууд	Толгой компани	Нийтлэг эрх бүхий байгууллага	Бусад	Нийт дүн	
	Хүүгийн орлого	1,210,232	-	15,076,475	757,918	17,044,625
	Хүүгийн зардал	3,642,154	165,672	7,915,334	570	11,723,730
	Хураамж, шимтгэлийн орлого	40,160	13,849	138,497	3,482	195,988
	Түрээсийн орлого	-	-	858,151	-	858,151
	Төлсөн ногдол ашиг	417,725	62,424,053	4,846,150	-	67,687,928
	Бусад үйл ажиллагааны зардал	-	-	2,540,327	-	2,540,327

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны холбоотой талуудтай хийсэн орлого болон зардлыг дор харуулав:

Мянган төгрөгөөр	Захирлууд болон эрх бүхий албан тушаалтнууд	Толгой компани	Нийтлэг эрх бүхий байгууллага	Бусад	Нийт дүн	
	Хүүгийн орлого	1,019,848	-	12,706,775	4,867,045	18,593,668
	Хүүгийн зардал	1,431,680	142,662	12,420,083	998,485	14,992,910
	Хураамж, шимтгэлийн орлого	245,695	2,676	51,037	1,670	301,078
	Түрээсийн орлого	-	-	550,638	-	550,638
	Төлсөн ногдол ашиг	377,755	56,181,647	4,361,535	24,181	60,945,118
	Бусад үйл ажиллагааны зардал	-	-	1,855,131	-	1,855,131

2025 оны 12 дугаар сарын 31 болон 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкны холбогдоотой талуудад гаргасан баталгаа, аккредитивын үлдэгдэл дүнг дор харуулав.

Мянган төгрөгөөр	2025 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Баталгаа		
Баталгаа	1,399,035	3,029,763
Гаргасан экспортын аккредитив	-	35,912,625
Олгосон зээлийн шугамын ашиглаагүй үлдэгдэл	9,660,709	7,921,763
Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг	11,059,744	46,864,151
Хасах нь: зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүргийн үнэ цэнийн бууралтын сан	(11,655)	(6,264)
Цэвэр зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг	11,048,089	46,857,887

Банкны ТУЗ болон эрх бүхий албан тушаалтнуудын цалин хөлс болон урамшууллын талаарх мэдээллийг дор толилуулав:

Мянган төгрөгөөр	2025 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
Цалин хөлс	8,598,125	5,912,179
Урамшуулал	7,831,000	2,473,000
Нийгмийн даатгалын шимтгэл	2,001,509	1,014,974
Нийт дүн	18,430,634	9,400,153

Голомт Банк ХК**Санхүүгийн тайлангуудын тодруулга – 2025 оны 12 дугаар сарын 31****44 Холбоотой талуудын ажил гүйлгээ (үргэлжлэл)**

Захирлууд болон эрх бүхий албан тушаалтнуудад ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд багтана. Бусад холбоотой талуудад Банк болон Банкны гол хувьцаа эзэмшигчдийн хяналтанд байдаг компаниуд багтана.

45 Тайлант хугацааны дараах үйл явдлууд

Ногдол ашиг зарласан. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасны дагуу, 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит бус хурлаар хувьцаа эзэмшигчдэд хуримтлагдсан ашгаас 64,692,584 мянган төгрөг (нэгж хувьцаанд 80 төгрөг) олгохоор шийдвэрлэсэн.

Дараа үеийн үйл явдал. Хэдийгээр инфляц 2025 оны эцэст төв банкны зорилтот интервалд хүрч буурсан ч инфляцыг өсгөх эрсдэлт хүчин зүйлс давамгайлсан хэвээр байгааг Монголбанкнаас онцолж байна. Улмаар 2025 оны 12 дугаар сарын ээлжит хурлаар бодлогын хүүг 12%-д хэвээр хадгалах шийдвэр гаргасан бол 2026 оны 01 дүгээр сард болсон ээлжит бус хурлаар банкны системийн зээлийн өсөлтийг зохистой түвшинд хадгалах зорилгоор өр орлогын харьцааны дээд хязгаарыг 45% болгох, банкнуудын төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг тус бүр 1 нэгж хувиар нэмэгдүүлж, харгалзан 14 хувь болон 19 хувьд хүргэх шийдвэрүүдийг гаргаад байна.

46 Монгол орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг мөн Англи хэл дээр бэлтгэсэн болно. Англи болон Монгол хувилбаруудын хооронд утга, агуулгын зөрүү гарсан тохиолдолд Англи хувилбарыг баримтална.

Голомт Банк ХК**Санхүүгийн тайлангуудын тодруулга – 2025 оны 12 дугаар сарын 31****47 Товчлол**

Эдгээр санхүүгийн тайлангуудад ашиглагдсан товчилсон үгийн жагсаалтыг дор толилуулав:

Товчлол	Бүтэн нэр
ХӨ	Хорогдуулсан өртөг
АХБ	Азийн Хөгжлийн Банк
МБ	Монголбанк
ССФ	Зээл рүү хөрвөх магадлалын коэффициент
EAD	Дефолт болох үеийн үлдэгдэл
ХБЗА	Хүлээгдэж буй зээлийн алдагдал
EIR	Үр ашигт хүүгийн арга
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
БДОБҮЦ	Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ
ААБҮЦ	Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
JICA	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
LGD	Дефолт болох алдагдал
МИК	Монголын ипотекийн корпораци
БДО	Бусад дэлгэрэнгүй орлого
PD	Дефолтын магадлал
SICR	Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗХҮТ	Зөвхөн хүү болон үндсэн төлөлт
VaR	Хамгийн их эрсдэл


Эдийн засгийн тойм

Дэлхийн эдийн засгийн тойм

2025 оны геополитикийн хурцадмал байдал нь санхүүгийн зах зээл, нийлүүлэлтийн сүлжээ, түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлж, дэлхийн эдийн засагт тодорхойгүй байдлыг үүсгэв. Хөгжсөн орнууд эдийн засгаа дэмжихийн тулд мөнгөний зөөлөн бодлого явуулж байсан бол хөгжиж буй, түүхий эдээс хамаарал

өндөртэй улсуудын хувьд худалдааны өөрчлөлттэй холбоотой эрсдэлээс сэргийлж, мөнгөний хатуу бодлого явуулсан жил боллоо. Ийнхүү хөгжсөн улс орнуудын хувьд 2025 оны инфляц дунджаар 2.5 хувьд байгаа бол хөгжиж буй улс орнуудынх 5.2 хувьд буюу арай өндөр түвшинд байх хүлээлттэй байна.


Инфляцын өсөлт ба ирээдүйн хүлээлт, хувиар



Харин ирэх онуудын инфляцын хүлээлтийн тухайд 2025 оны хүлээгдэж байсан 4.1%-ийн өсөлтөөс 2026 онд 3.8%, 2027 онд 3.4% болж тогтвортой буурах төлөвтэй байна. Хөгжсөн эдийн засагтай улсуудын хувьд инфляц илүү хурдан саарч, 2026–2027 онуудад Төв банкнуудын зорилтот түвшинд ойртох төлөвтэй байна. Харин хөгжиж буй орнуудын инфляц харьцангуй

өндөр хэвээр байх боловч мөн адил аажмаар буурна. Олон улсын хэмжээнд инфляц буурч буй гол шалтгаан нь дотоод эрэлт хэрэглээ суларч, хөдөлмөрийн зах зээл саарч байгаатай холбоотой. Мөн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан түүхий эдийн үнэ хэлбэлзэж, хүмүүсийн худалдан авах чадвар ерөнхий түвшиндээ буурч буйтай холбоотой байна.

Эдийн засгийн өсөлт ба ирээдүйн хүлээлт, хувиар



Инфляцын түвшин буурахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтийн хувь хэмжээ мөн адил 2026 онд 3.3%, 2027 онд 3.2% болж бага зэрэг буурах төлөвтэй байна. Гэсэн хэдий ч ойрын жилүүдэд худалдааны бодлогын өөрчлөлтийн сөрөг нөлөөг үр харгалзан технологийн чиглэлийн хөрөнгө оруулалтууд өсөн нэмэгдэх, мөн цаашлаад технологиор дамжин бүтээмж нэмэгдэж байгаа нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлнэ гэдгийг ОУВС-ийн "Дэлхийн эдийн засгийн төлөв байдал"-ын 1-р сарын тайланд дурджээ.

АНУ-ын эдийн засаг

2025 онд АНУ-ын эдийн засаг өмнөх жилүүдтэй харьцуулахад удааширсан төлөвтэй байгаа ба Холбооны Нөөцийн Сангийн төсөөллөөр эдийн засгийн өсөлт 1.6–1.8 % орчим, харин ОУВС-ийн төсөөллөөр 2.4 хувь байна гэж үзжээ. Харин инфляцын түвшин тарифтай холбоотой импортын зардал өссөний үр дүнд жилийн эцэст 2.7 хувьтай гарсан ба энэ нь Төв банкны зорилтот түвшнээс өндөрт хадгалагдаж байна. Гэвч тарифтай холбоотой эрсдэл олон талын хэлэлцээрийн үр дүнд хүлээгдэж байснаас бага байгаа тул 2025 онд 12-р сард 25 суурь

нэгжээр бууруулж, 3.5-3.75 хувьд хүргэсэн ба 2026 онд ч мөн адил бодлого боловсруулагчид бодлогын хүүг бууруулж эдийн засгаа дэмжих гол төлөвтэй байна.

БНХАУ-ын эдийн засаг

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2025 онд 5.0%-д хүрч засгийн газрын зорилтот түвшинд хүрлээ. 2025 оны эцэвэр экспорт ДНБ-ий өсөлтийн 33 орчим хувийг бүрдүүлсэн нь 1997 оноос хойших хамгийн өндөр түвшин болсон ба БНХАУ эдийн засгийн өсөлтөө экспортоор дэмжиж байгааг илтгэж байна. 2026 онд идэвхтэй төсвийн тэлэх бодлого болон зохистой уян хатан мөнгөний бодлого баримтлахаа баталсан ба БНХАУ-ын Ардын банк 2025 онд банкнуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээ болон хүүг бууруулах төлөвтэй байна. Мөн АНУ-тай 11-р сард хийсэн 1 жилийн худалдааны тохиролцооны үр дүнд Хятадын бараанд ногдох АНУ-ын бодит тарифын түвшин буурснаар худалдааны эрсдэл 2026 оны хувьд буурах хандлагатай байна. Ийнхүү эдгээр эрсдэл болон боломжийг харгалзан үзэж, ОУВС-ийн таамаглалаар БНХАУ-ын эдийн засаг 2026 онд 4.5 хувиар өснө гэсэн хүлээлттэй байна.


Монголын эдийн засгийн тойм

Гадаад худалдаа

Монгол Улсын хувьд 2024 онтой харьцуулахад 2025 онд эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй тогтворгүй байв. Эхний хагас жилд Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналтаас эхлэлтэй дотоод хэрэглээний зогсонги байдал болон АНУ-ын тарифын бодлогоос шалтгаалсан гадаад худалдааны эрсдэл БНХАУ-ын

эдийн засгийн төлөвийг муутгаж, БНХАУ-ын Засгийн газраас нүүрсний гол эрэлтийг бүрдүүлэгч гангийн үйлдвэрлэлийг бууруулах шийдвэр гаргасан. Мөн БНХАУ-ын дотоодын нүүрсний уурхайнуудын олборлолт өндөр байсан нь импортын эрэлтийг бууруулж, олон улсын зах зээлд коксжих нүүрсний үнэ огцом унасан юм.


Чулуун нүүрсний биет хэмжээ болон хилийн дундаж үнэ



Улмаар 2025 оны эхний хагас жилд Монгол Улсаас БНХАУ руу экспортолх чулуун нүүрсний биет хэмжээ болон үнийн түвшин өмнө оны мөн үетэй харьцуулахад хоёул бууралттай байсан ч 7-р сараас эхлэн Хятадын дотоод дефляцитай тэмцэх хүрээнд явуулсан нүүрсний хэт үйлдвэрлэлийг бууруулах (Anti-Involution) бодлогын үр дүнд сүүлийн хагаст нүүрсний экспортын орлого


тогтворжиж, гадаад худалдааны алдагдал буурлаа. 2025 онд чулуун нүүрсний экспортын биет хэмжээ 83.9 сая тоннд (2024 онтой харьцуулахад 6.0%-ийн өсөлт) хүрсэн бол жилийн дундаж хилийн үнэ тонн тутамд 66.3 ам.доллар болж, 2024 оноос 38.3%-аар буурчээ. (2024 онд жилийн дунджаар чулуун нүүрсний үнэ 107.4 ам.доллар/тонн байв)

Экспорт, импортын жилийн өсөлт




Голлох экспорт, импортын бүтээгдэхүүний орлого, зардал - 2025 оны эцэст

Экспортын голлох бүтээгдэхүүний орлого, жилийн өсөлт



Импортын голлох бүтээгдэхүүний зардал, жилийн өсөлт



2025 оны хувьд нүүрсний экспортын орлого (12-р сарын эцсийн байдлаар 5.6 тэрбум ам.долларт хүрч өмнө оны мөн үеэс 34.8%-аар буурсан) өндөр бууралттай байсан ч Оюу Толгойн далд уурхайн үйл ажиллагаагаар эрчимжиж, зэсийн баяжмалын орлого огцом өссөн онцлогтой жил байлаа.


Тухайлбал зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 2.3 сая тоннд хүрсэн нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 34.6%-аар, харин хилийн дундаж үнэ тонн тутамд 2,546 ам.долларт хүрсэн нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 30%-аар өссөн үзүүлэлт болов. Улмаар зэсийн нийт экспортын орлого 5.8 тэрбум ам.долларт хүрсэн нь 2024 онтой харьцуулахад даруй 75.0%-аар өссөн өндөр гүйцэтгэл юм.

Ийнхүү жилийн эцсийн гүйцэтгэлээр экспортын нийт орлогын 37.0%-ийг зэсийн баяжмал, харин 35.4%-ийг чулуун нүүрсний экспортын орлого бүрдүүлж, зэс тэргүүлэх түүхий эд боллоо.


Улмаар 2025 оны эцсийн гүйцэтгэлээр нийт экспортын орлого 15.7 тэрбум ам.долларт хүрч, өмнө оны мөн үеэс 0.5%-аар буурсан бол импортын зардал 11.3 тэрбум ам.долларт хүрч 2.6%-аар буурчээ. Улмаар худалдааны тэнцэл эерэг буюу 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнө оны мөн үеэс 5.3%-аар өссөн байна. (Эхний хагас жилд худалдааны ашиг өмнө оны мөн үетэй харьцуулахад 58.0%-ийн бууралттай байв)

Төлбөрийн тэнцэл, гадаад валютын албан нөөц, ханш


Урсгал данс, санхүүгийн данс




Төлбөрийн тэнцэл



Гадаад валютын албан нөөц



Ханш




Цаашлаад худалдааны ашиг нэмэгдсэнээр урсгал дансны алдагдал буурч, 2025 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 1.5 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнө оны мөн үеэс 19.3%-аар буурсан үзүүлэлт юм. (2024 оны эхний 11 сард урсгал дансны алдагдал 1.9 тэрбум ам.долларт хүрч байв) Урсгал дансны алдагдал буурч байгаа нь сүүлийн саруудад төлбөрийн тэнцэл ашигтай гарахад эерэг нөлөөлөл үзүүлж байгаа бол 2025 оны жилийн туршид санхүүгийн дансаар орж ирэх валютын урсгал өндөр байсан нь төлбөрийн тэнцэл хэт алдагдалд хүрэхгүй байх нөлөөллийг авчрав.

Монгол Улсын зээлжих зэрэглэл сүүлийн хоёр жилд дараалан өсөж, 2025 оны 10-р сард S&P байгууллагын үнэлгээгээр ВВ- түвшинд хүрснээр хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, санхүүгийн дансаар орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт болон бондын санхүүжилт нэмэгдэж буй.

Тухайлбал 2025 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр багцын хөрөнгө оруулалтаар дамжуулж, 820 сая ам.долларыг (голлох бондын санхүүжилт, 2025 оны 7-р сард Хөгжлийн банкны 500 сая ам.доллар, 2025 оны 9-р сард Төрийн банкны 200 сая ам.доллар), харин гадаадын шууд хөрөнгө оруулалтаар 2.2 тэрбум ам.долларыг амжилттай татсан байна. Улмаар санхүүгийн дансны ашиг 1.4 тэрбум ам.долларт хүрч, төлбөрийн тэнцэл 11-р сард хуримтлагдсан дүнгээр 66 сая ам.долларын ашигтай гарснаар ханш тогтвортой хадгалагдаж байгаа юм.

Мөн 2025 оны эцсийн гүйцэтгэлээр гадаад валютын албан нөөц 7 тэрбум ам.доллар буюу 7 сарын импортыг хангах хэмжээнд хүрлээ. Ингэснээр 12-р сарын төлбөрийн тэнцлийн ашиг өндөр гарах, ханш тогтвортой хадгалагдах дохио болсон ба 12-р сарын эцэст ханш 3,557 төгрөг/ам.долларт хүрсэн нь эхний хагас жилтэй харьцуулахад 0.6%-аар чангарсан үзүүлэлт боллоо.

Бодит эдийн засгийн өсөлт - 2015 оны суурьтай



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн өсөлт, салбарын оролцоогоор

Эдийн засгийн өсөлт, салбараар	Оролцоо	Үеү
ДНБ	5.9%	
ХАА	3.4%	33.8%
Уул уурхай	1.1%	8.2%
Боловсруулах	0.5%	7.7%
Цахилгаан, хий, уур, усан хангамж	0.2%	8.4%
Барилга	0.4%	22.2%
Бөөний, жижиглэн худалдаа	-0.6%	-5.1%
Тээвэр	-0.3%	-6.1%
Мэдээлэл холбоо	0.4%	10.0%
Үйлчилгээний бусад	1.2%	4.2%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-0.3%	-1.8%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Эдийн засгийн өсөлтийн хувьд нүүрсний экспортын орлого багассанаар уул уурхайн салбарын өсөлтийг хязгаарлаж, бусад уул уурхайгаас хамааралтай салбаруудад сөрөг нөлөөлөл үзүүлсэн ба эдийн засгийн өсөлтийг уул уурхайн бус салбарууд дэмжсэн жил болов.

Тухайлбал 2025 оны эхний 3 улирлын гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон эдийн засгийн өсөлт 5.9%-тай гарсан ба цаг уурын таатай нөхцөл байдлаас шалтгаалан өмнөх жилүүдийн зудын хүндрэлээс сэргэсэн хөдөө аж ахуйн салбар нийт өсөлтийн 3.4 нэгж хувийг дангаар бүрдүүлжээ. Статистикаас дурдахад хаваржилт тогтуун байж, мал төллөлт, бойжилт хэвийн үргэлжилсний үр дүнд бойжсон төлийн тоо толгой 21.6

саяд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 сая толгой малаар нэмэгдэн том малын зүй бус хорогдол 199 мянга болж, өмнөх оны мөн үеэс 9.1 сая толгой малаар буурсан байна.

Цаашлаад барилгын салбар 2025 онд орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай, Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын голлох нөлөөгөөр эдийн засгийн өсөлтийг 0.4 нэгж хувиар дэмжсэн байна. Харин уул уурхайн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтийн 1.1 нэгж хувийг бүрдүүлсэн ба тээвэр болон худалдаа зэрэг уул уурхайгаас хамааралтай бусад салбаруудын өсөлт саарч, нийт эдийн засгийн өсөлтөөс 0.9%-аар хойш татжээ.

Инфляц, мөнгөний бодлого



ХҮИ (100=2023), жилийн өсөлт
2024.1-р сараас 2025.12-р сар


Эх сурвалж: Монголбанк

Инфляцын нөхцөл байдлаас хамаарч, Монголбанкнаас мөнгөний бодлогын чиглэлээ тодорхойлдог. 2025 он гарснаас хойш олон улсын зах зээлд тодорхойгүй нөхцөл байдал давамгайлж, Монгол Улсад импортын барааны үнийн өсөлтөөр дамжин инфляц хөөрөгдөх эрсдэлийг нэмэгдүүлсэн билээ. Гадаад нөхцөл байдлаас гадна дотоодод төрийн зохицуулалттай бараа бүтээгдэхүүн буюу цахилгааны үнэ 2024 оны 11-р сараас нэмэгдэж, инфляцыг эрчимжүүлж эхэлсэн. Улмаар 2025 оны туршид инфляцын түвшин Монголбанкны зорилтот 6 +/-2 түвшний дээд интервалыг давсан хэвээр үргэлжилсэн ба жилийн эцэст цахилгааны үнийн өсөлт арилсан суурь нөлөөллөөр 7.5%-д хүрч, Монголбанкны зорилтот интервалд орлоо. (Өмнөх саруудад төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнийн өсөлтийн нөлөөлөл инфляцын 2 орчим нэгж хувийг бүрдүүлж байсан бол 12-р сард 0.5 нэгж хувийг бүрдүүлжээ)

Улмаар мөнгөний бодлого 2025 оны туршид хатуу төлөвт хадгалагдсан. Тухайлбал, Монголбанк 2025 оны 3-р сард бодлогын хүүг 10 хувиас 12 хувь болгож өсгөсөн бол банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг валют, төгрөгийн хувьд тус бүр 2 хувиар нэмэгдүүлж, 18 хувь болон 13 хувьд хүргэсэн. Үүнээс гадна банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 50 хувьд шинэчлэн тогтоосон.

Цаашлаад 2025 оны 12-р сард Мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргасан бол 2026 оны 1-р сард ээлжит бус хурлаар хэрэглээний зээлийн өр орлогын харьцааны дээд хязгаарыг 45%-д хүргэх, банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг 1 нэгж хувиар өсгөж, 14% (төгрөг), 19% (валют)-д хүргэх зэрэг олон талт мөнгөний хатуу бодлогын арга хэмжээг зарлалаа.

Банкнудын жигнэсэн дундаж хүү



Бодлогын хүү өнөөгийн өндөр түвшинд хадгалагдаж байгаа нөхцөл зээлийн хүү буурах орон харьцангуй бага байдаг. 2025 оны 12-р сарын байдлаар төгрөгийн зээл болон хадгаламжийн хүүгийн зөрүү 5.2% болж, 2024 оны эцсээс 0.2 нэгж хувиар нэмэгдсэн байна. Харин гадаад валютын зээл, хадгаламжийн хүүгийн зөрүү 6.2% байгаа бөгөөд өмнөх оноос 0.7 нэгж хувиар нэмэгдсэн байна.

2025 оны 12-р сарын байдлаар төгрөгийн зээлийн хүү өмнөх оны эцсээс 0.3 нэгж хувиар өсөж, 17.2% болсон бол төгрөгийн хадгаламжийн хүү 0.1 нэгж хувиар нэмэгдэж, 12.0% байна. Харин гадаад валютын хадгаламжийн хүү 0.5 нэгж хувиар буурч, 3.6%-д хүрсэн бол гадаад валютын зээлийн хүү 0.2 нэгж хувиар нэмэгдэж, 9.8% болж өсжээ.

Цаашдын төлөв

Хэдий 2025 оны жилийн эцсээр инфляц алгуур буурч байгаа ч Засгийн газраас 2026 онд хэрэгжүүлэх мега төслүүд, түүний санхүүжилт, багш, эмч нарын цалингийн өсөлт, экспортын орлого болон валютын ханшийн төлөв, цаг агаар болон нийлүүлэлтээс шалтгаалсан хүнсний үнийн өөрчлөлт зэрэг нь инфляцыг хөөрөгдүүлэх эрсдэлтэй хэвээр байна. (Монголбанкны Мөнгөний бодлогын тайлан, 2025 оны 12-р сар)

Улмаар мөнгөний хатуу бодлого 2026 оны дунд үе хүртэл үргэлжлэх төлөвтэй байгаа ба цаашид инфляцыг хөөрөгдүүлэх аливаа гэнэтийн хүчин зүйлс үүсэхгүй, нийлүүлэлтийн шинжтэй шок бий болохгүй (цаг агаарын нөхцөл байдал хэвийн, шатахууны нийлүүлэлт хэвийн үргэлжлэх гэх мэт) гэж үзвэл дунд хугацаанд буюу 2027 оноос инфляцын зорилтот түвшнийг 5 +/-2 түвшинд хүргэж бууруулах хүлээлттэй байна.

Банкны салбарын тойм

Банкны салбарын гүйцэтгэл

Үзүүлэлтүүд	Нэгж	2023	2024H1	2024	2025H1	2025	Өсөлт
Нийт актив	тэрбум ₮	57,070	62,185	71,238	72,600	85,426	25.10%
Нийт зээлийн үлдэгдэл	тэрбум ₮	27,152	33,259	36,781	42,224	43,752	19.0%
Хугацаа хэтэрсэн зээл	тэрбум ₮	1,264	1,227	1,271	1,756	1,493	17.5%
Чанаргүй зээл	тэрбум ₮	2,039	1,950	1,867	2,069	2,218	18.8%
Чанаргүй зээлийн харьцаа	%	7.5%	5.9%	5.1%	4.9%	5.1%	-0.6%
Иргэдийн зээл, ₮	тэрбум ₮	15,306	19,385	21,855	24,534	25,865	18.3%
Иргэдийн зээл, \$	тэрбум ₮	70	67	101	103	97	-3.8%
Хугацаа хэтэрсэн зээл, Иргэд, ₮	тэрбум ₮	264	331	485	693	685	41.3%
Хугацаа хэтэрсэн зээл, Иргэд, \$	тэрбум ₮	2	2	2	5	2	3.7%
Чанаргүй зээл, Иргэд, ₮	тэрбум ₮	479	488	554	739	891	60.8%
Чанаргүй зээл, Иргэд, \$	тэрбум ₮	24	23	23	25	25	9.8%
Чанаргүй зээлийн харьцаа, Иргэд, ₮	%	3.1%	2.5%	2.5%	3.0%	3.4%	35.9%
Чанаргүй зээлийн харьцаа, Иргэд, \$	%	34.2%	34.8%	22.7%	24.5%	25.9%	14.1%
Байгууллагын зээл, ₮	тэрбум ₮	9,905	11,281	11,910	14,358	14,850	24.7%
Байгууллагын зээл, \$	тэрбум ₮	1,560	1,900	1,855	2,185	2,346	26.5%
Хугацаа хэтэрсэн зээл, Байгууллага, ₮	тэрбум ₮	618	554	563	842	559	-0.8%
Хугацаа хэтэрсэн зээл, Байгууллага, \$	тэрбум ₮	379	338	220	214	246	11.7%
Чанаргүй зээл, Байгууллага, ₮	тэрбум ₮	1363	1283	1160	1188	1204	3.7%
Чанаргүй зээл, Байгууллага, \$	тэрбум ₮	163	147	121	109	89	-26.0%
Чанаргүй зээлийн харьцаа, Байгууллага, ₮	%	13.8%	11.4%	9.7%	8.3%	8.1%	-16.8%
Чанаргүй зээлийн харьцаа, Байгууллага, \$	%	10.4%	7.8%	6.5%	5.0%	3.8%	-41.5%
Нийт харилцах, хадгаламж	тэрбум ₮	34,250	37,800	39,563	39,669	43,273	9.4%
Харилцах данс, ₮	тэрбум ₮	8,578	10,350	10,326	9,306	9,643	-6.6%
Харилцах данс, \$	тэрбум ₮	4,561	4,195	3,645	3,447	3,846	5.5%
Хадгаламж, ₮	тэрбум ₮	16,344	18,841	20,955	21,697	24,555	17.2%
Хадгаламж, \$	тэрбум ₮	4,766	4,415	4,637	5,219	5,230	12.8%
Өөрийн хөрөнгө	тэрбум ₮	6,182	6,523	7,339	7,605	8,455	15.2%
Нийт пассив	тэрбум ₮	50,887	55,661	63,899	64,994	76,971	20.5%


Эх сурвалж: Монголбанк

Нийт актив ба зээл

Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт 2025 оны эцэст 47.1 их наяд төгрөг болж, өмнөх оноос 8.7 хувиар буюу 3.8 их наядар төгрөгөөр өслөө.

Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт



Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө
 Валютын харилцах
 Валютын хадгаламж
 Төгрөгийн хадгаламж
 Төгрөгийн харилцах
 Мөнгө M2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.7%-аар өсөхөд эх үүсвэр (пассив) талаас иргэд болон байгууллагын хадгаламж өссөн нь голлон нөлөөлсөн бол төгрөг болон гадаад валютын харилцах өмнөх оноос буурсан нь сөргөөр нөлөөлжээ.

Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 9.3 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 1.8 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -1.1 нэгж хувийг төгрөгийн харилцах, -1.3 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлж байна. Төгрөгийн хадгаламж 2025 оны эцэст 26.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.0 их наяд төгрөг буюу 18.3 хувиар өссөн байна. Төгрөгийн хадгаламжийн 82.6 хувийг иргэдийн хадгаламж, 17.2 хувийг аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж бүрдүүлж байна. Түүнчлэн валютын хадгаламж 5.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 776.3 тэрбум төгрөгөөр буюу 16%-аар өсжээ. Харин төгрөгийн харилцах өмнөх оноос 4.5%-аар, валютын харилцах 12%-аар тус тус буурсан байна.

Мөнгөний нийлүүлэлтийн байршуулалт (актив) талаас дотоод цэвэр актив 38.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 11%-аар өссөн нь мөнгөний нийлүүлэлт өсөхөд голлон нөлөөлжээ. Мөнгөний хатуу бодлого үргэлжилсэн хэвээр байгаа ч зээлийн өсөлт өндөр хэвээр хадгалагдсан нь дотоод цэвэр активыг нэмэгдүүлсэн байна.


2025 оны эхэнд БНХАУ-ын нүүрсний эрэлт буурч, хэт нийлүүлэлтийн улмаас нүүрсний үнийн бууралт үргэлжилсэнтэй холбоотойгоор энэ оны эхний хагаст манай улсын нүүрсний экспортын орлого 45%-аар буураад байсан бол оны сүүл хагаст харьцангуй сэргэсэн нь төлбөрийн тэнцэл ашигтай гарахад нөлөөлсөн. Улмаар гадаад цэвэр актив өмнөх оны түвшинд хадгалагдаж, мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтөд үзүүлсэн нөлөө маш бага түвшинд буюу 0.1% байна.

Банкны салбарын зээл

2023 оны эдийн засгийн идэвхжилийн дараагаар зээлийн өсөлт тасралтгүй үргэлжлэн 2023 онд 23%, 2024 онд 35%, 2025 оны эцэст 18.9%-аар тус тус өслөө.

Улмаар 2023 онд 27.4 их наяд төгрөг байсан зээлийн үлдэгдэл 2025 оны эцэст 44 их наяд төгрөг болж, 16.6 их наяд төгрөгөөр буюу 60%-аар өсжээ.

Зээлийн үлдэгдэл ба жилийн өсөлт



(их наяд төгрөг) ■ Зээлийн үлдэгдэл ■ Жилийн өсөлт

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Аж ахуй, нэгж байгууллагуудын зээл болон иргэдийн зээлийн өсөлт тогтвортой байгаа бөгөөд 2024 оны өндөр өсөлтийн дараагаар нийт зээлийн өсөлт 2025 оны эхний хагас жилд саараад байсан бол сүүлийн саруудад эргэн эрчимжжээ. Түүнчлэн эдийн засгийн идэвхжилийг дагаад эдийн засгийн салбарууд дахь зээлийн өсөлт тогтвортой байгаа нь зээлийн өсөлтийг дэмжиж байна. Харин сүүлийн жилүүдэд их хэмжээгээр тэлсэн төсвийн тэлэлттэй холбоотойгоор цалин, тэтгэврийн өсөлтөөс үүдэн иргэдийн орлого нэмэгдэж, хэрэглээг өдөөх замаар хэрэглээний зээлийн өсөлтийг хурдтай нэмэгдүүлж байна.

Нийт зээлийн хувьд хугацаа хэтэрсэн, анхаарал хандуулах шаардлагатай зээлийн үлдэгдэл 2025 онд 1.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 17.5%-аар өссөн

бол чанаргүй зээлийн хэмжээ 2.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 18.9%-аар тус бүр өссөн байна. Харин чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 5.1% болж өмнөх оны түвшинд байна.

2026 оны 1-р сард Мөнгөний бодлогын хорооны ээлжит бус хурлаар зээлийн өсөлтийн зохистой түвшнийг хадгалах, санхүүгийн системийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлийн өсөлтийг хязгаарлах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 45 хувь болгон шинэчлэн тогтоох, банкнуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг нэмэгдүүлэх зэрэг багтаж байна. Банкнуудын заавал байлгах нөөцийн хувийг нэмэгдүүлэхэд банкнуудын зээлд гаргах боломжтой эх үүсвэр багасаж, зээлийн нөхцөл чангарснаар зээлийн өсөлт хязгаарлагддаг.

Иргэд ба байгууллагын зээл, жилийн өсөлт




Нийт зээлийн үлдэгдлийн бүрэлдэхүүнд иргэдийн зээл 26.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 25.1%-аар өссөн бол байгууллагын зээл 17.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 18.2%-аар өссөн байна. Мөн нийт зээлийн 59 хувийг иргэдийн зээл, 39 хувийг байгууллагын зээл бүрдүүлжээ. Иргэдэд олгосон зээлийн 49% нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх төрлийн зээл байгаа бол үлдсэн 51% нь хэрэглээний зээл байна. Харин анхаарах шаардлагатай хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оноос 41.3%-аар өсөж, 700 тэрбум төгрөгт хүрсэн бол чанаргүй зээлийн хэмжээ 925 тэрбум төгрөгт хүрч, 58.5%-аар нэмэгджээ. Харин байгууллагын зээлийн чанаргүй зээлийн хэмжээ 1.3 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 0.9%-аар өсжээ. Ийнхүү иргэдийн орлого нэмэгдэхийн хэрээр хэрэглээний зээлийн өсөлт эрчимжиж байгаа ч нөгөө талд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өсөлт өндөр байгаа нь зээлийн эрсдэл нэмэгдэж байгааг харуулж байна.

Иргэдийн зээлийн үлдэгдэл (ангиллаар)

Иргэдийн зээлийн үлдэгдэл 2025 оны эцэст 12.9 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.5 их наяд төгрөгөөр буюу 11.8%-аар өсжээ. Иргэдийн хэрэглээний зээлийн 71%-ийг цалин, тэтгэврийн зээл бүрдүүлж байгаа бол 13.3%-ийг хадгаламж барьцаалсан зээл, 8.6%-ийг малчны зээл, 5.6%-ийг автомашин ба өрхийн хэрэглээ, 1.6%-ийг картын зээл бүрдүүлсэн байна.

Зээлийн бүрэлдэхүүнийг дэлгэрэнгүй авч үзвэл цалин, тэтгэврийн зээл өмнөх оноос 17.8%-аар, хадгаламж барьцаалсан зээл 19.3%-аар тус тус өссөн байна. Харин Картын зээл 35.7%-аар өсөж, 213 тэрбум төгрөг болсон бол автомашин ба өрхийн хэрэглээний зээл 14.0%-аар өсөж, 738 тэрбум төгрөг болжээ. Малчны зээл 2025 оны эцэст 1.1 их наяд төгрөг байгаа бөгөөд энэ нь өмнөх оны эцсээс 17.3%-аар буурсан байна.

Иргэдийн хэрэглээний зээлийн ангилал




Байгууллагад олгосон шинэ зээл (салбараар)

2025 онд нийт 30 их наяд төгрөгийн зээл аж ахуй, нэгж байгууллагуудад шинээр олгосон бөгөөд энэ нь өмнөх оноос 25.9%-аар өссөн байна. Нийт шинээр олгосон зээлийн 50% нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 12.9% нь уул уурхай, олборлолтын салбар, 10.4% нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 10.2% нь барилгын салбарт тус тус олгогдсон байна.

2025 онд бөөний худалдааны салбарт нийт 15.0 их наяд төгрөгийн зээлийг шинээр олгосон бөгөөд энэ нь өмнөх

оноос 19.4%-аар өссөн байна. Уул уурхай, олборлолтын салбарт олгогдсон зээл өмнөх оноос 21.2%-аар өсөж, 3.9 их наяд төгрөг болсон бол барилгын салбарт олгогдсон зээл 27.1%-аар өсөж, 3.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Харин өнгөрсөн онд 3.7%-аар буураад байсан боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгогдсон зээл энэ онд 32.8%-аар өсөж, 3.1 их наяд төгрөг болсон байна. Үл хөдлөх хөрөнгийн салбар болон хөдөө аж ахуйн салбарын зээл өмнөх оноос тус тус 42.9% болон 54.1%-аар өсжээ.


Байгууллагуудын зээл (салбараар)



2025 онд эдийн засгийн өсөлт харьцангуй тогтвортой байснаар зээлийн өсөлт эдийн засгийн салбаруудад өндөр түвшинд хадгалагдлаа. Зээлийн өсөлт хэт өндөр байх нь зээлийн чанаргүй хувь нэмэгдэж, аж ахуй нэгж байгууллагад өрийн дарамт нэмэгдэх эрсдэлийг

бий болгох тул Монголбанкнаас зээлийн өсөлтийг хязгаарлах бодлогын шийдвэрүүдийг гаргаад байна. Тиймээс 2026 онд зээлийн өсөлт саарах хүлээлттэй байна.

Чанаргүй зээлийн хэмжээ болон хувь



2025 оны байдлаар нийт банкны салбарын зээлийн үлдэгдлийн 3.4% буюу 1.5 их наяд төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 5.1% буюу 2.2 их наяд төгрөгийг чанаргүй зээл бүрдүүлж байна.

салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оноос 1.2%-аар өссөн ч чанаргүй зээлийн хувь 11.3% болж, өмнөх оноос 3.7 нэгж хувиар буурсан байна. Боловсруулах салбарын чанаргүй зээл өмнөх оноос 2.6%-аар буурч, чанаргүй зээлийн хувь 12.7% болж өмнөх оноос 3.6 нэгж хувиар саарсан байна. Харин уул уурхайн салбарын идэвхжилийг дагаад 2025 онд тус салбарын чанаргүй зээл 2023 оноос 37.6%-аар, 2024 оноос 6.2%-аар тус тус буурч, 218 тэрбум төгрөгт хүрчээ. Улмаар чанаргүй зээлийн хувь 2025 онд уул уурхайн салбарт 8.6%-тай байна.

2025 онд чанаргүй зээлийн хувь салбаруудад тогтвортой буурсан байна. Тухайлбал, ХАА салбар дахь чанаргүй зээлийн хэмжээ 2025 оны эцэст 80 тэрбум төгрөг байгаа бөгөөд чанаргүй зээлийн хувь 2023 онд 15.9% байсан бол 2025 онд 4.8% болж сайжирсан байна. Түүнчлэн бөөний худалдаа болон үл хөдлөх хөрөнгийн салбарын чанаргүй зээлийн хувь 2025 оны эцэст тус бүр 3.0% ба 1.5% байгаа нь хамгийн бага үзүүлэлт байна. Барилгын

Хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээлэл



Голомт банкны Хөрөнгө оруулагчидтай харилцах чиг үүрэг нь банкны хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид болон санхүүгийн зах зээлийн оролцогч талуудад хүргэх мэдээллийн ил тод, үнэн зөв байдлыг хангах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг. Цаашлаад банкны стратеги, санхүүгийн гүйцэтгэл, бизнесийн төлөв байдлын талаарх мэдээллийг цаг тухайд нь хүргэж, зах зээлийн оролцогч талуудын итгэлийг бэхжүүлэхийн зэрэгцээ банк болон хөрөнгө оруулагчдын хооронд тогтвортой, харилцан итгэлцэлд суурилсан хоёр талын харилцааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хөрөнгө оруулагчидтай харилцах чиг үүргийн хүрээнд зах зээл болон хөрөнгө оруулагчдын хүлээлт, санал хүсэлтийг банкны удирдлагад уламжилж, стратегийн шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх замаар банкны урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд Голомт банк хөрөнгө оруулагчидтай харилцах чиг үүргийн хүрээнд улирлын санхүүгийн тайлангийн 4 удаагийн нээлттэй танилцуулгыг зохион байгуулж, томоохон болон жижиг хөрөнгө

оруулагчидтай нийт 110 удаагийн уулзалт хийлээ. Эдгээр уулзалт, танилцуулгыг танхимын болон онлайн хосолсон хэлбэрээр зохион байгуулж, банкны удирдлагууд банкны урт хугацааны стратеги, санхүүгийн голлох үзүүлэлтүүд, үйл ажиллагааны чиг хандлагыг танилцуулж, хөрөнгө оруулагчид болон шинжээчдийн санал хүсэлт, дүгнэлтийг хүлээн авсан юм.

Банкны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор Хөрөнгө оруулагчидтай харилцах жилийн календарийг нийтэлж, үнэт цаасны компаниудын шинжээчдэд зориулсан Analyst Day арга хэмжээг зохион байгуулсан. Мөн удирдлагын түвшний онлайн уулзалт болон асуулт, хариултын арга хэмжээнүүдийг зохион байгуулж, сар бүрийн мэдээллийн товхимол, банкны салбарын эрсдэл, өнөөгийн болон ирээдүйн төлөв байдлыг санхүүгийн үзүүлэлтүүдтэй хамтатган тайлбарласан "Удирдлагын хэлэлцүүлэг ба шинжилгээ" (Management Discussion & Analysis) мэдээллийг хөрөнгө оруулагчдад тогтмол хүргэж ажиллалаа.

Түүнчлэн банкны стратеги, гүйцэтгэл, ирээдүйн төлөвийн талаарх гол агуулгыг хөрөнгө оруулагчдад

ойлгомжтой, цогц байдлаар хүргэх зорилгоор Гүйцэтгэх захирлын захидал (CEO Letter)-ыг жилийн тайланд багтаан танилцуулж, банкны удирдлагын түвшний байр суурь болон стратегийн чиглэлийг хөрөнгө оруулагчдад нээлттэй хүргэж ажилласан.

Тайлант онд Банк нь мэдээлэл тайлагнал, ил тод байдлын шаардлагыг олон улсын стандарттай нийцүүлэхэд онцгойлон анхаарч ажилласан. Үүний хүрээнд хөрөнгө оруулагчидтай харилцах үйл ажиллагааг мэргэшүүлэх, олон улсын сайн туршлагад нийцүүлэх зорилгоор холбогдох нэгжийн ажилтнуудыг хамруулсан сургалт, туршлага солилцох мэргэшүүлэх workshop-ууд зохион байгуулж, хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээллийн чанар, агуулга, тайлагналын арга барилыг сайжруулахад анхаарч ажиллав.

Үүний зэрэгцээ “Монголын хөрөнгийн зах зээл: Сонин хачин” цахим группийн 2,700 гаруй арилжаа эрхлэгч, жижиг хувьцаа эзэмшигчдийг хамруулсан улирал бүрийн санхүүгийн тайлангийн танилцуулах уулзалтуудыг 2025 онд зохион байгууллаа.

Хөрөнгө оруулагчдын харилцааг бэхжүүлэх чиглэлд Нью-Йорк, Лондон, Хонг Конг, Сингапур, Токио хотуудад Монгол Улсын эдийн засаг болон банк санхүүгийн салбарыг сурталчлах хөрөнгө оруулагчдын уулзалт, арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцож, хамтран зохион байгууллаа. Эдгээр арга хэмжээнд 10 гаруй улс орны давхардсан тоогоор 370 гаруй байгууллагын төлөөлөл, хөрөнгө оруулагчид оролцсон бөгөөд банкны үйл ажиллагаа төдийгүй Монгол Улсын эдийн засгийн онцлог, хувийн хэвшлийн боломжуудыг олон улсын хөрөнгө оруулагчдад танилцуулах боломж бүрдлээ.



Хувьцааны ханш

Дээд	1,281	915	1,244	1,350
Доод	1,171	904	1,240	1,285
Хаалт	1,274	907	1,242	1,332
Дундаж	1,172	954	1,008	1,108
	2022	2023	2024	2025



Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

Ногдол ашгийн өгөөж /%/	4%	10%	8%	6%
P/E харьцаа	7.8	3.5	2.4	3.3
	2022	2023	2024	2025

Ногдол ашгийн мэдээлэл

Тайлант он	ТУЗ-ийн шийдвэр гаргасан огноо	Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг	Нийт ногдол ашиг	Бүртгэлийн өдөр	Олгосон өдөр
2022	2023.02.17	50 төгрөг	40.4 тэрбум төгрөг	2023.04.04	2023.04.20
2023	2024.02.14	90 төгрөг	72.8 тэрбум төгрөг	2024.03.25	2024.04.25
2024	2025.02.17	100 төгрөг	80.8 тэрбум төгрөг	2025.03.26	2025.04.25
2025	2026.02.13	80 төгрөг	64.7 тэрбум төгрөг	2026.03.16	2026.04.27

Хөрөнгө оруулагчдын календарь

2026

2026.01.19

Улирлын санхүүгийн
тайлан нийтлэх

2026.02.05

Earnings call зохион
байгуулах

2026.02.13

Ногдол ашгийн тухай шийдвэр зарлах хугацаа

2026.03.16

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
товыг зарлах хугацаа

2026.03.31

Жилийн эцсийн
аудитлагдсан санхүүгийн
тайлан нийтлэх

2026.03.31

Гүйцэтгэх захирлын
хувьцаа эзэмшигчдэд
хүргэх захидал

2026.04.03

Удирдлагын хэлэлцүүлэг
ба дүн шинжилгээний
тайлан

2026.04.06

Банкны жилийн тайлан
нийтлэх

2026.04.06

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах хугацаа

2026.04.20

Улирлын санхүүгийн
тайлан нийтлэх

2026.04.24

Earnings call зохион
байгуулах

2026.04.30

БОНЗ-ын тайлан
нийтлэх

2026.04.30

Жилийн үйл
ажиллагааны
тайлан - МХБ

2026.07.20

Хагас жилийн
санхүүгийн тайлан
нийтлэх

2026.07.20

Хагас жилийн үйл
ажиллагааны тайлан
нийтлэх - МХБ

2026.07.24

Earnings call зохион
байгуулах

2026.09.21

Хянан нягталсан хагас
жилийн хураангуй
санхүүгийн тайлан

2026.10.19

Улирлын санхүүгийн
тайлан нийтлэх

2026.10.23

Earnings call зохион
байгуулах